



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Удирдамж, журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай туулийн 36.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний удирдамж”- ийг нэгдүгээр, “Нөхөн үржихүйн эм хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг хангах журам”-ыг хоёрдугаар, “Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журам”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Удирдамж, журмыг мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Төгсдэлгэр), Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн), Эм эмнэлгийн хэрэгслийн хэлтэс (Ч.Мөнхдэлгэр), Эх хүүхдийн эрүүл мэндийн Үндэсний төв (Ш.Энхтөр)-д тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.ХҮРЭЛБААТАР

080076

## Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний удирдамж

Гэр бүл төлөвлөлт (ГБТ) нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэн чухал хэсэг бөгөөд хосууд хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ мэддэг, мэдээлэлтэйгээр сонголт хийх, шийдэх, нөхөн үржихүйн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, жирэмслэхээс хамгаалах аргын хэрэглээг багтаасан тусламж үйлчилгээ юм.

ГБТ нь эхийн өвчлөл, эндэгдлийг бууруулахад хамгийн үр нөлөөтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай болох нь батлагдсан арга хэмжээ юм. Хэрэв жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн (ЖСАХ) хангамж, хүртээмж, хэрэглээг зохистой түвшинд хүргэж чадвал эхийн эндэгдлийг 40 хувиар бууруулах боломжтой гэж ДЭМБ үзэж байна.

Манай улсын хувьд 1990-ээд оны эхээр хүн амын дөнгөж 10% нь ГБТ-ийн талаар мэдлэгтэй, жирэмслэхээс хамгаалах аргын хэрэглээ 10-15% байсан бол 20 жилийн дараа мэдлэг 98%, жирэмслэхээс хамгаалах арга нь ихэнхи эмэгтэйчүүдийн амьдралын чухал хэрэгцээ болсон байна. Нийт эмэгтэйчүүдийн 45 хувь, гэр бүлтэй эмэгтэйчүүдийн 55 хувь нь жирэмслэхээс хамгаалах ямар нэгэн арга хэрэглэж байгаа бөгөөд уг аргыг хэрэглэж буй эмэгтэйчүүдийн 66 хувь нь ямар нэгэн зардал гаргахгүйгээр уг аргыг хэрэглэж байна<sup>1</sup>. Гэвч гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээ нэмэгдсээр байгааг судалгаанууд харуулсаар байна.

### ГБТ-ийн үр дүнтэй үйлчилгээний шинж чанар

- 1) Зөвөлгөө өгөх
- 2) Хялбар авч болох, хүртээмжтэй, хүрэлцээтэй, олон төрлийн аргуудыг санал болгох
- 3) Нотолгоонд суурилсан байх
- 4) Тусламж үйлчилгээний чанар нь сайн байх
- 5) Үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангах
- 6) Эрэгтэйчүүдийн оролцоог хангах
- 7) Зан үйлийг өөрчлөх харилцаа
- 8) Тогтвортой хангамж

<sup>1</sup> НҮЭМ-ийн судалгаа, 2008, хуудас 25-27

### Зөвлөгөө өгөх

Зөвлөгөө өгөх нь ГБТ-ийн үйлчилгээний үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм.

Үр дүнтэй зөвлөгөө өгөх зарчим. **GATHER: Greet- Мэндлэх (M), Ask- Асуух (A), Tell- Хэлж өгөх (X), Explain- Тайлбарлах (T), Return- Буцаж ирүүлэх (B)**

Зөвлөгөө өгөх үе шат:

Зарчим	Үе шат	Анхаарах асуудлууд
<b>Мэндлэх</b>	Нэрээ хэлж үйлчлүүлэгчтэй мэндэлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлчлүүлэгчийг хүндэтгэж, нөхөрсөг уур амьсгал бий болгоно.</li> <li>✓ Хувийн нууцыг нь хадгалахаа түүнд батлан хэлнэ.</li> </ul>
<b>Асуух</b>	ГБТ – ийн талаар үйлчлүүлэгчийн хүсч буй зүйлийн талаар ярилцана.	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлчлүүлэгчээс төрөлт хоорондын зайг зохицуулах, эсвэл жирэмсэлтийг хязгаарлахыг хүсч байгаа эсэхийг тодруулна.</li> <li>✓ Эмэгтэй болон түүний бэлгийн хавьтагчид БЗДХ авах эрсдэл байгаа эсэхийг тодруулна.</li> <li>✓ Эмэгтэй жирэмсэн биш гэдгийг баталгаажуулна.</li> </ul>
<b>Хэлж өгөх</b>	ГБТ-ийн талаархи ерөнхий мэдээллийг ( аргууд, хэрэглэх зарчим, давуу болон сул тал, гаж нөлөө, үр дүн) үйлчлүүлэгчид өгнө.	<ul style="list-style-type: none"> <li>✓ Жирэмслэхээс хамгаалах түр ба байнгын аргуудын ялгааг эмэгтэй сайн ойлгосон байна.</li> <li>✓ Тодорхой нэг эсвэл хэд хэдэн арга хэрэглэхийг дэмжих эсвэл эсэргүүцэх хандлага байгаа эсэхийг ажиглана.</li> </ul>
<b>Тайлбарлах</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Үйлчлүүлэгчид нөхцөл байдалд нь хамгийн тохиромжтой жирэмслэхээс хамгаалах аргыг сонгоход нь тусална.</li> <li>2. Эм хэрэглэх зааврыг үйлчлүүлэгчид тодорхой тайлбарлаж өгнө.</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Үйлчлүүлэгчийн өмнөөс шийдвэр бүү гарга – хэрэглэх аргаа өөрөө сонгох боломжийг түүнд олго.</li> <li>✓ Үйлчлүүлэгчид уг арга тохирох эсэхийг эрүүл мэндийн үзлэг хийж баталгаажуулна.</li> <li>✓ Хэрэглэх зааврыг бүхэлд нь үйлчлүүлэгчээр давтуулж хэлүүлнэ.</li> <li>✓ Үйлчлүүлэгчээс асуух зүйл байгаа эсэхийг тодруулж, түүний санал бодлыг хуваалцаж ярилцана.</li> </ul>

<b>Буцаж ирэх</b>	Ямар нэг асуудал үүссэн тохиолдолд хүссэн үедээ эргэн ирж үзүүлж болохыг түүнд зөвлөнө.	✓ Үйлчлүүлэгчийг эргэн хянах үзлэгийг төлөвлөх шаардлагагүй. ✓ Хүссэн үедээ өөр арга сонгон, хэрэглэж болохыг хэлнэ.
-------------------	---	---

**Эмэгтэйг жирэмсэн биш гэдгийг батлах шинжүүд**

Түүний биеийн юм ирээд долоо хоног хэтрээгүй байгаа.

**ЭСВЭЛ**

Эмэгтэй сүүлийн биений юм, үр хөндөлт, төрөлтөөс хойш үтрээгээр бэлгийн харьцаанд ороогүй гэж мэдээлсэн.

**ЭСВЭЛ**

Эмэгтэй гэр бүл төлөвлөлтийн найдвартай аргыг зөв хэрэглэдэг.

**ЭСВЭЛ**

Эмэгтэй төрөөд 4 долоо хоног өнгөрөөгүй байгаа

**ЭСВЭЛ**

Зулбалт, үр хөндүүлснээс хойш 7 хоног болоогүй байгаа

**ЭСВЭЛ**

Хүүхдээ дан хөхөөр хооллодог, төрснөөс хойш зургаан сарын хугацаа өнгөрөөгүй, биений юм ирээгүй байгаа.

## НЭГ: ЖИРЭМСЛЭХЭЭС ХАМГААЛАХ ДААВРЫН ХАВСАРСАН ЭМ

Орчин үед хэрэглэгдэж буй жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эм (ДХЭ) эмэгтэй хүний биед үүсдэг байгалийн даавар эстроген болон прогестерон төстэй даавруудыг бага тунгаар агуулсан байдаг. Эдгээр эмүүд нь зонхилон нэг савлагаанд нийт 28 ширхэг хоёр төрлийн шахмал хэлбэрээр байдаг. Үүний 21 ширхэг нь даавар агуулсан идэвхтэй эм, үлдсэн 7 ширхэг нь өөр өнгөтэй, даавар агуулаагүй байна. Манай оронд Ригевидон, Микрогинон зэрэг эмийг зонхилон хэрэглэж байна.

**ДХЭ-ийн үйлчлэх зарчим:** ДХЭ нь өндгөн эс боловсорч, өндгөвчнөөс гарах үйл ажиллагааг дарангуйлна. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлснээр үрийн шингэн умайн хүзүүгээр нэвтрэхэд саад учруулдаг. ДХЭ нэгэнт үүссэн үр хөврөлийн хөгжилтийг зогсоох нөлөө үзүүлэхгүй.

**ДХЭ-ийн үр дүн:** Тогтмол зөв хэрэглэсэн тохиолдолд өндөр үр дүнтэй. 100 эмэгтэйн зөвхөн 8 нь жирэмслэх боломжтой.

### ДХЭ-ийн давуу тал:

- ✓ Өсвөр насны охидоос эхлээд цэвэршилтийн өмнөх насны эмэгтэйчүүд хүртэлх насны хүмүүс хэрэглэх боломжтой.
- ✓ Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй.
- ✓ Биений юм тогтмол, бага хэмжээтэй, цөөн хоног ирнэ. Биений юм ирэх үеийн өвдөлт багасна.
- ✓ Хүссэн үедээ эм хэрэглэхийг зогсоож болно. Эмийг зогсоосон даруйд жирэмслэх чадвар сэргэнэ.
- ✓ Төмөр дутагдлын цус багадалтаас сэргийлнэ.
- ✓ Умайн гаднах жирэмсэн, умайн салст, өндгөвчийн хорт хавдар, өндгөвчийн уйланхай, бага аарцгийн хөндийн эрхтэний үрэвсэлт өвчин, хөхний хоргүй хавдар зэргээс урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлнэ.

### ДХЭ-ийн сул тал:

- ▶ Хэрэглэсэн эхний гурван сард ноцтой бус зарим гаж нөлөөг үүсгэж болох ба эдгээр нь эмийг үргэлжлүүлэн хэрэглэхэд аяндаа арилна.
- ▶ Дотор эвгүйрхэх, хөхөөр хөндүүрлэх.
- ▶ Биений юмны мөчлөгийн хооронд ялангуяа эмэгтэй эмээ уухаа мартсан эсвэл оройтож уусан тохиолдолд цус алдах, цусархаг ялгадас гарах.
- ▶ Толгой өвдөх.
- ▶ Биеийн жин бага зэрэг нэмэгдэх.
- ▶ Биений юмгүйдэл үүсэх.
- ▶ Өдөр бүр тогтмол цагт уугаагүй тохиолдолд үр дүн буурна. Эмийг өдөр бүр марталгүй уух нь зарим эмэгтэйд бэрхшээлтэй санагдаж болно.
- ▶ Маш ховор тохиолдолд тархинд цус харвах, хөлний гүний хураагуур судасны бүлэнт бөглөрөл, зүрхний шигдээс үүсэх шалтгаан болно. Эдгээр гаж нөлөө үүсэх эрсдэл нь артерийн даралт ихэсдэг, 35 ба түүнээс дээш насны, өдөрт 20-иос олон ширхэг тамхи татдаг эмэгтэйд илүүтэй тохиолддог.

- ▶ Хөхний сүүний чанар, гарцад нөлөөлдөг учир хөхүүл эхчүүд төрсний дараах эхний зургаан сард хэрэглэхэд тохиромжгүй.
- ▶ БЗДХ/ХДХВ/ ДОХ-ын халдвараас хамгаалахгүй.

**ДХЭ-ийг олгоход шаардагдах багаж, төхөөрөмж:** ДХЭ-ийг аюулгүй байдлаар үйлчлүүлэгчид олгоход зориулагдсан эм, үзлэгийн ор бүхий зөвлөгөө өгөх, үзлэг хийх өрөө, цусны даралт хэмжигч, чагнуур шаардагдлагатай. Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах боломжоор хангагдсан байна.

**ДХЭ-ийг хэрэглэх нь дараах эмэгтэйчүүдэд илүү тохиромжтой:**

1. Жирэмслэхээс найдвартай хамгаалах түр хугацааны аргыг хэрэглэхийг хүсч буй эмэгтэй.
2. Биений юм нь тогтмол бус, их хэмжээгээр, удаан хугацаагаар үргэлжилдэг эмэгтэй.
3. Биений юм нь өвдөлттэй ирдэг эмэгтэй. ДХЭ нь цус алдалтыг багасгаж, өвдөлтийг бууруулдаг.
4. Умайн хүзүүний шархлаа, урагдал, урвалттай эмэгтэй.
5. Бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчтэй эмэгтэй. (Эдгээр эмэгтэйчүүдэд бэлгийн замаар дамжих халдвар авах эрсдлийг бууруулахын тулд бэлгэвчийг хавсран хэрэглэхийг зөвлөнө.)
6. Умайн холбогч эдийн хоргүй хавдар болон эндомиозтой эмэгтэй.

**ДХЭ-ийг хэрэглэхэд тохиромжгүй нөхцөл:**

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Жирэмсэн	ДХЭ-ийг жирэмсэн үед санамсаргүй хэрэглэсэн тохиолдолд эх болон урагт гаж нөлөө үзүүлдэггүй нь тогтоогдсон байна.
Төрсний дараа	Төрсний дараах эхний 3 сард хэрэглэдэггүй.
Хөхүүл эмэгтэй	Хөхүүл эх төрсний дараах эхний 6 сард хэрэглэх шаардлагагүй.
Тамхи татдаг	Эрүүл мэндэд муу нөлөө үзүүлдэг учир тамхинаас гарахыг зөвлөнө.
Артерийн даралт ихэсдэг	Артерийн даралт нь 140/90-аас доош эмэгтэй хэрэглэж болно, дээш бол хэрэглэхгүй.
Гүний хураагуур, уушгины судасны бүлэн	Гүний хураагуур судас, уушгины судсанд бүлэн үүсч байсан өгүүлэмжтэй эмэгтэй хэрэглэж болохгүй.
Удаан хугацааны хөдөлгөөнгүй байдал үүсгэх мэс засал	7 ба түүнээс олон хоногоор хөдөлгөөнгүй байх шаардлагатай мэс засалд орох гэж буй эмэгтэй хэрэглэж болохгүй. Хагалгаанаас 1-2 долоо хоногийн өмнө эм уухыг зогсоох шаардлагатай. Өвчтөний бие эргээд хэвийн хөдөлгөөнд орсны дараа хэрэглэвэл аюулгүй. ДХЭ хэрэглэхийг зогсоосон хугацаанд эмэгтэй жирэмслэх боломжтой байх тул орлуулах өөр аргыг хэрэглэх ёстой.
Зүрх, судасны эмгэг	Зүрхний шигдээс өвчтэй эмэгтэй хэрэглэж болохгүй.
Холгойн талласан өвдөлт (мигрень)	Хөнгөн хэлбэрийн мигреньтэй эмэгтэй хэрэглэж болно. Харин тодорхой байршил бүхий мэдрэлийн шинж тэмдгүүд

	илэрч, дахилт өгдөг хүнд хэлбэрийн мигреньтэй эмэгтэй хэрэглэж болохгүй.
Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт	Шалтгааныг тодруулна.
Хөхний хорт хавдар	Хөхний хорт хавдартай нь оношлогдсон бол хэрэглэж болохгүй.
Цөсний хүүдийн эмгэг	Цөсний хүүдийн эмгэгтэй нь тогтоогдсон бол хэрэглэж болохгүй.
Элэгний эмгэг	Элэгний хатуурал, хавдар, вирүсийн гаралтай элэгний хурц үрэвсэлтэй эмэгтэй хэрэглэж болохгүй.
Эмүүдийн харилцан үйлчлэл	Рифампицин, Гризеофульвин зэрэг антибиотууд болон Фенитоин, карбамизепин, барбитуратууд, Примадон зэрэг таталтын эсрэг эмүүд элэгний энзимуудыг идэвхжүүлж ДХЭ-ийн үр нөлөөг бууруулдаг тул хамт хэрэглэхгүй.

### ДХЭ-ийг хэрэглэж эхлэх нөхцөл, хугацаа:

Эмэгтэйн биеийн байдал	Хугацаа
Биений юмны мөчлөг	Биений юмны тогтмол мөчлөгтэй үед биений юм ирж эхэлсэн өдрөөс хойших долоо хоногийн дотор аль ч өдөр нь эхэлж болно.
Хөхүүл эх	Хүүхдээ хөхүүлэхээ больсон, эсвэл төрснөөс хойш 6 сарын хугацаа өнгөрсөн.
Хүүхэд төрүүлсэн, дараа хөхүүл биш эмэгтэй	Төрсний дараах 3-6 долоо хоног дотор хэрэглэж эхэлнэ.
Зулбалт, үр хөндөлтийн дараа	Жирэмслээд эхний 6 сарын хугацаанд зулбасан эсвэл үр хөндүүлсний дараа долоо хоногийн дотор хэрэглэж эхэлнэ.
Жирэмслэхээс хамгаалах бусад аргыг хэрэглэхээ болих үед	Эмийг даруй эхэлнэ. Тариа болон бусад жирэмслэхээс хамгаалах аргуудыг хэрэглэхээ зогсоож байгаа үед биеийн юм ирэхийг хүлээх шаардлагагүй.

### ДХЭ-ийг хэрэглэх талаар үйлчлүүлэгчид өгөх зааварчилгаа:

Алхам 1	Нэг боодол ДХЭ-ийг үйлчлүүлэгчид үзүүлж тайлбарлана. Эхний 21 ширхэг эм нь даавар агуулсан байх ба сүүлийн 7 ширхэг эм нь өөр өнгөтэй, даавар агуулаагүй, зөвхөн "сануулах" шахмалууд байна. Эмэгтэй "сануулах" эмийг уухаа мартсан үед жирэмсэн болохгүй ба харин идэвхтэй, даавар агуулсан эмээ уухаа мартсан тохиолдолд жирэмслэх магадлалтай гэдгийг түүнд сануулна.
Алхам 2	<ul style="list-style-type: none"> <li>✓ Боодлыг дуустал өдөр бүр нэг ширхэг эмийг тогтмол цагт уух ёстойг</li> <li>✓ Бэлгийн харьцаанд ороогүй байсан ч өдөр бүр нэг ширхэг эм уух ёстойг сануулна.</li> </ul>
Алхам 3	<b><i>Нэг ба олон эмийг уухаа мартсан үед</i></b>

Санасан даруй мартсан эмийг ууна. Дараагийн эмийг уух ёстой цагтаа ууна.

**Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:**

<b>Гаж нөлөө, асуудал</b>	<b>Авах арга хэмжээ</b>
Дотор эвгүйрхэх, толгой бага зэрэг өвдөх, бөөлжих, суулгах, зан араншин өөрчлөгдөх	Эмийг оройн цагаар, эсвэл хооллох үедээ, тогтмол цагт хэрэглэхийг зөвлөнө. Аспирин, парацетамол, ибупрофен зэрэг дааврын бус үрэвслийн эсрэг эмүүд хэрэглэхийг зөвлөнө.
Дааврын эмийг уусны дараа нэг цагийн дотор бөөлжих	Дааврын эмийг дахиж ууна.
Биений юмгүйдэл	Түгээмэл тохиолдоно. ✓ Эмээ тасралтгүй уусан бол жирэмсэн биш гэдгийг тайлбарлана. ✓ Эмээ хэрэглэхийг больсон бол жирэмсэн байж болохоос гадна, биений юм хэдэн сараар саатаж болохыг түүнд хэлнэ.
Биений юмны мөчлөг хооронд цусархаг ялгадас гарах, цус алдах зовиур хэдэн сарын туршид илрэх.	Эмээ уухаа мартсан эсэхийг лавлана. Эмээ уухаа мартсанаас цусархаг ялгадас болон цус алдаж болно, харин эмийг өдөр бүр ууж байгаа тохиолдолд цусархаг ялгадас үзэгдэж болдгийг тайлбарлана.
24 цагаас дээш хугацаагаар бөөлжих, хүчтэй суулгах	Шалтгааныг тодруулна. Хэдийгээр биед зовиуртай ч гэсэн эмийг болж өгвөл үргэлжлүүлэн ууж, суулгалт, бөөлжилт зогссоны дараа эмээ долоо хоног тасралтгүй уух явцдаа бэлгэвч хэрэглэх, эсвэл бэлгийн харьцаанд орохгүй байхыг эмэгтэйд зөвлөнө.
Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт.	Шалтгааныг тодруулна Ерөнхий болон эмэгтэйчүүдийн үзлэг хийж, үнэлгээ өгнө.



## ХОЁР. ДАН ПРОГЕСТЕРОН АГУУЛСАН ЭМ

**Прогестроны үйлчлэх механизм:** умайн хүзүүний салиаг анхдагчаар өтгөрүүлж, эр бэлгийн эс түүгээр нэвтрэн ороход болон биений юмны мөчлөгийн зөвхөн тал хувьд өндгөн эс боловсрох болон өндгөн эс өндгөвчнөөс гадагшлахад саад учруулдаг. ДПЭ жирэмслэлтийг зогсоохгүй.

**Үр дүн:** Зөв, тогтмол хэрэглэсэн тохиолдолд үр дүн сайтай. Уг аргыг хэрэглэж эхэлсэн эхний жилд 100 эмэгтэй тутмын 5 нь, 100 хөхүүл эмэгтэй тутмын нэг нь жирэмсэлж болзошгүй. Уг эм хөхний сүүний гарцад нөлөөлөхгүй тул хөхүүл эмэгтэй хэрэглэхэд тохиромжтой.

### Эмийн давуу тал:

- ✓ Эстроген хэрэглэснээс үүсэх эрсдлийг нэмэгдүүлэхгүй.
- ✓ Хөхний хоргүй хавдар, умайн салст болон өндгөвчний хорт хавдар, бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх нөлөөтэй.

### Эмийн сул тал:

- ▶ Биений юм өөрчлөгдөх, биений юм тогтмол бус болох, биений юмны мөчлөгүүдийн хооронд цусархаг ялгадас гарах, цус алдах, ховор тохиолдолд биений юм ирэхгүй болж болно. Зарим эмэгтэйд биений юм удаан үргэлжлэх, эсвэл их хэмжээгээр ирэх зэрэг өөрчлөлт илэрч болно.
- ▶ Хөхүүл үед ДПЭ-ийг хэрэглэвэл биений юмгүйдлийн үргэлжлэх хугацаа уртасч болно.
- ▶ Толгой өвдөх, хөх хөндүүрлэх зэрэг гаж нөлөө цөөн тооны эмэгтэйд илэрнэ.
- ▶ ДПЭ-ийг өдөр бүр тогтмол цагт уухад өндөр үр дүнтэй байх болно. Эмийг уух ёстой цагаас хэдэн цагаар оройтуулж уухад жирэмслэх магадлал нэмэгдэх бөгөөд хоёр ба түүнээс олон тооны эмийг уулгүй өнгөрөхөд магадлал эрс нэмэгдэнэ.

### ДПЭ-ийг хэрэглэж болох эмэгтэйчүүд:

1. Жирэмслэхээс хамгаалах богино хугацааны өндөр үр дүн үзүүлэх арга хэрэглэхийг хүсч буй бүх насны эмэгтэй, хөхүүл эмэгтэй.
2. Тамхи татдаг, толгой нь өвддөг, артерийн даралт ихтэй эмэгтэй.
3. Умайн хүзүүний шархлаа болон эктропионтой эмэгтэй.
4. Гэр бүлийн аль нэг гишүүн хөхний хоргүй ба хортой хавдраар өвчилж байсан дурьдатгалтай болон өндгөвчний хоргүй хавдартай эмэгтэй
5. Цус бүлэгнэлтийн эмгэг, хураагуур судасны өргөсөл, зүрхний хавхлагын эмгэгтэй эмэгтэй.
6. Цөсний хүүдийн эмгэгтэй эмэгтэй.
7. Бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчтэй, эсвэл уг өвчнөөр өвчлөх эрсдэлтэй болон умайн холбогч эдийн хоргүй хавдар болон эндометриозтой эмэгтэй.
8. Биений юм их хэмжээтэй, удаан үргэлжлэн, өвдөж ирдэг.
9. Эпилепситэй болон рифамицин хэрэглэдэг эмэгтэй.

### ДПЭ-ийг хэрэглэхэд тохиромжгүй нөхцөл:

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Жирэмсэн	Жирэмсэн эмэгтэй ДПЭ-ийг хэрэглэхгүй. Гэвч жирэмсэн үед санамсаргүй хэрэглэсэн тохиолдолд эх болон урагт хортой нөлөө үзүүлсэн тохиолдол тэмдэглэгдээгүй байна.
Шалтгаан нь тодорхой бус үтрээний цус алдалт	Жирэмсэн болон бусад шалтгааныг аль болох хурдан тогтоох хэрэгтэй. Шалтгааныг тогтоох хүртэл ДПЭ-ийг болгоомжтой хэрэглүүлж болно.
Хөхний хорт хавдар	Хөхний хорт хавдартай, эсвэл урьд нь түүгээр өвчилж байсан дурьдатгалтай эмэгтэй ДПЭ-ийг хэрэглэж болохгүй.
Элэгний өвчин	Элэгний хатуурал, хавдар, вирусийн гаралтай элэгний <b>хурц</b> үрэвсэлтэй эмэгтэй ДПЭ-ийг хэрэглэж болохгүй. Архаг В гепатитын нян тээгчид ДПЭ эмийг хэрэглэж болно.

### ДПЭ-ийг хэрэглэж эхлэх хугацаа, нөхцөл:

Нөхцөл байдал	Хэзээ хэрэглэж эхлэх
Хөхүүл үе	<ul style="list-style-type: none"> <li>Төрөөд 6 сар болсон, биений юм ирсэн бол ДПЭ-ийг аль болох түргэн хэрэглэж эхлэх хэрэгтэй.</li> <li>Хүүхдээ дан хөхний сүүгээр хооллодоггүй тохиолдолд төрсний дараа 6 долоо хоног өнгөрмөгц эсвэл хүүхдээ хөхүүлэхийг хязгаарлаж эхэлмэгц хэрэглэж эхлэх хэрэгтэй. Эм хэрэглэхийг хойшлуулсан тохиолдолд жирэмслэх чадвар сэргэж болно.</li> <li>Биений юм ирсэн, жирэмсэн биш гэдэгт эргэлзэхгүй байгаа тохиолдолд ДПЭ-ийг хэдийд ч эхэлж болно.</li> </ul>
Төрсний дараа хөхүүл биш үе	<ul style="list-style-type: none"> <li>Төрсний дараа шууд, эсвэл эхний 4 долоо хоног дотор хэзээ ч эхэлж болно. Биений юм ирэхийг хүлээх шаардлагагүй.</li> <li>Эмэгтэй жирэмслээгүй гэдэгт эргэлзэхгүй байгаа үед 4 долоо хоногоос дээш хугацаа өнгөрсний дараа дуртай үедээ эхэлж болно. Эргэлзэж байгаа тохиолдолд эмэгтэй эхний биеийн юмаа иртэл бэлгийн харьцаанд орохгүй байх, эсвэл бэлгэвч хэрэглэх шаардлагатай. Үүний дараа ДПЭ-ийг хэрэглэж эхэлнэ.</li> </ul>
Үр хөндүүлсэн, эсвэл зулбасны дараа	<ul style="list-style-type: none"> <li>Жирэмсний эхний 22 долоо хоногоос өмнө зулбасан болон үр хөндүүлсний дараа шууд, эсвэл 7 хоногийн дараа</li> <li>Эмэгтэй жирэмсэн биш гэдгээ баттай мэдэж байгаа тохиолдолд дээрх хугацаанаас хойш хэдийд ч эхэлж болно.</li> </ul>
Биений юмны мөчлөг хэвийн	<ul style="list-style-type: none"> <li>Биений юм ирж эхэлсний эхний 5 хоногийн дотор илүү тохиромжтой.</li> <li>Биений юмны 5 дахь хоногоос хойш хэрэглэж эхэлсэн бол эхний 2 хоногт бэлгэвч, эсвэл өөр арга хавсарч хэрэглэх ёстой.</li> </ul>
Жирэмслэхээс хамгаалах өөр арга хэрэглэхээ болих үе	<ul style="list-style-type: none"> <li>Жирэмслэхээс хамгаалах тариа хэрэглэж байсан тохиолдолд ДПЭ-ийг шууд хэрэглэж болно.</li> </ul>

**ДПЭ-ийг хэрэглэх заавар:**

<b>Алхам 1</b>	Боодол дахь бүх эмийг дуустал нь өдөр бүр нэг ширхгээр, тогтмол цагт ууна. Эмэгтэй бэлгийн харьцаанд орохгүй байгаа тохиолдолд ч эмийг өдөр бүр үргэлжлүүлэн ууна.
<b>Алхам 2</b>	Үйлчлүүлэгч нэг эсвэл олон ширхэг эмийг уухаа мартсан тохиолдолд санасан даруйдаа нэг ширхэг эм ууж, дараа нь өдөр бүр нэг ширхгээр эмийг үргэлжлүүлэн хэвийн горимоор ууна. Эм уух ёстой цагаас 3 цагаас дээш хугацаа хэтэрвэл дараагийн хоёр хоногийн туршид бэлгийн харьцаанд орохгүй байх эсвэл бэлгэвч хэрэглэх шаардлагатай.
<b>Алхам 3</b>	Эмэгтэйд асуудал үүссэн, түүний санаа зовоосон зүйлс байгаа эсэхийг тодруулна.

**Гаж нөлөө илэрсэн үед авах арга хэмжээ:**

<b>Гаж нөлөө</b>	<b>Авах арга хэмжээ</b>
Дотор эвгүйрхэх, толгой хүчтэй өвдөх, сэтгэл санаа тогтворгүй болох, хөхөөр хөндүүрлэх.	Эмийг хоолтой хамт, эсвэл орой унтахын өмнө уухыг зөвлөнө. Өвдөлт намдаах эм уухыг зөвлөнө.
Дааврын эмийг уусны дараа нэг цагийн дотор ямар нэг шалтгаанаар бөөлжих	Эмийг дахин уухыг зөвлөнө.
24 цагаас дээш хугацаагаар бөөлжих, хүчтэй суулгах	Эмийг болж өгвөл үргэлжлүүлэн ууж, суулгалт, бөөлжилт зогссоны дараа эмийг хоёр хоног дараалан уух хүртэл бэлгийн харьцаанд орохгүй эсвэл бэлгэвч хэрэглэхийг зөвлөнө.
Хөхүүл эмэгтэйд биений юмгүйдэл үүсэх	Хөхүүл эмэгтэйд хэвийн үед ч тохиолдож болох шинж гэдгийг эмэгтэйд тайлбарлаж өгнө.
Хөхүүл биш эмэгтэйн санааг зовоож буй биений юмгүйдэл, цусархаг ялгадас гарах, эсвэл тогтмол бус цус алдах.	Жирэмсэн эсэхийг магадлах хэрэгтэй.
Үтрээнээс цус алдах.	ДПЭ-ийг үргэлжлүүлэн хэрэглэж болно.
Артерийн судасны бүлэнгийн улмаас үүссэн зүрхний цусан хангамж дутагдах өвчин эсвэл цус харвалт	Зүрхний эмгэг илэрвэл тусламж үзүүлэхээр шилжүүлэх.

## ГУРАВ. ЯАРАЛТАЙ УУЖ ЖИРЭМСЛЭХЭЭС ХАМГААЛАХ ЭМ

Хамгаалалтгүй бэлгийн харьцааны дараа яаралтай жирэмслэхээс хамгаалах даавар (ЯЖХД) –ын эм ууж хамгаалж болно. Уг эмийг “ хурьцлын дараах маргааш өглөөний” жирэмслэхээс хамгаалах эм гэж нэрлэх нь ч бий. Энэ нь 2 төрөл байдаг.

1. Левонел (Levonelle one) – хамгаалалтгүй бэлгийн харьцаанаас хойш 3 хоногийн дотор ууна. Өндгөн эсийн хөгжлийн үеийг саатуулдаг даавар агуулсан бэлдмэл юм.

2. Элла (Ella One) – хамгаалалтгүй бэлгийн харьцаанаас хойш 5 хоног дотор хэрэглэнэ. Энэ нь юлипристал ацетат агуулж, өндгөн эс чөлөөлөгдөх явцыг саатуулна.

**Үйлчлэх зарчим:** ЯЖХД эм нь өндгөн эс өндгөвчнөөс гадагшлахыг саатуулдаг. Нэгэнт үүссэн жирэмслэлтийг зогсоох нөлөө үзүүлэхгүй.

**Үр дүн:** ЯЖХД эмийг хэрэглэснээр хүсээгүй жирэмсний дөрөвний гурваас хамгаална. Нэг удаагийн хамгаалалтгүй бэлгийн хавьтлын дараа жирэмслэх магадлал 8% байдаг ба уг эмийг хэрэглэснээр энэ үзүүлэлт 2% хүртэл буурах боломжтой.

### ЯЖХД эмийн давуу тал:

- Төлөвлөөгүй нөхцөл байдлын (жишээ нь бэлгэвч урагдсан, эсвэл хүчин үүссэн) дараа хэрэглэж, жирэмслэхээс хамгаална.
- Бэлгийн хавьтлын дараа хүсээгүй жирэмслэхээс хамгаалах цорын ганц арга юм.
- ЯЖХД эм хэрэглэснээр хүсээгүй жирэмсэлтийг бууруулах ба улмаар үр хөндөлт буурна.

**ЯЖХД эмийн сул тал:** Яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эмийг гэр бүл төлөвлөлтийн бусад аргыг орлуулах зорилгоор байнга хэрэглэж болохгүй. Бусад аргуудтай харьцуулахад ЯЖХД эмийг хэрэглэсэн үед жирэмслэх магадлал өндөр, гаж нөлөө үүсэх нь элбэг.

### ЯЖХД эмийг олгох:

- Жирэмсэн эсэхийг тодруулах зорилгоор холбогдох асуултыг эмэгтэйгээс асууна. Жирэмсэн батлагдсан бол ЯЖХД эмийг олгож болохгүй.
- Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон өдөр, цагийг тогтоож, ЯЖХД эмийг хэрэглэх хугацаа хэтэрсэн эсэхийг тогтооно.
- Жирэмсэн болон ЯЖХД уухад эсрэг заалт байгаа эсэхийг тогтоох зорилгоор ерөнхий биеийн болон үтрээний үзлэг хийнэ.
- ЯЖХД эм, түүний гаж нөлөө, үр дүнгийн талаар тайлбарлана. ЯЖХД эмийг сард дөрвөөс илүү хэрэглэж болохгүй гэдгийг мөн хэлж өгнө. Эм хэрэглэж байгаа үед дотор эвгүйцэх, огиулах гаж нөлөө элбэг үүсдэгийг анхааруулна.

### ЯЖХД эмийг хэрэглэж болох эмэгтэйчүүд:

- Эмэгтэй бэлгийн хүчирхийлэлд өртсөн,

- Тохиолдлын бэлгийн харьцаанд орсон,
- Бэлгэвч цоорсон,
- Ерөндөг унасан,
- Эмэгтэйн хэрэглэж байсан жирэмслэхээс хамгаалах хэрэгслийн нөөц дууссан, дан прогестерон агуулсан жирэмслэхээс хамгаалах эмийн 2 ба түүнээс олон ширхаг эмийг уугаагүй өнгөрсөн, ДМПА тариаг хийлгэх ёстой хугацаанаас хэдэн долоо хоногоор хоцорсон,
- Жирэмслэхээс хамгаалах дааврын уух эмийг удаан хугацаагаар хэрэглэхэд эсрэг заалттай эмэгтэй ЯЖХД эмийг яаралтай үед хэрэглэж болох ба эрүүл мэндэд аюулгүй.

#### ЯЖХД эмийн төрөл:

Эмийн нэр	Яаралтай уух эмийн тоо ширхэг	12 цагийн дараа уух эмийн тоо ширхэг
<b>Постинор</b> - Левоноргестрол 0.75 мг	1	1
<b>Ригевидон</b> - Даавар бага тунгаар агуулсан (35 микрограм этинилэстрадиол+ 0.15 мг левоноргестрол): Микрогинон, Нордетте, Млада-Д.	4	4
<b>Даавар өндөр тунгаар агуулсан</b> (50 микрограм этинилэстрадиол+ 0.25 мг левонестрол) жирэмслэлтээс хамгаалах хавсарсан уух эм. Эугинон 50, Феменаль, Нордиол, Оврал	2	2

#### ЯЖХД эмийг хэрэглэх заавар:

1. ЯЖХД эмийн эхний тунг хамгаалалтгүй бэлгийн хавьтлын дараа сонгож буй эмээс шалтгаалан 72 эсвэл 120 цагийн дотор аль болох яаралтай уух ёстой. Эмийг яаралтай хэрэглэх нь жирэмслэхээс илүү найдвартай хамгаалах ач холбогдолтой.
2. Хоёр дахь тунг эхний тунг хэрэглэснээс хойш 12 цагийн дараа ууна. Эхний тунг хэрэглэсний дараа дотор эвгүйцэх, огиулах тохиолдолд ч 2 дахь тунг заавал ууна. Хоёр дахь тунг уугаагүй өнгөрсөн тохиолдолд эмчилгээний үр дүн гарахгүй байж болно.
3. 2 цагийн дотор бөөлжсөн бол тунг давтан уух шаардлагатай.
4. Хүсээгүй жирэмслэлтээс өөрийгөө хамгаалахын тулд жирэмслэхээс хамгаалах өөр арга даруй хэрэглэж эхлэх хэрэгтэй.

#### Үйлчлүүлэгчид сануулах нь:

- ЯЖХД эмийг хэрэглэсний дараа дахин хамгаалалтгүй бэлгийн хавьталд ороход уг эм таныг жирэмслэлтээс хамгаалахгүй. Та дараагийн биений юмаа ирэхээс өмнө дахин бэлгийн хавьталд орохоор бол үрийн шингэнийг үтрээнд ороход саад учруулах хаалтын аргыг хэрэглэх ёстой.

- ЯЖХД эм БЗДХ, ХДХВ/ДОХ-оос хамгаалахгүй.
- Дараагийн биений юм хэвийн бус тохиолдолд эмнэлэгт хандах ёстой. Тухайлбал:
  - Хэт бага ирэх (жирэмсэн болсон байж болзошгүй)
  - 3 долоо хоногоос илүү хугацаагаар саатах (жирэмсэн болсон байж болзошгүй)
  - Хүчтэй өвдөлт үүсэх (умайн гаднах жирэмсэн байж болно).
  - Гэнэт хэвлийн доод хэсгээр өвдөх
  - ЯЖХД эмийг буруу хэрэглэсэн
  - БЗДХ авсан байж болзошгүй.

#### Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:

Гаж нөлөө, асуудал	Авах арга хэмжээ
Дотор эвгүйрхэх,	Дотор эвгүйрхэхийг багасгахын тулд эмээ уухаас өмнө юм идэхийг зөвлөнө. Жирэмсэн үед дотор эвгүүрдэг, огиулдаг өгүүлэмжтэй, эсвэл дааврын хавсарсан эмийг хэвийн горимоор хэрэглэхэд дээрх зовуурь илэрдэг эмэгтэйд ЯЖХД эмийг олгохын өмнө тайвшруулах эм уулгаж болно. (фенерган, диазепам зэрэг)
Дааврын эмийг уусны дараа бөөлжих	Эмэгтэй эм уусны дараа 2 цагийн дотор бөөлжсэн бол эмийн нэг тунг дахин уух ёстой. Бөөлжөөгүй үед эм давтан уух шаардлагагүй.
Биений юмны мөчлөг алдагдах	Дараагийн биений юм ирэх ёстой хугацаанаас 1 долоо хоногийн өмнө, эсвэл хойно ирж болно.

#### Аюулгүй байдал:

- ЯЖХД эм нь эрүүл мэндэд аюулгүй. Уг арга 20 гаруй жилийн туршид хэрэглэгдэж байгаа ба энэ хугацаанд нас баралт, эрүүл мэндэд аюултай хүндрэл үүссэн тохиолдол тэмдэглэгдээгүй байна.
- Жирэмсэн үед ЯЖХД эмийг хэрэглэсэн тохиолдолд ургийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэггүй болохыг тогтоожээ.

## ДӨРӨВ. ЖИРЭМСЛЭХЭЭС ХАМГААЛАХ ДАН ПРОГЕСТЕРОН АГУУЛСАН ТАРИА

Жирэмслэхээс хамгаалах дан прогестерон агуулсан Депо-Провера тариа 150 мг депот-медроксипрогестерон ацетат агуулдаг. Өндгөн эс өндгөвчнөөс гадагшлахыг зогсоох, умайн хүзүүний салиаг өтгөрүүлснээр үрийн шингэн үтрээнээс умай руу ороход саад учруулах ба 3 сар тутамд булчинд, гүн тарьж хэрэглэнэ. Тариаг хийх ёстой хугацаанаас нь оройтож хийлгүүлсэн эсвэл хийлгээгүй өнгөрсөн, тохиолдолд жирэмслэх магадлал нэмэгддэг.

### ДМПА-ийн давуу тал:

- ✓ Бүх насны эмэгтэйчүүдэд тохиромжтой.
- ✓ Хөхний сүүний чанар болон гарцад нөлөөлөхгүй.
- ✓ Зүрх, судасны өвчний эрсдлийг бий болгохгүй.
- ✓ Умайн салстын хорт хавдар болон умайн холбоосонд хоргүй хавдар үүсэхээс урьдчилан сэргийлэхэд тустай.
- ✓ Төмөр дутагдлын цус багадалтаас урьдчилан сэргийлнэ.
- ✓ Эпилепситэй эмэгтэйчүүд хэрэглэхэд эпилепсийн уналтын тоо цөөрч болно.

### ДМПА-ийн сул тал:

- ▶ Бага хэмжээний цусархаг ялгадас гарах ба эсвэл цус ихээр алдаж болно.
- ▶ Биений юмгүйдэл илэрч болно.
- ▶ Биеийн жин нэмэгдэж болно.
- ▶ Толгой өвдөх, хөхөөр хөндүүрлэх, сэтгэл гутрах, дотор эвгүйрэх, үс унах, бэлгийн сэрэл буурах, нүүрэнд батга гарах зэрэг өөрчлөлтүүд ажиглагдана.
- ▶ Жирэмслэхээс хамгаалах хавсарсан эм уух, ерөндөг, бэлгэвч, эсвэл үтрээний түрхлэг хэрэглэж байсан эмэгтэйг бодвол жирэмслэх чадвар 4 сараар хожуу сэргэдэг.
- ▶ 3 сар тутамд төлөвлөсөн хугацаанд тариаг хийлгэх шаардлагатай.
- ▶ ДМПА нь БЗДХ/ ДОХ/ХДХВ-аас хамгаалахгүй.

### ДМПА-г хэрэглэх нь:

- Жирэмслэхээс удаан хугацаагаар хамгаалах, үр дүн сайтай арга хэрэглэхийг хүсч буй эмэгтэйд тариаг 3 сар тутамд нэг удаа хийнэ.
- Биений юм нь ирж эхэлсэн охидоос эхлээд цэвэршилтийн нас хүртэлх бүх насны эмэгтэйчүүд хэрэглэхэд тохиромжтой.
- Тамхи татдаг эмэгтэйчүүд.
- Төрсний дараа 6 долоо хоног болсон хөхүүл эмэгтэй.
- Бага аарцгийн хөндийн эрхтний үрэвсэлтэй эсвэл уг өвчнөөр өвчлөх эрсдэлтэй эмэгтэй. Халдвар авах эрсдлийг багасгахын тулд бэлгэвч хэрэглэх ёстой.

**ДМПА-ыг хэрэглэхэд тохиромжгүй нөхцөл:**

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Жирэмсэн	Жирэмсэн үед Депо-Провераг хэрэглэхгүй. Гэвч санамсаргүй тохиолдлоор хэрэглэсэн тохиолдолд эх болон урагт сөрөг нөлөө үзүүлдэггүй.
Хөхүүл үе	Стероид даавар нярайд нөлөөлөх тул Депо-Провераг төрсний дараах 6 долоо хоногийн хугацаанд хэрэглэж болохгүй.
Артерийн даралт ихсэх	Артерийн даралт бага хэмжээгээр (АД140-159мм МУБӨ/90-99мм МУБӨ) эсвэл дунд зэрэг (АД160-179мм МУБӨ/100-109мм МУБӨ) ихэссэн үед Депо-Провераг хэрэглэж болно. Артерийн даралт 180/110 МУБӨ-с дээш, эсвэл судасны эмгэгээс шалтгаалан даралт ихэссэн тохиолдолд Депо-Провераг хэрэглэж болохгүй.
Зүрхний шигдээс өвчинтэй, өвчилж байсан дурьдатгалтай	Депо-Провераг хэрэглэж болохгүй.
Цус харвалт	Цус харваж байсан өгүүлэмжтэй эмэгтэй Депо-Провераг хэрэглэж болохгүй.
Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт	Шалтгааныг тодруулна.
Хөхний хавдар	Өмнө нь хөхний хорт хавдраар өвчилж байсан өгүүлэмжтэй, эсвэл одоо дээрх оноштой байгаа эмэгтэй Депо-Провераг хэрэглэхгүй.
Умайн салст болон өндгөвчний хорт хавдар	Эмчилгээг эхлээгүй байгаа үед эмэгтэй Депо-Провераг хэрэглэхэд аюулгүй болно.
Элэгний эмгэг	Элэгний хатуурал, хавдар, вирусийн гаралтай элэгний хурц үрэвслийн үед Депо-Провераг хэрэглэхгүй.

**Депо-провераг тарих заавар:** Түгээмэл үйлдлийн стандартын дагуу тарилгыг хийнэ. Ариун зүү, тариураар мөрөнд эсвэл өгзгөнд гүн хатгаж тарина.

**Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:**

Гаж нөлөө, асуудал	Үнэлгээ	Авах арга хэмжээ
Тарианы давтан тунг авах хугацаанаас 2 долоо хоног хоцорсон, байнгын бэлгийн харьцаанд байдаг	Эмэгтэй жирэмсэлсэн эсэхэд үнэлгээ өгнө. Депо-Провераг хэрэглэж буй эмэгтэйн биений юм ирэхгүй байх нь элбэг тохиолддогийг анхаар.	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэй жирэмсэн биш бол дараагийн тунг хийлгэж болно.</li> </ul>



Биений юмгүйдэл		<ul style="list-style-type: none"> <li>• Депо-Провераг хэрэглэгчдэд биений юмгүйдэл үүсэх нь элбэг тохиолддог.</li> </ul>
Биений юмны мөчлөг хооронд цусархаг ялгас гарах, цус алдах	БЗДХ, бага аарцгийн эрхтний үрэвсэлт өвчнийг үгүйсгэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цусархаг ялгас гарах, цус алдах нь элбэг тохиолддог. Эмэгтэйчүүдийн эмгэг илэрвэл шаардлагатай эмчилгээг хийнэ, эсвэл эмэгтэйг шилжүүлнэ.</li> </ul>
	Цус алдалтыг шалтгаан тодорхойгүй бөгөөд эстроген даавар хэрэглэх эсрэг заалт байхгүй тохиолдолд:	<ul style="list-style-type: none"> <li>▪ Даавар бага тунгаар агуулсан жирэмслэхээс хамгаалах хавсарсан эмийг өдөрт 1 ширхгээр 7-21 хоногийн туршид, 2-3 сар уулгана. <b>ЭСВЭЛ</b> Ибупрофен, эсвэл стероид бус үрэвслийн эсрэг бусад эмийг уулгана.</li> </ul>
Нүдний хараа бүрэлзэх, хүчтэй (мигрень)	хараа толгой өвдөх	<ul style="list-style-type: none"> <li>▪ Эмэгтэй даавар агуулаагүй өөр аргасонгох шаардлагатай.</li> </ul>

**Эмнэлэгт давтан ирж үзүүлэх:** Жирэмслэхээс найдвартай хамгаалахын тулд 3 сар тутамд тогтмол тариулна. Тариа хийх хугацааг 2-4 долоо хоногоор урагшлуулж, эсвэл 2 долоо хоногоор хойшлуулж болох ч энэ нь оновчтой бус шийдвэр юм. Тариа хийх хугацаа 2 долоо хоногоос илүү хугацаагаар өнгөрсөн бол дараагийн тариаг тариултал бэлгэвч хэрэглэх, эсвэл бэлгийн харьцаанд орохгүй байхыг зөвлөнө. Мөн жирэмслэхээс хамгаалах зорилгоор өндөр тунтай дааврыг бэлгийн харьцаанд орсны дараа шууд хэрэглэж болно.

## ТАВ. СУУЛГАЦ.

Жирэмслэхээс хамгаалах дан прогестерон агуулсан суулгац нь дараах 2 төрөл байна.

**А. Имплант:** Шүдэнзний хэлбэртэй 2 ширхэг суулгацыг мэргэжлийн эмч арьсан дор суулгадаг. Имплант суулгацаас шар биеийн даавар аажмаар ялгаран цусны урсгалд ордог байна.

**Б. Норплант:** Шүдэнзний модны хэмжээтэй зургаан ширхэг жижиг хуванцар капсулаас бүрдэнэ. Капсул бүр нь прогестин левоноргестрел хэмээх шар биеийн даавар агуулна. Норплантын суулгац 5 жилээс багагүй хугацааны туршид жирэмслэхээс хамгаална. Норплант суулгацуудын нэг иж бүрдэлд 36 мг левоноргестрел даавар агуулагдах бөгөөд үүний 85 микрограмм нь өдөр бүр тогтмол ялгарч, арван найман сарын дараа тун буурч 30 микрограмм болно.

**Суулгацын үйлчлэх зарчим:** Умайн хүзүүний салиаг өтгөрүүлж, үрийн шингэн үтрээнээс умай руу ороход саад болж, өндгөн эс боловсрохыг зогсооно.

**Үр дүн:** Нэг жилийн туршид уг аргыг хэрэглэж байгаа эмэгтэй тутамд жирэмсэн болох магадлал 0.32 буюу нэг тохиолдлоос бага байна.

### Суулгацын давуу тал:

- ✓ Таван жилийн туршид жирэмслэхээс хамгаалах өндөр үр дүнтэй.
- ✓ Суулгац тавьснаас хойш 24 цагийн дотор үйлчилж эхэлнэ.
- ✓ Ихэнхи тохиолдолд капсулуудыг авсан даруй жирэмслэх чадвар сэргэнэ.
- ✓ Хөхний сүүний чанар болон гарцад нөлөөлөхгүй. Хүүхэд төрүүлээд 6 долоо хоног өнгөрснөөс хойш хөхүүл эхчүүд норплантыг хэрэглэж болно.
- ✓ Төмөр дутагдлын цус багадалтаас сэргийлнэ.
- ✓ Умайн гадуур жирэмслэхээс сэргийлнэ.
- ✓ Умайн салстын хорт хавдраас сэргийлнэ.

### Суулгацын сул тал:

- ▶ Цусархаг ялгадас гарах, биений юмны мөчлөг хооронд цус алдах,
- ▶ Биений юм удаан хугацаагаар үргэлжлэх эсвэл биений юмгүйдэл үүсэх,
- ▶ Толгой өвдөх, толгой эргэх,
- ▶ Өндгөвч, өндгөвчний цэврүүнүүд томрох,
- ▶ Хөхөөр хөндүүрлэх, хөхнөөс шүүрэл гарах,
- ▶ Хэт цочромтгой болох, дотор эвгүйрэх, нүүрэнд батга, тууралт гарах,
- ▶ Хоолны дуршилд өөрчлөлт орох, жин нэмэх ба буурах,
- ▶ Үс унах эсвэл нүүрэнд илүү үс ургах.

### Суулгацыг хэрэглэх нь:

1. ГБТ-ийн удаан хугацааны бөгөөд байнгын бус арга хэрэглэхийг хүсч байгаа эмэгтэй.
2. Хүссэн хүүхдээ төрүүлсэн боловч тухайн үед байнгын арга хэрэглэхийг хүсэхгүй байгаа эмэгтэй.

3. Хүүхдээ төрүүлснээс хойш 6 долоо хоног ба түүнээс дээш хугацааны турш хүүхдээ хөхүүлж байгаа бөгөөд жирэмслэхээс хамгаалах хэрэгсэл хэрэглэхийг хүсч буй эмэгтэй.
4. Тамхи татдаг эмэгтэй.

**Суулгацыг хэрэглэх эсрэг заалт:**

Нөхцөл байдал	Үйлчилгээ
Жирэмсэн	Хэрэв суулгац тавьсны дараа умайн жирэмсэн нь батлагдаж, эмэгтэй хүүхдээ төрүүлэх шийдвэр гаргасан бол суулгацыг авна.
Шалтгаан нь тодорхой бус үтрээний цус алдалт	Шалтгааныг тогтоож, эмгэгийг эмчилсний дараа суулгацыг суулгаж болно.
Биений юм өөрчлөгдөхөд тухайн эмэгтэй эмзэглэх	Биений юм тогтмол бус ирэх, ойр ойрхон ирэх зэрэгт санаа зовж буй эмэгтэйд суулгацыг суулгахаас өмнө дан прогестерон агуулсан эмийг 3 сар уулгах, эсвэл өөр арга сонгож болох юм.
Шарлалт	Зөвхөн бусад аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд суулгацыг хэрэглэнэ.
Элэгний хавдар	Зөвхөн бусад аргыг хэрэглэх боломжгүй тохиолдолд суулгацыг хэрэглэнэ.
Хөхний хорт хавдартай эсвэл уг эмгэгээр өвчилж байсан, одоо шинж тэмдэггүй байгаа	Зөвхөн бусад аргыг хэрэглэх боломжгүй үед суулгацыг хэрэглэнэ. Бага тунтай прогестерон хөхний хорт хавдар үүсгэсэн тохиолдол байхгүй боловч хөхний хорт хавдар нь дааварт мэдрэг байдаг. Сэжиг бүхий хөндий бэрсүүтэй бол хэрэглэхээс өмнө үнэлгээ өгнө.
Эпилепси ба сүрьеэ өвчнийг эмчлэх эм хэрэглэдэг	Эдгээр эмийг хэрэглэж байгаа тохиолдолд Норплантын үр нөлөө буурах боломжтойг эмэгтэйд анхааруулна.

**Суулгацыг хэрэглэж эхлэх нөхцөл, хугацаа:**

Эмэгтэйн биеийн байдал	хугацаа
Биений юмны мөчлөг	<ul style="list-style-type: none"> <li>• Биений юм ирсэн эхний өдрөөс хойш 7 хоногийн дотор</li> <li>• Мөчлөгийн бусад үед жирэмсэн биш гэдгийг баттай мэдэж байгаа тохиолдол</li> </ul>
Хөхүүл эх	<ul style="list-style-type: none"> <li>• Стероид даавар нярайд нөлөөлөх тул суулгацыг төрсний дараах 6 долоо хоног дотор хэрэглэж БОЛОХГҮЙ.</li> <li>• Биений юм ирж эхэлсэн тохиолдолд: эхний 7 хоног дотор хэрэглэнэ.</li> </ul>
Хөхүүл биш эмэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Эмэгтэйн биений юм ирэхийг хүлээх шаардлагагүй төрсний дараа шууд эсвэл 6 долоо хоног дотор.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Төрснөөс хойш 6 сараас дээш хугацаа өнгөрсөн, эсвэл жирэмсэн биш гэдэг нь батлагдсан тохиолдолд эмэгтэй биений юм иртэл бэлгийн харьцаанд орохгүй байх эсвэл бэлгэвч хэрэглэнэ. Зөвхөн биений юм ирсэн тохиолдолд суулгацыг суулгаж болно.</li> </ul>
Зулбалт, үр хөндөлтийн дараа	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсний эхний эсвэл хоёр дахь 3 сард зулбасан эсвэл үр хөндүүлсний дараа шууд эсвэл долоо хоногийн дотор</li> <li>• Зулбалт, үр хөндөлтөөс хойш долоо хоногоос дээш хугацаа өнгөрсөн бол бэлгэвч эсвэл өөр арга хэрэглэж байгаад дараагийн биений юм ирсний дараа эсвэл эмэгтэй жирэмсэн биш гэдэгт эргэлзэхгүй байгаа тохиолдолд аль ч хугацаанд суулгаж болно.</li> </ul>

**Суулгацыг тавих:** Дараах багаж тоног төхөөрөмж шаардлагатай.

- Эмэгтэйг хэвтүүлэх үзлэгийн ширээ
- Гарын түшлэг, эсвэл хажуугийн ширээ
- Гар угаах саван
- Зургаан ширхэг суулгацыг агуулсан ариутгасан уут
- Мэс заслын ариутгасан даавуу
- Ариутгасан багажийг байрлуулах жижиг ширээ, тавиур
- Ариутгасан 3 сав бэлтгэнэ. Эхний саванд антисептик уусмал, хоёр дахь саванд – бээлийний талькийг арчих ариутгасан нойтон хөвөн хийх, гурав дахь саванд – суулгацуудыг уутнаас нь гаргаж бэлтгэнэ.
- Мэс заслын ариутгасан нэг хос бээлий
- 1%-ийн найрлага бүхий хэсгийн мэдээ алдуулах лидокайн
- Тариур, 22 G зүү
- #10 трокарь, түлхэгчийн хамт
- Мэс заслын #11 иртэй хутга
- Суулгацуудыг дэвүүр хэлбэртэй байрлуулахыг харуулсан хуванцар загвар
- Шархыг наах бэлэн наалт эсвэл ариутгасан марль, мэс заслын ариутгасан боолт, бигнүүр, анафилаксийн шокийн үед хэрэглэх эпинефрин

Алхам 1	Үйлчлүүлэгчийг ширээн дээр хэвтэхээс өмнө гарыг нь савангаар угаалгаж, шууны дотор дээд хэсгийг антисептикийн уусмалаар арчина.
Алхам 2	Суулгацуудыг суулгах хамгийн тохиромжтой талбайг тохойны үенээс дээш 8 см-т тэмдэглэж сонгоно. Загварыг ашиглан зүсэлт хийх ба капсулуудыг суулгах газрыг тэмдэглэнэ.
Алхам 3	Арьсыг халдваргүйжүүлэх уусмалаар арчин, шууг ариутгасан даавуугаар хучиж, ариун талбай бий болгоно. Хэсгийн мэдээ алдуулах тариа 3 мл-ийг тарина. Суулгацыг суулгах 3 чиглэлд трокарыг оруулах замын дагуу тус бүр 1 мл мэдээ алдуулах тариа шахна. Мэс заслын хутгыг 45 хэмийн өнцгөөр барьж, арьсыг дөнгөж нэвтлэх

	жигиг, өнгөц зүсэлт хийнэ. Урт, гүн зүсэлт бүү хий.
Алхам 4	<b>Трокарь дээрх хоёр тэмдгийн зориулалтыг санах нь зүйтэй.</b> Трокарийн налуу (Bevel)- г дээш хариуулж барина. Трокар дээр хоёр зураас байгаа. Тэмдэг (1) – энэ нь трокарын уг хэсэгт ойр байх ба, суулгацуудыг хийхээс өмнө трокарь энэ тэмдэг хүртэл арьсан доор орсон байх ёстой. Тэмдэг (2) – энэ нь трокарийн үзүүрт ойр байх ба суулгац бүрийг суулгах явцад аль хэсэг хүртэл арьсан дор үлдэхийг заана.
Алхам 5	Налуу хэсгийг нь дээш харуулан, түлхэгчийг хийсэн байдлаар трокарийн үзүүрийг зүсэлт хийсэн газарт хурц өнцгөөр оруулна. Загварт харуулсан дагуу дэвүүрийн хажуу талаас эхлэн налууг нь арьсан дор налууны төгсгөлөөс 2-3 мм өнгөртөл трокарийг урагш явуулна. <b>Трокарийг оруулахад хүч хэзээ ч бүү хэрэглэ.</b> Хэрэв эсэргүүцэл тулгарвал өөр өнцгөөр дахиж оруулна.
Алхам 6	Капсулуудыг арьсан дор өнгөц байрлуулахын тулд трокарийг арьсан доогуур дээш чиглүүлэн удаан зөөлөн, эхний зураас хүртэл түлхэнэ. Трокарь нь хуруугаар мэдэрч болохоор арьсан дор өнгөц байх ёстойг анхаар. Трокараар арьсыг гүвийлгэн товойлгож зөв явж байгаа эсэхийг тогтмол хянана. Трокарь нь арьсан дор зохих хавтгайд байрласан тохиолдолд зөөлөн саадгүйгээр урагшилна.
Алхам 7	Трокарь эхний зураас (1)-д хүрэхэд түлхэгчийг гаргана. Эхний капсулыг хоёр хуруугаараа эсвэл хавчуураар барьж трокарьт хийнэ. Капсулуудийг гараар барьж байгаа тохиолдолд бээлийний гадаргууд тальк болон бусад жигиг хэсгүүд байх ёсгүй. Капсулийг унахаас сэргийлж гараа доор нь тосож түүнийг трокарт суулгана. Капсулийг доош шахаж түлхэгчийг буцааж хийнэ.
Алхам 8	Түлхэгчийн тусламжтай капсулийг трокарийн үзүүр хүртэл эсэргүүцэл мэдэртэл явуулна. <b>Түлхэгчид хүч бүү хэрэглэ. Түлхэгч нь трокарийн хагас урттай тэнцэх зам туулсан үед эсэргүүцэл мэдрэгдэж эхэлнэ.</b>
Алхам 9	Нэг гараараа түлхэгчийг байранд нь хөдөлгөөнгүй болгоомжтой барина. Зураас (2) зүсэлтээс харагдаж эхлэх хүртэл гарын эрхий ба долоовор хуруугаар трокарийг буцааж, уг нь түлхэгчийн бариулд хүртэл татна. Капсулийг зөөлөн эд рүү шахахаас сэргийлэн түлхэгчийг хөдөлгөөнгүй барих шаардлагатай.
Алхам 10	Трокарийн уг түлхэгчийн бариулд хүрэхэд Зураас (2) зүсэлтээс харагдах бөгөөд капсул трокараас суллагдсан арьсан дор байрласан байна. Капсулын үзүүр трокарийн үзүүрээс суллагдсан эсэхийг хуруугаараа тэмтэрч шалгана. Хэрэв капсул суллагдаагүй бол трокарийг үргэлжлүүлэн хойш нь татаж, гэхдээ түүнийг зүсэлтээс бүрэн гаргахаас болгоомжил капсулын үзүүрийг чөлөөлнө. Капсулын дээрх арьсны гадаргуугаас эсрэг үйлдэл хийх нь нэмэр болж болно.
Алхам 11	Трокарийг бүрэн гаргалгүйгээр, шуун дээрх дэвүүр хэлбэртэй тэмдэглэлийн дагуу 15 градус өнцөгт шилжүүлэн явуулна. Суулгагч нь солгой биш бол трокарийг баруун тийш, солгой бол зүүн тийш шилжүүлнэ. Үүнийг хийхийн тулд эхний суулгасан капсулыг долоовор

	хуруугаар дарж, трокарийг энэ хурууны хажуугаар урагш зөөлөн чиглүүлж Зураас (1) зүсэлтийн ирмэгт тултал явуулна. Энэ үйлдэл нь капсул бүрийн хооронд тодорхой хэмжээний зайг үүсгэн, өмнө тавьсан капсулуудыг трокараар цоолохоос сэргийлдэг юм. Дараагийн капсулыг трокарьт хийж, бүх капсулуудийг суулгаж дуустал дээрх үйлдлүүдийг давтан хийнэ.
Алхам 12	Капсулуудийг буцаж гарахаас сэргийлж тэдгээрийг зүсэлтийн ирмэгээс 5 мм-ээс дээш зайд тавьсан байна. Мөн капсулын зүсэлтэнд ойр үзүүрүүд нь хоорондоо нэг капсулын өргөнөөс ихгүй зайтай байх шаардлагатай. Капсул зүсэлтээс цухуйсан эсвэл зүсэлтэнд хэт ойрхон тавигдсан тохиолдолд түүнийг гарган авч дахин зөв тавих шаардлагатай.
Алхам 13	Зургаан капсулыг суулгах явцад трокарийг зүсэлтээс гаргахгүй байхыг хичээ. Трокарь гарахаас урьдчилан сэргийлэх нь эдийн гэмтэл, халдвар орох эрсдлийг бууруулж суулгац тавих хугацааг богиносгоно. Трокарийг гаргаж авахаас өмнө зургаан капсул бүгд тавигдсан эсэхийг шалгана.
Алхам 14	Трокарийг болгоомжтой гарган авч, зүсэлт хийсэн газарт хөвөн тавьж хуруугаараа нэг минут орчим даран, гарч буй цусыг тогтооно. Зүсэлтийн эргэн тойрны талбайг антисептик уусмалаар арчин хөвөнгөөр цэвэрлэнэ.
Алхам 15	Зүсэлтийн хоёр ирмэгийг нийлүүлэн зориулалтын шархны лент эсвэл ариун боолт тавьж зүсэлтийг хаана. Оёдол тавих нь сорвижилтыг ихэсгэж болох тул шаардлагагүй. Цус гарч байгаа эсэхийг шалгана. Суулгац тавьсан газрыг самбайгаар дарж, цус гарч байгаа эсэхийг хянана, хөхрөлтийг багасгах зорилгоор шархны гадуур шууг ороосон боолт хийнэ.
Алхам 16	Бохирдсон багажийг халдваргүйжүүлэх зорилгоор бээлийгээ тайлахаас өмнө тэдгээрийг 0.5% хлорын шохойн уусмалд хийнэ. Түлхэгчийг трокараас салгаж уусмалд хийнэ. Багажийг уусмалд 10 минут байлгана. Төмөр багажны өнгө хувирч зэврэхээс сэргийлэн уусмалаас гаргасны дараа шууд цэвэр усаар зайлна.
Алхам 17	Үйлчлүүлэгчийн хяналтын дэвтэрт суулгацын байршил ба суулгац тавих явцыг тайлбарласан тэмдэглэл хийнэ.
Алхам 18	Зүсэлтээс цус гарах эсвэл хэвийн бус байдал үүсэх эсэхийг 15–20 хормын турш хянана.

**Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:**

Гаж нөлөө ба асуудал	Үнэлгээ	Авах арга хэмжээ
Биений юмгүйдэл	Жирэмсэн эсэхийг тогтооно.	Суулгац хэрэглэгчдийн 7%-д эхний жилд биений юмгүйдэл нь түр тохиолдох ба цаашдаа биений юм хэвийн байдлаар ирдэг. Бага тунтай прогестероны байнгын нөлөө умайн салстыг хатингаршуулж, биений юм бага хэмжээгээр ирэх, эсвэл зарим

		эмэгтэйд ирэхгүй болгодог. Жирэмсэн нь батлагдвал эмэгтэйн хүсэлтээр суулгацыг авна. Зулбасан эсвэл жирэмслэлтийг тасласан тохиолдолд суулгацуудыг авах шаардлагагүй. Умайн гаднах жирэмсэн сэжиглэгдэж буй тохиолдолд эмэгтэйг шилжүүлнэ.
Цус алдах	Цус алдалтыг үүсгэж болох бусад шалтгаануудыг тодорхойлно.	Бэлгийн замын эмгэг өөрчлөлт илэрсэн тохиолдолд зохих эмчилгээг хийнэ. Эмэгтэйг санаа зовоосон мөчлөгт бус цус алдалт ихэнх тохиолдолд 6-12 сарын дараа харьцангуй тогтмол горимд шилждэг. Өгсөн зөвлөгөө ба баталгаанд үйлчлүүлэгч сэтгэл ханамжгүй байгаа боловч үргэлжлүүлэн хэрэглэхийг хүсч байгаа тохиолдолд дараах 2 эмчилгээний аль нэгийг сонгоно: <ul style="list-style-type: none"> <li>• Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эмийг эмэгтэйд уулгах (30-35µg этинил эстрадиол) эсвэл</li> <li>• Ибупрофен 400 мг-аар өдөрт 3 удаа, 5 өдрийн турш, эсвэл үрэвслийн эсрэг үйлчилгээтэй стероид бус бусад эмүүд</li> </ul>
Суулгацууд ил гарах	Суулгацууд бүрэн ба хагас гадагшилсан эсэхийг шалгана.	Хагас цухуйсан суулгацуудыг авч хаяна. Үлдсэн суулгацууд байрандаа байгаа эсэхийг шалгана. Суулгацууд тавьсан газар халдварлагдаагүй тохиолдолд нэмж нөхөн суулгана.
Суулгац тавьсан газарт халдвар орсон	Суулгац тавьсан газарт халдвар орсон идээт буглаа үүссэн эсэхийг шалгана.	Халдварын буглаа үүсээгүй, халдварлагдсан тохиолдолд: <ul style="list-style-type: none"> <li>✓ Талбайг антисептик уусмалаар цэвэрлэнэ.</li> <li>✓ 7 хоног антибиотик уулгана.</li> </ul> Суулгацуудыг бүү ав. Үйлчлүүлэгчийг долоо хоногийн дараа дахин үзэж, байдал сайжраагүй тохиолдолд суулгацуудыг авна. Нөгөө гарт шинэ бүрдэл суулгац суулгах, эсвэл өөр арга сонгоход нь тусална. Идээт буглаа үүссэн тохиолдолд: <ul style="list-style-type: none"> <li>✓ Талбайг антисептик уусмалаар арчиж цэвэрлэнэ</li> <li>✓ Зүсэлт хийх</li> <li>✓ Суулгацуудыг авах</li> <li>✓ Шархыг цэвэрлэх</li> <li>✓ 7 хоног антибиотик уулгана.</li> </ul>
Хэвлийн доод хэсэгт болон бага аарцгийн	Асуумж авах Судасны цохилт Цусны даралт Биеийн халуун	Дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрсэн тохиолдолд эмэгтэйг шууд шилжүүлнэ: <ul style="list-style-type: none"> <li>▪ Хэвлийгээр хүчтэй өвдөх</li> <li>▪ Судасны лугшилт олшрох</li> </ul>

орчмоор өвдөх	Гемоглобин, гематокрит тодорхойлох	<ul style="list-style-type: none"> <li>▪ Артерийн даралт буурах</li> <li>▪ Халуурах</li> <li>▪ Хүнд хэлбэрийн цус багадалт:             <ul style="list-style-type: none"> <li>○ гемоглобин <math>\leq 9</math>г/дл эсвэл</li> <li>○ гематокрит <math>\leq 27</math></li> </ul> </li> </ul>
	Хэвлий, үтрээний үзлэг хийнэ:	Суулгацтай зарим эмэгтэйн өндгөвчид уйланхай үүсч, зарим тохиолдолд тэдгээр нь буцаж шимэгдэх явц удааширдаг. Ийм өөрчлөлт ихэвчлэн Норплант хэрэглэж эхэлсэн эхний 6 сард үүсдэг. Зовуургүй боловч ихэвчлэн үтрээний үзлэгийн үеэр гтэмтрэгддэг. Ихэнх тохиолдолд томорсон фолликулууд яваандаа арилдаг бөгөөд эмчилгээ хийх эсвэл суулгацуудыг авах шаардлагагүй.
“суулгацууд алдагдагда”	Суулгацуудыг арьсан дор хэт гүн суулгасан, 6-аас цөөн тооны суулгац суулгасан, эсвэл суулгацууд буцаж гарсныг эмэгтэй анзаараагүй байж болно.	Рентген, хэт авианы оношлогоогоор суулгацуудын байрлалыг зарим тохиолдолд олж болно.
Биеийн жин нэмэгдэх, хасагдах	Суулгац тавиулахын өмнөх үеийн жинг одоогийн жинтэй нь харьцуулна.	Биеийн жинд 1-2 килограммын хэлбэлзэл үүсч болохыг тайлбарлаж өгнө.

**Суулгацыг авах:** Дараах багаж тоног төхөөрөмж шаардлагатай.

- Эмэгтэйг хэвтүүлэх үзлэгийн ор
- Гарын тавиур, эсвэл ширээ
- Гар угаах саван
- Мэс заслын ариутгасан хуурай даавуу
- Ариутгасан 3 сав
- Мэс заслын ариун нэг хос бээлий
- Хэсгийн мэдээ алдуулах лидокайн 1%-ийн уусмал
- Тариур 22 G зүү
- Мэс заслын #11 иртэй хутга
- Тахир ба тэгш хавчуур
- Шархны лент
- Үйлчлүүлэгч суулгацыг үргэлжлүүлэн хэрэглэх хүсэлтэй байгаа тохиолдолд суулгацын өөр шинэ бүрдлийг бэлтгэх



## Суулгац авах

Алхам 1	Үйлчлүүлэгчийн гарыг бүхэлд нь савандаж угаан, сайн зайлж савангийн хөөсийг арилгана
Алхам 2	Эмэгтэйг үзлэгийн орон дээр хэвтүүлж суулгац тавьсан гарыг тавиур, эсвэл ширээн дээр чөлөөтэй тэнийх, эсвэл бага зэрэг нугалж болохоор байрлуулна.
Алхам 3	Бээлий өмсөхөөс өмнө 6 суулгацыг тэмтэрч байрлалыг тогтоогоод, суулгацуудын хоёр талын үзүүрүүдийг үзгээр тэмдэглэнэ.
Алхам 4	Арьсыг антисептик уусмалаар арчиж бэлтгэнэ. Хэсгийн мэдээ алдуулагчийг зүсэлт хийх газарт, авах гэж буй суулгацуудын үзүүрүүдийн <u>доогуур</u> хийнэ. Мэдээ алдуулагчийг суулгацуудын дээгүүр хэзээ ч бүү хий. Учир нь хавдсан арьсны гадаргуугаас суулгацын байршлыг олоход хүндрэлтэй болдог. Хэсгийн мэдээ алдуулагчийн хортой нөлөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд эпинефрингүй (адреналингүй) 1% -ийн 10мл-ээс илүүгүй хэмжээгээр хэрэглэнэ.
Алхам 5	Тохой талаас ижил 5 мм зайд доошоо (тохой руу) байрласан бүх суулгацуудын үзүүрийг олж тэмдэглэнэ. Скальпелиар 4 ммба түүнээс богино хэмжээгээр хөндлөн зүснэ. Битгий урт зүс.
Алхам 6	Эхлээд арьсны гадаргуу, эсвэл зүсэлтэнд хамгийн ойр байгаа суулгацыг сонгоно. Суулгацын үзүүрийг зүсэлтний нүхээр харагдаж эхэлтэл зүсэлтийн зүг болгоомжтой түлхэнэ. Энэ үед муруй хавчуурын үзүүрийг дээш нь харуулан зүсэлт рүү оруулж суулгацны үзүүрийг хавчина.
Алхам 7	Суулгацны үзүүрүүдийн эргэн тойрон наалдац үүссэн бол татахад хүндрэлтэй байх тул дараах аргаар наалдцыг салгаж болно: Муруй хавчуурын үзүүрийг дээш харуулж зүсэлт рүү оруулан тохойд хамгийн ойр байрлаж буй суулгацуудын үзүүр дор ортол урагш нь явуулна. Дараа нь суулгацын үзүүрийн эргэн тойрон дахь наалдцыг салгах зорилгоор хавчуурыг онгойлгож хаана. Бүх суулгацуудыг хялбар авч болох хүртэл энэ үйлдлийг давтан хийнэ. Эхэнд авах суулгацын үзүүрийг зүсэлт рүү аль болох ойртуулж түлхэнэ. Суулгацыг нэг гарын долоовор ба дунд хуруугаар хөдөлгөөнгүй тогтоож, нөгөө гараар муруй хавчуурыг үзүүрийг нь дээш харуулан зүсэлт рүү дахиж оруулна. Хавчуурыг суулгацын үзүүр дор байрлуулж, суулгацын үзүүрээс чимхэн, зүсэлтийн зүг зөөлхөн татна.
Алхам 8	Суулгацын үзүүрийг ил гаргахын тулд түүнийг тойрсон ширхэглэг эдийг ариутгасан самбайгаар цэвэрлэж онгойлгоно. Суулгацыг тойрсон ширхэглэг эдийн уутыг цэвэрлэж, онгойлгох боломжгүй тохиолдолд муруй хавчуур эсвэл мэс заслын хутга хэрэглэж болно. Суулгацыг огтлохоос сэргийлж хутганы иргүй талыг ашиглана.
Алхам 9	Суулгацын ил гарсан үзүүрийг хоёр дахь хавчуураар барьж хавчина. Эхний хавчуурыг суллаж, хоёр дахь хавчуураар суулгацыг зөөлөн,

	татаж гаргана. Силикон резинд эд эс наалддаггүй учир суулгац амархан гулгаж гадагшлах ёстой. Хялбар гарахгүй байвал үлдсэн ширхэглэг эдийг ариутгасан марлиар зөөлөн арчиж, эсвэл хутганы ирээр ховхолж суулгацнаас салгана.
Алхам 10	<ul style="list-style-type: none"> <li>- Авахад амархан харагдаж буй дараагийн суулгацыг сонгож, гаргана. Үлдсэн суулгацуудыг дээрхтэй адил аргаар авна.</li> <li>- Ажилбарыг дуусгахын өмнө зургаан ширхэг суулгац авсан эсэхийг баталгаажуулж, тэдгээрийг тоолно.</li> <li>- Суулгацуудыг аваад 0.5% хлорын шохойн уусмалтай жижиг саванд хийж халдваргүйжүүлээд хаяна.</li> </ul>
Алхам 11	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгч шинэ суулгац тавиулахыг хүсэхгүй байгаа тохиолдолд зүслэг хийсэн талбайг антисептик уусмалаар арчиж цэвэрлэнэ. Хавчуур ашиглан зүслэтийн хоёр ирмэгийг нийлүүлж түр хугацаанд барина. Энэ нь зүслэлт хийсэн газраас гарч буй цусыг тогтоох зорилготой.</li> <li>- Зүслэтийн хоёр амсрыг нийлүүлсэн байдлаар шархны лент наах эсвэл ариутгасан самбайгаар бооно. Сорвижилтыг нэмэгдүүлэх тул оёдол тавих шаардлагагүй. Цус гарч байгаа эсэхийг шалгана.</li> <li>- Их хэмжээний хөхрөлт үүсэхээс урьдчилан сэргийлж, даралттай боолт хийнэ. Зүслэлт хийсэн талбайг цэвэр, хуурай байлгана.</li> </ul>

#### **Шархыг гэртээ хэрхэн арчлах талаар үйлчлүүлэгчид өгөх зөвлөмж:**

- Зүслэлт хийсэн газар хөхрөх, хавдах, хөндүүрлэх зэрэг зовиур хэд хоногийн туршид ажиглагдаж болно.
- Зүслэг тойрсон талбайг 48 цагийн туршид хуурай цэвэр байлгана. Усанд орох үеэр шарх норвол халдвар орох боломжтой.
- Даралттай боолтыг 48 цаг, шархны лент ба мэс заслын боолтыг зүслэлт эдгэртэл 3-5 хоног байлгана.
- Өдөр тутмын ажлаа үргэлжлүүлэн хийж болно. Харин шархыг цохих, суулгацтай гараар хүнд юм өргөх, шарханд даралт учруулахаас болгоомжилбол зохино.
- Шархыг эдгэрсний дараа уг талбайд хэвийн даралт учруулж, хүрч, угааж болно.
- Халуурах, үрэвсэх зэрэг халдварын шинж илрэх, эсвэл олон хоногийн турш гар өвдөх тохиолдолд эмнэлэгт буцаж ирж үзүүлэх шаардлагатай.

## ЗУРГАА: ЗЭС АГУУЛСАН ЕРӨНДӨГ

Манай оронд зэс агуулсан "Cu T-380A" ерөндгийг өргөнөөр хэрэглэдэг. Сүүлийн үед "MLCu-375 Multiload" ба даавар бага тунгаар агуулсан ерөндгүүдийг хэрэглэж байна. Ерөндөг нь удаан хугацааны туршид жирэмслэхээс хамгаалах өндөр үр дүнтэй арга юм.

Ерөндөг нь үзүүр хэсэгтээ утсан учигтай, учигны үзүүр нь умайн хүзүүгээр дамжин үтрээнд унжсан байдалтайгаар байрладаг. Хэрэглэгч учгийг тэмтэрч ерөндөг байрандаа байгаа эсэхийг шалгаж болно. Үйлчилгээ үзүүлэгч учгийг хавчуураар хавчин, зөөлөн татаж ерөндгийг авч болно.

**Ерөндгийн үйлчлэх механизм:** Зэс агуулсан ерөндөг нь жирэмслэхээс хамгаалах уух эмийн адил олон төрлийн үйлчилгээтэй. Ерөндгийн гол үйлчилгээ нь умайн хөндийд эр бэлгийн эсийг хөдөлгөөнгүй болгох, эр бэлгийн эсийг үр дамжуулах сувагт орон эм бэлгийн эстэй нийлэхээс сэргийлэх, үр тогтсон өндгөн эс умайн салстад бэхлэгдэхэд саад учруулдаг.

**Үр дүн:** Ерөндөг нь өндөр үр дүнтэй арга бөгөөд хэрэглэж эхэлсэн эхний жилд 100 эмэгтэй тутмын 1 нь жирэмсэлж болзошгүй.

### Ерөндөг хэрэглэхийн давуу тал:

- ✓ С Т-380А ерөндөг нь удаан хугацаанд үйлчилнэ. Дааврын гаж нөлөө болон аливаа эмийн үйлчилгээнд нөлөө үзүүлэхгүй.
- ✓ Ерөндөг хэрэглэхтэй холбоотой анхаарвал зохих зүйл бага.
- ✓ Бэлгийн харьцаанд нөлөөлөхгүй.
- ✓ Ерөндгийг хүссэн үедээ авахуулж болно. Ерөндгийг авахуулмагц жирэмслэх чадвар сэргэнэ. Хөхний сүүний гарц ба чанарт нөлөөлөхгүй.
- ✓ Цэвэрших хүртэл хэрэглэж болно.

### Ерөндөг хэрэглэхийн сул тал:

- ▶ Биений юмны өөрчлөгдөх - Биений юм удаан хугацаагаар үргэлжлэх, их цус гарах, биений юмны мөчлөгийн дунд үед цус алдах, цусархаг ялгас гарах, биений юм өвдөлттэй ирэх гэх мэт өөрчлөлт эхний 3 сард элбэг тохиолдох бөгөөд цаашид хэвийн байдалд эргэн орно.
- ▶ Ховор тохиолдолд:
  - Ерөндөг тавиулаад 3-5 хоног өнгөрөхөд хүчтэй өвдөлт хэвээр байх
  - Биений юм ирэх үед цус ихээр алдах, мөчлөгийн дунд үед цус, эсвэл цусархаг ялгас гарснаас цус багадалт үүсэх
  - Умайн хана цоорох хүндрэл үүсэх ба ерөндгийг зөв суулгаж байгаа үед маш ховор тохиолдоно.
- ▶ БЗДХ/ХДХВ/ДОХ-аас хамгаалахгүй. Ерөндөг нь БЗДХ-тай ба бэлгийн олон хавьтагчтай эмэгтэйд зохимжгүй арга.
- ▶ БЗДХ-тай эмэгтэй ерөндөг хэрэглэснээр аарцгийн эрхтнүүдийн үрэвсэл үүсгэж энэ нь үргүйдэлд хүргэж болно.

- ▶ Ерөндөг суулгасны дараа хэвлийгээр өвдөх, цус алдах, цусархаг ялгадас гарах зэрэг шинж тэмдгүүд үүсч болох ба нэг, хоёр хоногийн дараа аяндаа арилна.
- ▶ Эмэгтэй өөрөө ерөндгийн утсыг тэмтэрч, ерөндөг байрандаа байгаа эсэхийг шалгана. Ерөндөг нь эмэгтэйд мэдэгдэхгүйгээр умайгаас унаж болно.

**Ерөндөг хэрэглэх нь:**

1. Жирэмслэхээс хамгаалах удаан хугацааны арга хэрэглэхийг хүсч байгаа эмэгтэй.
2. Хоёр ба түүнээс дээш тооны хүүхэдтэй болон хөхүүл эмэгтэй.
3. 35-аас дээш настай ба өдөрт 15 ширхгээс цөөнгүй тооны тамхи татдаг эмэгтэй.
4. БЗДХ авах эрсдэл багатай.

**Ерөндөг хэрэглэхэд тохиромжгүй нөхцөл:**

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Жирэмсэн	Жирэмсэн эсэхийг найдвартай тогтоох
Бага аарцгийн эрхтний үрэвсэлтэй.	Өвчтөн эдгэрч, эд эрхтэн хэвийн байдалд эргэн орох хүртэл уг эмэгтэй жирэмслэхээс хамгаалах өөр аргыг 3 сарын туршид хэрэглэнэ.
Үр хөндөлт/төрсний дараах үед умайн салст давхаргын үрэвсэл үүссэн	Өвчтөн эдгэрч, эд эрхтэн хэвийн байдалд эргэн ортол уг эмэгтэй жирэмслэхээс хамгаалах өөр аргыг 3 сарын туршид хэрэглэнэ.
Шалтгаан тодорхойгүй үтрээний цус алдалт (сүүлийн 3 сарын туршид тогтмол бус цус алдалт үүссэн, биеийн юмны дунд үе ба бэлгийн харьцаанд орсны дараа цус гарах)	Үтрээний цус алдалтын шалтгааныг тогтоож, ерөндөг тавихаас өмнө бүрэн эмчилсэн байх шаардлагатай.
Үтрээний үрэвсэл, мөөгөнцөр, нянгийн вагиноз	Үтрээний үрэвсэл байгаа тохиолдолд ерөндөг тавихаас өмнө уг үрэвслийг эмчилнэ.
Умайн хоргүй хавдартай, эсвэл умайн гаж хөгжилтэй	Болгоомжтой тавина.
Умайн хүзүүний хэт нарийсал	Хэсгийн мэдээ алдуулалт хэрэглэн умайн хүзүүг тэлж ерөндөг тавина.

**Ерөндөг тавих хугацааг товлох:**

Эмэгтэйн биеийн байдал	Хэзээ тавих
Биеийн юмны хэвийн мөчлөгтэй эмэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>• Жирэмсэн биш бөгөөд хэвийн умайтай гэдэг нь батлагдсан тохиолдолд мөчлөгийн аль ч үед ерөндөг тавьж болно.</li> <li>• Биений юм ирж байгаа үед ерөндөг тавихад дараахь сул тал ажиглагдаж болно. Бага аарцгийн хөндийн эрхтнүүдийн үрэвслийн улмаас үүссэн өвдөлтийг</li> </ul>

	биений юм ирэх үеийн өвдөлттэй андуурч болно. Мөн умайн хүзүүнээс гарч байгаа ялгадас нь биений юмны цусаар далдлагдаж болно. Бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчин байгаа тохиолдолд эмэгтэйд ерөндөг тавьж болохгүй.
Хүүхэд төрүүлсний дараа	<ul style="list-style-type: none"> <li>• Төрсний дараа 4 долоо хоногоос хэтрэлгүй ерөндөг тавих нь тохиромжтой.</li> </ul>
Зулбалт, үр хөндөлтийн дараа	<ul style="list-style-type: none"> <li>• Халдвар аваагүй тохиолдолд шууд тавьж болно.</li> <li>• Халдвар авсан бол өвчнийг эмчилж, бусад ЖСАХ арга сонгоход нь тусална. 3 сарын дараа халдвар бүрэн эмчлэгдсэн, жирэмсэн биш тохиолдолд ерөндгийг тавьж болно.</li> </ul>
Жирэмслэхээс хамгаалах өөр арга хэрэглэхээ болих үед	Шууд тавина.

### Соррег Т 380А ерөндгийг тавих заавар:

Уг ажилбарыг гүйцэтгэхдээ халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөнө.

Алхам 1	эмэгтэйд уг ажилбарын тухай тайлбарлан, ойлгосон эсэхийг асууж бататгана.и. Ерөндөг тавихаас өмнө эмэгтэй шээж, давсгаа сулласан байх шаардлагатай.
Алхам 2	<p><b>Гадна бэлэг эрхтэнд үзлэг хийх:</b> Яр, шархлаа, цавь орчмоор хавдсан эсэхийг шалгана. Бартолины ба Скений булчирхай орчимд эмзэглэл, хаван үүссэн, ялгадас байгаа эсэхийг шалгана.</p> <p><b>Үтрээнд толь тавьж үзлэг хийх:</b> Үтрээний ялгадас, умайн хүзүүний үрэвсэл, шээсний сүвнээс ялгадас гарч байгаа эсэхийг шалган, шаардлагатай гэж үзвэл ялгадаснаас наац авч шинжилнэ.</p> <p><b>Үтрээний үзлэг хийх</b> Умайн хэмжээ, байрлал, цуллаг байдал, хөдөлгөөн, эмзэглэл байгаа эсэхийг тогтооно. Умайн хүзүүг хөдөлгөхөд эмзэглэлтэй, умайн дайвар болон арын хүнхрээнд үүсгэвэр, өвдөлт байгаа эсэхийг шалгана.</p>
Алхам 3	<p><b>Шаардлагатай ба боломжтой үед шинжилгээ авч бичил харуураар харах.</b> Мөөгөнцөр, трихомониаз, нянгийн вагиноз, заг хүйтэн байгаа эсэхийг магадлана. <i>Үтрээний үрэвсэл байгаа тохиолдолд ерөндөг тавихын өмнө эмчилнэ. Заг хүйтэн сэжиглэгдэж байгаа тохиолдолд өвчтөнийг бэлгийн хавьтагчтай нь цуг эмчилж, дахин үнэлгээ өгнө. Үзүүлэлтүүд хэвийн болж, дахин халдвар авах эрсдэл бага болтол ерөндөг тавьж болохгүй.</i></p>
Алхам 4	<b>Соррег Т 380А Ерөндгийг ариун уут дотор нь угсарна.</b>

	Ерөндөг тавихаас 5 минутаас илүү хугацааны өмнө түүнийг угсарч болохгүй. Эрт угсарвал ерөндөг хэвийн хэлбэртээ эргэж орохгүй болно. Ерөндгийн үзүүр, суулгагч хоолой дахь шахагч цагаан гуурс хоёрын хооронд 1-2 см зай байгаа эсэхийг магадал.
Алхам 5	<b>Үтрээнд толь тавьж умайн хүзүү, үтрээг цэвэрлэнэ.</b> Умайн хүзүү болон үтрээг антисептик уусмалаар сайн цэвэрлэнэ. Зөвхөн шаардлагатай үед хэсгийн мэдээ алдуулалт хийнэ.
Алхам 6	<b>Умайн байршил ба хэмжээг тогтоох зорилгоор умайн хөндийг сэтгүүрдэнэ.</b>
Алхам 7	<b>Соррег Т-380А Ерөндгийг тавина.</b> Умайн хөндийн уртын хэмжээнд тохируулан ерөндөг тавигч гуурсан дээрх хэмжигчийг тохируулна. Угсарсан ерөндгийг умайн хүзүүний суваг руу болгоомжтой хийж, хэмжигч умайн хүзүүнд шүргэх хүртэл явуулна. Эсэргүүцэл мэдрэгдмэгц зогсоох хэрэгтэй. <i>Эсэргүүцэл тулгарахад хүч бүү хэрэглэ.</i> Шахагч цагаан гуурсыг хөдөлгөөнгүй барьж, суулгагч хоолойг шахагчийн төгсгөл рүү хойш нь удаан татна. Гуурс болон шахагчийг умай руу нь цааш нь түлхэж болохгүй. Суулгагч хоолойг байранд нь тогтоож, цагаан гуурсыг сугална. Суулгагч хоолойг болгоомжтой дотогшоо (дээшээ) түлхэж ерөндөг умайд өндөр тавигдсаныг шалгана. Суулгагч хоолойг сугалан авч, утаснуудын үзүүрүүдийг 3-4 см урттай үлдээж хайчилна. Эсвэл хавчуураар утаснуудыг умайн хүзүүнээс 3-4 см зайд хавчиж, тайрна.
Алхам 8	<b>Бээлийг тайлахаас өмнө бохирлогдсон эд зүйлийг хаяна.</b> Цус, салиагаар бохирдсон даавуу болон бусад хог хаягдлыг таглаатай сав эсвэл уутанд хийж шатаана.
Алхам 9	<b>Ерөндгийн учиг утсыг хэрхэн шалгахыг эмэгтэйд зааж өгнө.</b> <b>Ерөндөг тавьсны дараа үйлчлүүлэгчийг 15-30 хором ажиглана.</b> Хүчтэй өвдөлт, дотор муухайрах, ухаан алдах, тэдгээр нь аспирын, ибупорфен, индометацин зэрэгт намдахгүй байгаа тохиолдолд ерөндгийг буцааж авах шаардлага гарч болно.

**Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:**

Гаж нөлөө, асуудал	Үнэлгээ	Авах арга хэмжээ
Ерөндөг суулгах, авах үед ухаан балартах, Орхний цохилт цөөрөх, судас	Эмэгтэй амархан сандардаг уу? Сэтгэл зовних тохиолдолд ухаан балартдаг уу? Умай жижиг, умайн	Ерөндөг тавих ба авах ажилбарыг аядуу, зөөлөн хийх ёстой: • Өвдөлт намдаах эм уулгаж болно. • Умайн хүзүүний нарийсалтай тохиолдолд умайн хүзүү орчимд

<p>мэдрэлийн хямрал үүсэх.</p>	<p>хүзүүний нарийсалтай байсан эсэх?</p>	<p>өвдөлт намдаах хориг хийх нь зүйтэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ухаан балартах шинж тэмдэг илэрмэгц ажилбарыг зогсооно.</li> <li>• Ерөндгийг умайн хүзүүний сувгаар оруулах үед хүчтэй өвдөлт үүсвэл ажилбарыг түр зогсооно. Эмэгтэйг гэдрэг харуулсан байдалд толгойг нь намсган, хөлийг нь өндөрлөж, тархины цусан хангамжийг нэмэгдүүлнэ.</li> <li>• Эрүүг түшиж, амьсгалын замыг байнга чөлөөтэй байлгана. Хүзүүнээс хэт татаж болохгүй. Бариу ялангуяа хүзүү, хоолой барьсан хувцсыг тайлна.</li> </ul>
<p>Умайн цооролт сэжиглэгдэж байгаа</p>	<p>Ажилбарын явцад үйлчлүүлэгч гэнэт хүчтэй өвдөлт үүслээ гэж зовиурлана.</p>	<p><b>Умайг зондлох үед:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажилбарыг зогсооно. Дотуур цус алдалтын шинж тэмдэг болох артерын даралт унах, судасны цохилт олшрох, хэвлийгээр хүчтэй өвдөх, хэвлийн гялтангийн цочролын шинж тэмдэг илрэх эсэхийг ажиглана. Артерийн даралт, судасны цохилтыг 15 хором тутамд, 90 хормын турш хэмжинэ.</li> <li>• Хоёр цагийн хугацаанд дээрх шинж тэмдэг илрээгүй тохиолдолд үйлчлүүлэгчид аюултай шинж тэмдгүүдийг хэлж өгөн, тэдгээрийг илэрсэн тохиолдолд эмнэлэгт яаралтай буцаж ирэхийг анхааруулна. Хэвийн байвал долоо хоногийн дараа ирж үзүүлэхийг зөвлөнө.</li> </ul> <p><b>Ерөндгийг суулгаж байх үед бүрэн ба бүрэн бус цооролт сэжиглэгдвэл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажилбарыг зогсооно. Ерөндгийг буцааж аваад дээрхтэй ижил арга хэмжээнүүдийг авна.</li> </ul>

**Үйлчлүүлэгчид сануулах нь:** Ерөндөг тавиулаад 3-6 долоо хоног өнгөрсний дараа \ биеийн юм ирсний дараа\ ирж үзүүлэхийг зөвлөнө. Үрэвсэл үүсэх, ерөндөг унах эрсдэл эхний сард элбэг тохиолдоно. Үзлэгээр эмэгтэйн биеийн байдал хэвийн байвал, цаашид 12 сард нэг удаа үзүүлэхийг зөвлөнө.

**Ерөндөг тавьсны дараа гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ:**

гаж нөлөө	Үнэлгээ	Авах арга хэмжээ
Ерөндөг умайн	Үйлчлүүлэгчээс дараах	Ерөндгийн утаснууд харагдаж байгаа,

хөндийд байгаа боловч биений юм ирэхгүй байгаа	<p>зүйлсийг тодруулна</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Сүүлийн биений юм хэзээ ирсэн,</li> <li>▪ Сүүлийн удаа учиг утаснуудыг хэзээ тэмтэрч үзсэн,</li> <li>▪ Жирэмсний шинж тэмдэг илэрч байгаа эсэх,</li> </ul> <p>Боломжтой бол жирэмсний сорил тавь. Үтрээнд толь тавьж үзлэг хийж утаснуудыг шалган, жирэмснийг үгүйсгэнэ.</p>	<p>жирэмснийг үгүйсгэсэн тохиолдолд зөвлөгөө өгнө.</p> <p><b>Жирэмсэлт:</b></p> <p>Умайн гаднах жирэмсэн болсон эсэхийг тодруулна.</p> <p>Жирэмсэлт сүүлийн сарын тэмдгийн байдлаар 13 долоо хоногоос бага, учиг утсууд харагдаж байвал бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчин болон зулбах эрсдлийг багасгах зорилгоор ерөндгийг авах шаардлагатайг тайлбарлаж, үйлчлүүлэгч зөвшөөрвөл ерөндгийг авна. Их хэмжээний цус гарах, өвдөх, эмгэг ялгадас гарах, халуурах тохиолдолд эмэгтэйд эргэж ирэхийг сануулна.</p>
Базлалт	Биений юмны өөрчлөлт, цус алдалт байгаа эсэхийг тодруулна.	<ul style="list-style-type: none"> <li>• Бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлт өвчний үед ерөндгийг авч, зохих эмчилгээг хийнэ.</li> <li>• Шалтгаан тодорхойгүй боловч, хүчтэй базлалттай үед ерөндгийг авна.</li> </ul>
Цус алдалтын хүнд хэлбэр	Сүүлийн биений юм хэзээ ирсэн, цус алдалт,, өвдөлт, жирэмсний шинж тэмдгүүд байгаа эсэх. Биений юмны мөчлөг тогтмол эсэх, хэвийнхээс өөрчлөгдсөн эсэх зэргийг үнэлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Төмрийн бэлдмэл өдөрт 1 ширхгийг гурван сарын туршид өгнө.</li> <li>• Цус алдалт ихэссэн, халдвар орсон, жирэмсэлсэн, үед, эсвэл эмэгтэй өөрөө хүсч байвал ерөндгийг авна.</li> <li>• Умайн гаднах жирэмснийг үгүйсгэнэ.</li> <li>• Цус алдсан үед ерөндгийг авч эмэгтэйд өөр арга сонгоход нь тусална.</li> </ul>
Жирэмслэлт болон архаг эмгэгээс шалтгаалаагүй үтрээний цус алдалт		<ul style="list-style-type: none"> <li>• Нөхцөл байдалд бүрэн үнэлгээ өгөх хүртэл ерөндгийг үргэлжлүүлэн хэрэглэх.</li> </ul>
Ерөндгийн утас үгүй болсон	<p>Эмэгтэйгээс ерөндөг унахыг мэдэрсэн эсэхийг асууна.</p> <p>Эмэгтэй мэдэхгүй байвал дараах зүйлүүдийг түүнээс асууна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн биений юм</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• эмэгтэй ерөндөг унасныг мэдэж байгаа тохиолдолд, жирэмсэн эсэхийг шалгана. Жирэмсэн биш тохиолдолд шинэ ерөндөг тавина.</li> <li>• Учиг харагдаж байвал үйлчлүүлэгчийг тайвшруулна.</li> <li>• Умайн гаднах жирэмсэн нь</li> </ul>



	<p>хэзээ ирсэн,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ерөндгийн учиг утаснуудыг хамгийн сүүлд хэзээ шалгасан,</li> <li>• Жирэмсний шинж тэмдгүүд байгаа эсэх,</li> <li>• Учиг утас байхгүйг мэдэрмэгц хамгаалалтын өөр арга хэрэглэж эхэлсэн эсэх,</li> </ul>	<p>тогтоогдвол эмчилнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Учиг байхгүй бол ерөндөг умайн хөндийд байгаа, умайг цоолон гарсан, унасан аль нь болохыг шалгаж тогтооно.</li> <li>• Оношилгооны явцад ерөндөг байхгүй бол мэдэгдэхгүй унасан байж болох юм. Шинэ ерөндөг тавих, эсвэл өөр арга сонгоход нь тусална.</li> <li>• Ерөндөг хэвлийн хөндийд байгаа тохиолдолд тэнд нь үлдээнэ.</li> </ul>
Эмэгтэйн бэлгийн хавьтагч ерөндгийн учигны талаар гомдол гаргах.	Ерөндөг байрандаа байгаа эсэхийг шалгана.	Ерөндгийн учиг зөөлөн бөгөөд ихэнх тохиолдолд умайн хүзүүний хажуу талаар байрладаг тул тэдгээрийг мэдрэх бараг боломжгүй байдгийг эмэгтэйд тайлбарлана. Учиг нь хэт урт байгаа бол богиносгож тайрна.
Үтрээний үрэвсэл	<p>БЗДХ, нөхөн үржихүйн замын бусад халдвартай байгаа эсэх</p> <p>Үтрээний үрэвсэл, умайн хүзүүний улайлт, шархлаа байгаа эсэх</p> <p>Грамын аргыг ашиглан лабораторийн оношлогоо хийх, боломжтой бол нойтон наац бэлтгэж шинжилнэ.</p>	Өгүүлэмжээр ноцтой өөрчлөлтгүй бол эмэгтэйд тайвшруулж, хэвийн бус ялгадасны талаар тайлбарлаж өгнө. Үтрээний үрэвсэл, умайн хүзүүний үрэвсэл, бага аарцгийн эрхтний үрэвсэл илэрвэл эмчилнэ.
Бага аарцгийн хөндийн эрхтнүүд, үтрээ, умайн хүзүүний үрэвсэл	<p>Бага аарцгийн үрэвсэлт өвчнөөр өвчилж байсан эсэх талаар асууж лавлана.</p> <p><i>Шээсний сүв, умайн хүзүүний үрэвсэл байгаа үед - ЕРӨНДГИЙГ АВ.</i></p>	<p>Үзлэг, лабораторийн шинжилгээгээр БАЭҮ болон умайн хүзүүний үрэвсэл батлагдсан бол ерөндгийг авна.</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Халуун 38.3° С ба түүнээс их.</li> <li>▪ Умайн хүзүү болон үтрээнээс хэвийн бус ялгадас гарч байгаа.</li> <li>▪ Умайн хүзүүг хөдөлгөхөд эмзэглэлтэй Умайн дайвар орчмоор эмзэглэлтэй</li> <li>▪ Бэлгийн хавьтагчийн нь шээсний сүвээс эмгэг ялгадас гарч байгаа, эсвэл заг хүйтний эмчилгээ хийлгэж байсан.</li> </ul>

Умайн хүзүүний шархлаа	Умайн хүзүүний шархлаа болон умайн хүзүүний бусад эмгэгээр өмнө өвдөж байсан эсэхийг лавлана.	<ul style="list-style-type: none"> <li>Умайн хүзүүний хуучин гэмтэл байгаа тохиолдолд сард нэг удаа, байдал тогтвортой болсон үед сараас дээш хугацаанд тогтмол үзэж байна.</li> <li>Умайн хүзүүний эсийн шинжилгээ хийх</li> </ul>
------------------------	---	---

**Copper T 380 A Ерөндгийг авах заавар:** Ажилбарыг гүйцэтгэхдээ халдвар хамгааллын дэглэмийг чанд сахих ёстой.

Алхам 1	Ажилбарын талаар үйлчлүүлэгчид тайлбарлан, асуулт асуухыг уриална.
Алхам 2	Үтрээнд толь тавьж умайн хүзүү болон ерөндгийн учиг утсыг харна .
Алхам 3	Антисептик уусмалаар умайн хүзүү болон үтрээний ханыг 2 ба түүнээс олон удаа сайтар арчиж цэвэрлэнэ.
Алхам 4	<p>Ерөндгийг авах гэж байгаагаа үйлчлүүлэгчид мэдэгдэнэ. Урт, гүнзгий амьсгалж, биеэ чөлөөтэй байлгахыг хүснэ. Базлалт үүсч болох бөгөөд энэ нь хэвийн үзэгдэл гэдгийг тайлбарлана.</p> <p><u>Ерөндөг авах хэвийн ажилбар</u></p> <p>Халдваргүйжүүлсэн эсвэл ариутгасан нарийн хавчуураар учиг утсуудаас аль болох умайн хүзүүнд ойр хавчиж, зөөлөн татна. Ихэнх тохиолдолд ерөндгийг амархан авч болдог ба нэмэлт хүч зарцуулах шаардлагагүй. Учиг тасрахаас сэргийлэн алгуур зөөлөн татаж ерөндгийг авна. Учиг тасарсан боловч ерөндөг харагдаж байгаа тохиолдолд түүнийг хавчуураар хавчин гаргана.</p> <p><u>Ерөндгийг авах явцад учирч болох бэрхшээл</u></p> <p>Утас харагдахгүй байгаа тохиолдолд жирэмсэн эсэхийг магадлана. Дараа нь умайн хүзүүг ариутгаад ариутгасан нарийн хавчуураар ерөндгийн учгийг умайн хүзүүний сувагт хайж үзнэ. Умайн хүзүүний сувагт учиг олдоогүй тохиолдолд ерөндгийн байршлыг тодорхойлж чадах туршлагатай мэргэжилтэнд хандахыг зөвлөнө.</p> <p>Та ерөндгийг бүрэн гаргахад бэрхшээлтэй боловч үйлчлүүлэгч тайван байгаа тохиолдолд эргүүлж, зөөлөн татна. Үттээний үзлэгээр умай, умайн хүзүү хоёрын хооронд хурц өнцөг (умай урагш хэт хазайсан) үүссэн байвал халдваргүйжүүлсэн эсвэл ариутгасан суман хавчуураар умайн хүзүүг хавчиж доош чиглэлтэй зөөлөн татахын сацуу ерөндгийг зөөлөн эргүүлж, доош татаж гаргана. Хүч бүү хэрэглэ.</p>
Алхам 5	Үйлчлүүлэгч хүсч байгаа, тохиромжтой нөхцөл бүрдсэн үед шинэ ерөндөг тавина.

**Гаж нөлөө:**

- Биений юм их удаан хугацаагаар үргэлжэх, их цус гарах
- Биений юмны мөчлөгийн дундуур үтрээнээс цусархаг ялгадас гарах, цус алдах
- Биений юм ирэх үеэр базлах, өвдөх **Ерөндөг тавихын өмнө эндокардит үүсэхээс урьдчилан сэргийлэх:**

**Эндокардитаар** өвчилж байсан, зүрхний хиймэл хавхлагатай, Фаллогийн дөрвөлсөн гажиг зэрэг хөхрөлт үүсгэдэг, зүрхний төрөлхийн хавсарсан өвчтэй эмэгтэйчүүд эндокардитаар өвчлөх эрсдэлтэй байдаг. Зүрхний төрөлхийн бусад эмгэгтэй (хүндрэл өгөөгүй тосгуур хоорондын гажиг үүнд хамаарахгүй), хавхлагын олдмол өвчтэй, зүрхний булчин хэт томорч зузаарсан, 2 хавтаст хавхлагын дутагдал үүсч цус эргэн урсдаг, эсвэл хавхлагын хавтас зузаарсан зэрэг өвчний үед эрсдэл нь дунд зэрэг байх болно. *Энтерококк* бэлгийн болон шээсний замд хийсэн ажилбаруудын дараа эндокардит үүсгэх нь элбэг байдаг.

Эмийн хэлбэр	Тун
Амоксициллин <sup>1</sup> уух	2 граммыг ажилбар эхлэхээс 1 цагийн өмнө уулгах
Ампициллин <sup>2</sup> тарих	2 граммыг ажилбар эхлэхээс 30 хормын өмнө булчинд эсвэл судсаар тарих
± Гентамицин ( <i>Гарамицин</i> болон бусад)	1.5 мг/кг (нийт 120 мг-ээс ихгүй) ажилбар эхлэхээс 30 хормын өмнө булчинд эсвэл судсаар тарих
<b>Пенициллинд харшилтай үед:</b> Ванкомицин (Ванкоцин, ба бусад)	1 граммыг ажилбар эхлэхээс 1 цагийн өмнөөс эхлэн судсанд <i>1цагийн туршид дулаар хийнэ.</i>
±Гентамицин	1.5 мг/кг (нийт 120 мш-ээс ихгүй) ажилбарыг эхлэхээс 30 хормын өмнө булчинд эсвэл судсаар тарих

1. Амоксицилин хурдан үйлчилдэг бөгөөд стрептококк болон энтерококк мэдрэг тул хэрэглэхийг зөвлөнө.
2. Эндокардит үүсэх өндөр эрсдэлтэй эмэгтэйчүүдэд гентамицин хэрэглэнэ. Ажилбар эхлэхээс өмнө ампициллин тариагаар хийсэн тохиолдолд ажилбар дуусаад 6 цаг өнгөрсний дараа 1 гр ампициллиныг судас, эсвэл булчинд тарих, эсвэл 1 гр амоксициллиныг уулгана.

## ДОЛОО. ДААВАР АГУУЛСАН ЕРӨНДӨГ

### Даавар агуулсан ерөндөг:

**Прогестерон Т:** 28 мг прогестерон агуулах ба хоногт 65 мкг прогестерон ялгаруулна. Нэг жилийн турш үйлчилнэ.

**Лиг 20- IUD: хоногт** 20 мкг левоногестролыг умай руу шууд ялгаруулж, 5 жилийн турш үйлчилнэ.

**Мирена:** даавар шууд умайн хөндий рүү ялгарч, хэсэг газрын үйлчилгээ үзүүлнэ. Мирена нь умайн хөндийд суулгагддаг даавар агуулсан бэлдмэл бөгөөд даавар нь тусгай мембраны тусламжтай хоногт тогтмол хэмжээгээр умайн хөндий рүү ялгарч байдаг.

### Миренагийн давуу тал:

- ✓ жилийн турш, полидиметилсилонон мембранаар хоногт 20 мкг даавар ялгарч, жирэмслэлтээс, найдвартай хамгаална.
- ✓ Умайн хүзүүний салстыг өтгөрүүлж, эр бэлгийн эс умайд нэвтрэн ороход саад учруулна.
- ✓ Эндометрийг хатингаршуулснаар үр хөврөл умайд бэхлэгдэх боломжгүй болно.
- ✓ Нөхөн үржихүйн чадвар эргэн сэргэнэ.

### Миренагаар эндометриозыг эмчлэх

- ✓ Левоноргестрел эндометриозын голомтын рецепторт хувиргах нөлөө үзүүлнэ. (эндометрт өндөр концентрацитай агуулагдах тул умайд ойр байрлалтай бага аарцагны бусад эрхтэнүүдэд нэвчин орно)
- ✓ Эндометрийг хатингаршуулснаар цус үрийн хоолойгоор дамжин хэвлий рүү хаягдах, өөрөөр хэлбэл эндометриоз үүсэх эрсдлийг багасгана.
- ✓ Хоёрдогчоор олигоменорея үүсч гэж гарах цусны хэмжээ багасна.
- ✓ Миренагийн эмчилгээний үр дүн нь биений юмгүйдэл үүссэн эсэхээс хамаарна.

## НАЙМ. ХАВСАРСАН ДААВАР АГУУЛСАН НААЛТ

Хавсарсан даавар агуулсан наалт нь эстроген, прогестрон бага тунгаар агуулах бөгөөд 3 долоо хоног арьсанд нааж, 1 долоо хоног завсарлана. Эстрадиол нь богино хугацаагаар харьцангуй сул үйлдэл үзүүлж, амархан задардаг байна. Ийм учраас эстроген – хамааралт гаж нөлөө нь тарьж хэрэглэхээс харьцангуй бага байдаг. Ortho Evra, Evra нэршлээр худалдаалагддаг. Гаж нөлөө, авах арга хэмжээ, хэрэглэх заалт зэрэг нь хавсарсан эмтэй адилхан .

## ЕС.ҮТРЭЭНИЙ ЦАГИРАГ

Хавсарсан даавар бага тунгаар агуулсан, үтрээнд 3 долоо хоногийн турш байрлуулж, жирэмслэхээс хамгаална. 4 дэх долоо хоногт үтрээнээс авна.

NuvaRing гэсэн нэршлээр худалдаалагдаж байна.

Өндгөвчнөөс өндгөн эс гадагшлахыг саатуулна. 100 эмэгтэй тутмын 1 нь л жирэмслэх боломжтой.

## АРАВ. САРЫН ТАРИА

Тарьж хэрэглэх 2 төрлийн бэлдмэл байдаг ба Циклофем нь медроксипрогестерон ацетат 25 мг, эстрадиол цепионат 5 мг, Месигина нь норэтистерон 50 мг эстрадиол валерат 5 мг тус тус агуулна. Бэлдмэлийг 4 долоо хоногийн зайтай, булчинд тарьж хэрэглэнэ. 97%-ийн үр дүнтэй.

## АРВАН НЭГ. ЭРЭГТЭЙ БЭЛГЭВЧ

**Тодорхойлолт:** Эрэгтэй бэлгэвч нь бэлгийн хавьтлын үед шодойд углаж хэрэглэдэг нимгэн бүрхүүл юм. Энэ нь үрийн шингэн болон БЗДХ үүсгэгчийг бэлгийн замд ороход саад учруулдаг.

**Эрэгтэй бэлгэвчний төрөл:** Олон улс орнуудад полиуретанаар хийгдсэн эрэгтэй бэлгэвчийг хэрэглэдэг. Энэ нь илүү нимгэн, бат бөх, сайн чанараа удаан хадгалах боловч резинэн бэлгэвчийг бодвол илүү үнэтэй. Нийлэг полиуретанан бэлгэвч нь резиний харшил үүсгэдэггүй, бэлгийн замын халдвар дамжихыг бууруулдаг.

Амьтны нарийн гэдсээр хийсэн эрэгтэй бэлгэвч нь вирусийг нэвтрүүлдэг учир вирусийн гаралтай бэлгийн замаар дамжих халдвараас хамгаалж чадахгүй.

**Эрэгтэй бэлгэвчний үйлчлэх механизм:** Бэлгэвч нь үрийн шингэн үтрээнд ороход саад учруулна. Бэлгэвчийг *бэлгийн хавьтал бүрд* эхнээс нь дуусах хүртэл хэрэглэсэн тохиолдолд л үр дүнтэй байна. Бэлгэвч нь ХДХВ/ДОХ ба бэлгийн замын бусад халдвараас хамгаалах хамгийн найдвартай хэрэгсэл юм.

**Үр дүн:** Зөв, тогтмол хэрэглэсэн тохиолдолд бэлгэвч нь жирэмслэхээс найдвартай хамгаалнана. Жирэмслэх магадлал 3 хувь байдаг. Энэ нь бэлгэвчийг нэг жилийн туршид зөв хэрэглэж буй 100 хос тутмын гуравт нь л хүсээгүй жирэмслэлт тохиолдоно гэсэн үг. Бэлгэвчийг зөв хэрэглэхэд туршлага зайлшгүй шаардлагатай байдаг. Бэлгэвч хэрэглэж эхэлсэн эхний жилд жирэмслэлт 14 хувь хүртэл тохиолдох боломжтой.

**Эрэгтэй бэлгэвчний давуу тал:**

- ✓ БЗДХ, ХДХВ/ДОХ, жирэмслэхээс хамгаална. Мөн бага аарцгийн эрхтний үрэвсэлт өвчний архаг өвдөлт, умайн хүзүүний хорт хавдар, эрэгтэй болон эмэгтэйн үргүйдэл үүсэх зэргээс сэргийлнэ.
- ✓ Төрөлт, зулбалт, үр хөндөлтийн дараа шууд хэрэглэж болно.
- ✓ Хөхний сүүнд нөлөөлөхгүй. Дааврын гаж нөлөө үзүүлэхгүй.
- ✓ Хүссэн үедээ бэлгэвч хэрэглэхийг зогсоож болно.
- ✓ Аль ч насны эрэгтэйчүүд хэрэглэхэд тохиромжтой.
- ✓ Хурдан тавихаас ихэнх тохиолдолд урьдчилан сэргийлнэ.

**Эрэгтэй бэлгэвчний сул тал:**

- ▶ Резинэн бэлгэвч нь резинд харшилтай зарим хүнд загатнаа үүсгэж болно. Зарим хүнд бэлгэвчийн чийгшүүлэгч бодис харшил өгч болно.
- ▶ Бэлгийн хавьтлын үед үүсэх мэдрэмж, бэлгийн таашаалыг бууруулж болзошгүй.
- ▶ Тогтмол, зөв хэрэглэх шаардлагатай. Үтрээ рүү шодойг хийхээс өмнө хөвчирсэн шодойд бэлгэвчийг углана.
- ▶ Бэлгэвчийн уутыг онгойлгох, бэлгэвчийг шодойд углах үеэр бэлгийн харьцаа завсардана.
- ▶ Бэлгийн харьцааны үед бэлгэвч мултарч, урагдаж болно.
- ▶ Бэлгэвчийг удаан, хэт халуун, нарны гэрэл шууд тусах ба хэт чийглэг орчинд хадгалсан, эсвэл тосон чийглэгч хэрэглэсэн тохиолдолд бэлгэвчний чанарт өөрчлөлт орж болно.
- ▶ Бэлгэвч худалдаж авах, бэлгийн хавьтагчаасаа бэлгэвч хэрэглэхийг хүсэх, бэлгэвчийг углах, авах, хаях нь зарим хүмүүст ичих болон эвгүй сэтгэгдэл төрүүлж болно.

**Эрэгтэй бэлгэвчийг хэрэглэх нь:**

- Жирэмслэхээс хамгаалах аюулгүй, найдвартай арга хэрэглэхийг хүсч буй, резиний хүнд хэлбэрийн харшилгүй ямар ч хүн бэлгэвч хэрэглэж болно.
- Бэлгэвч нь сөрөг нөлөө үзүүлэхгүй.
- БЗДХ-аас өөрийгөө хамгаалах хүсэлтэй аливаа хүн.

Санамж: Жирэмсэлт ба БЗДХ-аас найдвартай хамгаалахын тулд бэлгэвчийг тогтмол хэрэглэх шаардлагатай. Бэлгийн харьцаанд зөвхөн нэг удаа л хамгаалалтгүй ороход жирэмсэн болох эсвэл БЗДХ авч болно.

**Эрэгтэй бэлгэвчийг хэрэглэх заавар:**

1. Шодойг үтрээ рүү оруулахаас өмнө бэлгэвчийг хөвчирсэн шодойд углана:
  - Бэлгэвчний оройг шодойны эсрэг зүгт дээш нь харуулан барина.
  - Бэлгэвчийг шодойн оройд углана.
  - Бэлгэвчийг шодойн оройноос түүний суурь хүртэл хуйлаасыг нь тэнийлгэх хөдөлгөөнөөр шодойд углана. Бэлгэвчийн хуйлралт амархан тайлагдах ёстой.

- Буруу харуулж угласан тохиолдолд хуйлаасыг тайлахад хүндрэлтэй байдаг. Ийм үед бэлгэвчийг зөв тал руу нь эргүүлэн дахин углана. Харин БЗХ-аас хамгаалах зорилгоор бэлгэвч хэрэглэж байгаа тохиолдолд буруу углагдсан бэлгэвчийг хаяж, өөр шинэ бэлгэвч авч, зөв хэрэглэнэ.
2. Усан суурьтай чийгшүүлэгч бодисыг хэрэглэж болно. Чийгшүүлэгч бодис нь спермицид, глицерин болон тусгай бодисуудыг агуулсан байдаг. Эдгээр нь бэлгийн хавьтлын үед бэлгэвч урагдахгүй байхад тус нэмэртэй. Үтрээний ердийн ялгадас мөн ийм үйлчилгээ үзүүлнэ.
  3. Үрийн шингэн гарсны дараа бэлгэвчийн амсрыг шодойн уг руу татаж, бэлгэвч мултрахаас сэргийлнэ. Шодойн хөвчрөлт бүрэн сулрахаас өмнө эрэгтэй бэлэг эрхтнээ үтрээнээс гаргаж бэлгэвчийг мулталж авна.

**Бэлгэвч урагдсан тохиолдолд:** Жирэмслэхээс хамгаалах зорилгоор бэлгийн хавтлаас хойш 72 цагийн дотор яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм хэрэглэнэ.

**Гаж нөлөө үүссэн үед авах арга хэмжээ**

Гаж нөлөө	Авах арга хэмжээ
бэлэг эрхтэнд тууралт гарах, загатнах	<ul style="list-style-type: none"> <li>• Чийглэх зорилгоор ус хэрэглэхийг зөвлө.</li> <li>• Загатнаа үргэлжлэх тохиолдолд үйлчлүүлэгч (түүний хавьтагч нар) халдвар авсан эсэхийг тогтооно.</li> <li>• Зовуурь үргэлжилж байгаа тохиолдолд өөр арга сонгоход нь тусална. (Үйлчлүүлэгч БЗДХ аваагүй тохиолдолд).</li> </ul>
Бэлгэвчийг углах буюу хэрэглэж байх үед шодойн хөвчрөлт буух	<ul style="list-style-type: none"> <li>• Ихэнх тохиолдолд хэт санаа зовсноос болдог. Бэлгэвч хэрэглэх үед яаж илүү тааламж авах ба санаа зовохгүй байх талаар үйлчлүүлэгчтэй ярилцана. Жишээ нь: Эмэгтэй нь эрэгтэйдээ бэлгэвчийг углах замаар илүү тааламжтай байдлыг үүсгэж болно.</li> </ul>

## АРВАН ХОЁР. ЭМЭГТЭЙ БЭЛГЭВЧ

**Тодорхойлолт:** Эмэгтэй бэлгэвч нь ХДХВ/ДОХ/БЗДХ, хүсээгүй жирэмслэхээс хамгаалах зорилгоор эмэгтэйн үтрээнд хийж хэрэглэдэг нимгэн бүрхүүл юм.

**Эмэгтэй бэлгэвчийн онцлог:** 17см урт, 7.8см диаметртэй хоёр үзүүртэй, том жижиг уян цагираг бүхий хэрэгсэл юм. Жижиг, дотор цагираг нь бэлгэвчийг үтрээнд байрлуулахад зориулагдсан бөгөөд том, гадна цагираг нь бэлэг эрхтний гадна байрлаж бэлгэвчийг үтрээ рүү орохоос хамгаална. Эмэгтэй бэлгэвч нь зориулалтын чийгшүүлэгчтэй байдаг. Нийлэг эдээр хийгдсэн тул шаардлагатай үед тос, усан суурьтай ямар ч чийгшүүлэгч хэрэглэж болно. Бэлгэвч нь ямар нэг үнэргүй, харшил үзүүлэхгүй.

**Үр дүн:** Тогтмол зөв хэрэглэсэн тохиолдолд ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эрсдлийг 95-аас дээш хувиар бууруулна.

### Эмэгтэй бэлгэвчийн давуу тал:

- ✓ Бэлгэвчийн хэрэглээг эмэгтэйчүүд өөрсдөө хянах боломжтой.
- ✓ ХДХВ/ДОХ/БЗДХ болон жирэмслэхээс зэрэг хамгаална.
- ✓ Бэлгийн хавьтлаас 8 хүртэл цагийн өмнө үтрээнд байрлуулах боломжтой.
- ✓ Эрэгтэй бэлгэвчтэй харьцуулахад илүү бат бөх
- ✓ Дулаан сайн дамжуулдаг тул бэлгийн хавьтлын үед мэдрэмжийг бууруулна.
- ✓ Ус, тосон суурьтай бүх төрлийн чийгшүүлэгчийг ашиглах боломжтой.

### Анхаарах зүйлс:

- ▶ Эмэгтэй бэлгэвчийг анх удаа хэрэглэхэд төвөгтэй санагдаж болно.
- ▶ Бэлгийн хавьтлын үед бага зэрэг дуу чимээ гарч болно.
- ▶ Бэлгийн хавьтлын үед дотор болон гадна цагираг бага зэрэг таагүй мэдрэмж төрүүлж болно, энэ үед байрлалаа өөрчилж болно.
- ▶ Бэлгийн хавьтлын үед шодой бэлгэвч болон үтрээний хана хоёрын хооронд орж болно, шодойг бэлгэвч рүү зөв чиглүүлж өгөх хэрэгтэй.

### Эмэгтэй бэлгэвчийг хэрэглэх заавар:

1. Бэлгэвчийн уутыг сумны дагуу дээрээс доош чиглэлд задалж бэлгэвчийг гаргана.
2. Бэлгэвчийг үтрээнд оруулахдаа хэвтэх, өвдгөө салган суух, эсвэл зогсоод нэг хөлөө сандал дээр тавих гэх мэтээр өөртөө тохиромжтой байрлалыг сонгоно.
3. Бэлгэвчний дотор цагирагийг зураг дээр заасны дагуу гурван хуруугаар хавчиж үтрээ рүү оруулна.
4. Долоовор болон дунд хуруугаа бэлгэвчний дотор хийж дотор цагирагийг аль болох гүн хийнэ.
5. Гадна, том цагираг нь гадна бэлэг эрхтэн дээр байрлана.
6. Шодой нь бэлгэвч дотор зөв орж байгааг шалгана.
7. Үрийн шингэн ялгарсны дараа гаднах цагирагнаас барьж бэлгэвчийг мушгин авна.
8. Цаасанд боож хогийн саванд хий, жорлонд хийж болохгүй.
9. Эрэгтэй бэлгэвчтэй адил нэг удаа л хэрэглэнэ.
10. Эрэгтэй бэлгэвчтэй зэрэг хэрэглэх шаардлагагүй.
11. Хавьтлын үед бэлгэвч урагдвал шинэ бэлгэвч хэрэглэнэ



## АРВАН ГУРАВ. ЖИРЭМСЛЭХЭЭС ХАМГААЛАХ ХААЛТЫН АРГУУД

Жирэмслэхээс хамгаалах зорилгоор бэлгийн хавьтлын өмнө эмэгтэй үтрээндээ хийдэг төрөл бүрийн тос, шахмал, лаа, нийлэг эдээр хийсэн хэрэгсэл зэргийг жирэмслэхээс хамгаалах хаалтын аргууд гэнэ. Дараах хэлбэрүүдтэй байна

- үтрээний шахмал лаа, тос, хөөсрөгч бодис
- үтрээний хаалт - бэлгийн хавьтлын өмнө умайн хүзүүний наагуур үтрээнд байрлуулах хэрэгсэл
- умайн хүзүүний таглаа - бэлгийн хавьтлын өмнө умайн хүзүүнд өмсгөж байрлуулдаг

**Үйлчлэх зарчим:** Найрлагандаа үтрээний орчныг өөрчлөх бодис агуулсан шахмал, лаа, тос зэрэг нь эр бэлгийн эсийг амьдрах чадваргүй болгож, эр бэлгийн эсийг умайн хүзүүгээр нэвтрэх боломжгүй болгож жирэмслэхээс хамгаална.

**Үр дүн:** Бэлгийн хавьтлын үед зааврын дагуу хэрэглэхээс хамаарна.

### Давуу тал:

- ✓ Эмэгтэй өөрөө хянах боломжтой.
- ✓ Төрсний дараа шууд хэрэглэж болох ба хөхүүл эмэгтэйд нэн тохиромжтой.
- ✓ Заг хүйтэн, хламид зэрэг бэлгийн замын зарим халдвараас хамгаална.
- ✓ Тосыг нь бэлгэвчийн нэмэлт чийгшүүлэгч болгон хэрэглэж болно.
- ✓ Биеийн жин нэмэгдэхгүй.

### Сул тал:

- ▶ Байнга хэрэглэвэл үтрээ хорсож болох юм.
- ▶ Бэлгийн хавьтал бүрийн өмнө хэрэглэх шаардлагатай болдог.
- ▶ Найрлага дахь зарим бодисын үйлдэл эхэлтэл тодорхой хугацаагаар бэлгийн хавьтлыг хойшлуулах шаардлагатай болдог.

### Хаалтын арга дараах эмэгтэйчүүдэд илүү тохиромжтой:

- Бэлгийн хавьталд цөөхөн ордог
- Эмээ уухаа мартсан гэх мэт жирэмслэхээс хамгаалах өөр аргатай хавсран хэрэглэх шаардлагатай нөхцөлд
- Хөхүүл эмэгтэй.

Үтрээний тос, лаа нь үтрээний чийгшилт багатай ахимаг насны эмэгтэй

### Үйлчлүүлэгчид сануулах нь:

- Хаалтыг үтрээндээ хийхээс өмнө гараа сайтар угаах
- Бэлгийн хавьтлын өмнө үтрээнд аль болох гүн хийх
- Давтан бэлгийн хавьтал хийх тохиолдолд шинээр хэрэглэх
- Бэлгийн хавьтлын дараа доод тал нь 6-8 цаг үтрээндээ байлгах
-

**Үтрээний хаалт, умайн хүзүүний таглаа:**

- Бэлгийн хавьталд орохоос өмнө тосыг үтрээнд түрхэнэ.
- Давтан бэлгийн хавьталд орох бол хаалт, таглааг сугалж авахгүйгээр үтрээнд дахин тос түрхэж хэрэглэнэ.
- Бэлгийн хавьтлын дараа доод тал нь 6 цаг үтрээндээ байлгана.
- Үтрээний хаалт, умайн хүзүүний таглааг 24 цагаас илүү хугацаагаар үтрээнд байлгаж болохгүй.
- Хэрэглэсний дараа савантай бүлээн усаар угааж хуурай сэрүүн газар хадгална.

## АРВАН ДӨРӨВ. ЭРЭГТЭЙ ҮРИЙН СУВАГ БООХ

Энэ арга нь эмэгтэйгээ жирэмслүүлэхгүйн тулд эрэгтэй хүн хийлгэдэг энгийн мэс ажилбар юм. Уг мэс ажилбар эр бэлгийн эсүүдийг шодой уруу дамжуулдаг үрийн сувгуудыг боох буюу битүүрүүлдэг. Үрийн сувгуудыг боосноор эр бэлгийн эс үрийн шингэнд орох боломжгүй болно.

Үрийн сувгийг боох арга нь жирэмслэхээс хамгаалах байнгын арга учраас дахин хүүхэдтэй болохгүй гэж шийдсэн эрэгтэйчүүд энэ аргыг хэрэглэнэ.

Үрийн сувгийг боох нь энгийн бөгөөд үр дүнтэй арга юм. Энэ нь эрэгтэйчүүдийн бэлгийн харилцаанд нөлөөлөхгүй. Бусад мэс ажилбруудын нэгэн адил цус алдах, халдвар дамжих зэрэг хүндрэлүүд гарч болно. Иймд сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авах шаардлагатай, цөөн тохиолдолд уг ажилбар үр дүнгүй болох нь бий.

Үрийн сувгийг боох нь эрчүүдийн хувьд гэр бүл төлөвлөлтийн хамгийн аюулгүй, найдвартай арга юм.

Үрийн сувгийг боох арга нь БЗДХ, ХДХВ-ын халдвараас хамгаалахгүй.

## АРВАН ТАВ. ЭМЭГТЭЙН ХҮСЭЛТЭЭР ҮР ДАМЖУУЛАХ ХООЛОЙГ БООХ

Ихэнх хос нөхөн үржих насны хязгаарт хүрэхийн өмнө хүссэн тооны хүүхэдтэй болдог тул цаашид жирэмслэхээс хамгаалах найдвартай арга хэрэглэхийг хүсдэг. Ийм хүмүүст сайн дурын үндсэн дээр үр дамжуулах хоолойг боох арга хэрэглэх нь тохиромжтой.

Үр дамжуулах хоолойг боох ажилбарыг хэд хэдэн аргаар гүйцэтгэж болно. Үүнд:

1. Кесар хагалгаа, үр дамжуулах хоолойг тайрах, өндгөвчний уйланхайг авах зэрэг эмэгтэйчүүдийн мэс засал эмчилгээний үед
2. Минилапаротоми
3. Мэс заслын лапароскопи

Уг мэс заслыг бүрэн тоноглогдсон, ерөнхий болон нугасны мэдээ алдуулалтыг гүйцэтгэж болох хагалгааны өрөөнд, туршлагатай нарийн мэргэжлийн эмч хийнэ.

### Үр дамжуулах хоолойг боох аргын механизм

Үр дамжуулах хоолойг боох арга нь үр дамжуулах хоолойг механик аргаар битүүрүүлж, эр бэлгийн эс өндгөн эстэй нийлэхийг саатуулна.

### Үр дүн

Үр дамжуулах хоолойг боох арга нь жирэмслэлтээс хамгаалах өндөр үр дүнтэй, байнгын арга юм. Уг ажилбарын дараах эхний жилд 200 эмэгтэй тутамд 1 жирэмсэлт тохиолдоно. Уг ажилбарын дараах эхний арван жилд 100 эмэгтэй тутамд зөвхөн 1.8% нь жирэмсэлсэн байна

Жирэмслэх нь мэс засалчийн ур чадвар, хэрэглэсэн арга барилаас хамаарна. Орчин үеийн жирэмслэхээс хамгаалах аргуудаас үр дамжуулах хоолойг боох арга хамгийн найдвартайд тооцогддог.

### Үр дамжуулах хоолойг боох аргын давуу тал:

- Өндөр үр дүнтэй, жирэмслэхээс хамгаалах байнгын арга
- Жирэмслэхээс хамгаалах хэрэгслийг нөөцлөх, эмнэлэгт давтан хандах шаардлагагүй.
- Хөхний сүүний гарцад нөлөөлөхгүй.
- Бэлгийн хавьталд саад учруулахгүй.
- Гаж нөлөө байхгүй

### Үр дамжуулах хоолойг боох аргын сул тал:

- Уг аргыг хэрэглэхэд өргөн боломж бүрдээгүй, зөвхөн туршлагатай үйлчилгээ үзүүлэгч, мэс заслын тоног төхөөрөмжтэй эмнэлэгт хийнэ.
- Мэс заслын дараа хэдэн хоногийн туршид эмэгтэйд тавгүй байдал үүснэ.
- Мэс заслын явцад хүндрэл үүсэх эрсдэл ховор боловч тохиолдоно.
  - Зүсэлт хийсэн талбайд халдвар орох, цус хурах

- Халдварлагдах эсвэл цус алдах
- Дотор эрхтэнд гэмтэл учрах зэрэг

Мэдээ алдуулалтаас үүсч болох хүндрэл:

- ▶ Харшил үүсэх, эсвэл эмийн тун хэтрэх
- ▶ Мэдээ алдуулалтаас сэрэхгүй удах, хэрэглэсэн эм гаж нөлөө үүсгэх.

Ховор тохиолдолд мэдээ алдуулалт, эсвэл мэс заслын хүндрэлээс үхэлд хүрч болохыг үгүйсгэхгүй.

- Үр дамжуулах хоолойг боох мэс засал үр дүнтэй болоогүйгээс умайн гаднах жирэмсэлт үүсэх эрсдэл нэмэгдэнэ.
- БЗДХ, ХДХВ/ДОХ – аас хамгаалахгүй.

**Ирээдүйд жирэмсэн болохыг хүсч болох эмэгтэй жирэмсэлтээс хамгаалах өөр арга сонгох ёстой.**

**Үр дамжуулах хоолойг боох мэс заслыг гүйцэтгэхэд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж**

**Эмнэлгийн мэргэжилтэн:**

- Үр дамжуулах хоолойг боох мэс заслын давуу, сул тал, гарч болох хүндрэл, мэс заслын дараах үеийн сувилгаа, гэр бүл төлөвлөлтийн бусад аргын талаар зөвлөгөө өгөхөд сургагдсан, дадлага эзэмшсэн байна.
- Мэс засалч зөвшөөрөгдсөн тодорхой нэг аргыг хэрэглэж үр дамжуулах хоолойг боох ажилбарыг гүйцэтгэх, мэдээ алдуулалт болон мэс заслын явцад гарч болох хүндрэлийг удирдахад суралцсан, дадлага олсон байна.
- Эмнэлгийн мэргэжилтэн мэс заслын өрөө, мэс заслын дараах тасагт эмчид туслах, үйлчлүүлэгчид хяналт тавихад сургагдсан байна.
- Мэдээгүйжүүлгийн эмч сонгосон мэдээгүйжүүлгийг үйлчлүүлэгчид хийх, болзошгүй хүндрэлийг оношлож, эмчлэхэд суралцсан байна.

**Өрөө тасалгаа:**

- Зөвлөгөө өгөх, үзлэг хийх явцад үйлчлүүлэгчийг бусдаас тусгаарласан, чөлөөт байдлыг хангасан өрөө
- Шаардлагатай оношлогоог явуулах боломжтой лаборатори
- Яаралтай, хүндрэл гарсан үед өвчтөнд шаардагдах эм, багаж тоног төхөөрөмжөөр тоноглогдсон мэс заслын өрөө.
- Тогтмол хяналт явуулах ажилтантай, мэс заслын өрөөтэй ойр байрладаг сэхээн амьдруулах тасаг

**Багаж төхөөрөмж, хангамж:**

- Мэс заслын ширээ
- Мэс заслын багаж
- Өвдөлт намдаах эм
- Сэхээн амьдруулах, яаралтай үед хэрэглэх багаж төхөөрөмж
- Мэс заслын багажийг ариутгах автоклав болон хадгалах талбай.

- Антисептик уусмалууд
- Мэс заслын уусдаг утас, боолтын материал

**Үр дамжуулах хоолойг боох ажилбар нь гэр бүл төлөвлөлтийн байнгын арга бөгөөд үйлчлүүлэгч дараах зүйлийг тодорхой ойлгосон байх шаардлагатай:**

1. Үйлчлүүлэгч бэлгийн хавьтагчийн хамт жирэмслэхээс хамгаалах түр аргыг хэрэглэх боломжгүй.
2. Сайн дурын үндсэн дээр үр дамжуулах хоолойг боох нь мэс ажилбарын арга юм.
3. Уг ажилбар тодорхой хэмжээний эрсдэл болон давуу талтай. Эдгээрийн талаар үйлчлүүлэгчид ойлгомжтой тайлбарлаж өгнө.
4. Ажилбар амжилттай болсон тохиолдолд уг арга эмэгтэйг жирэмслэхээс найдвартай хамгаална. Өөрийн хүсэлтийн дагуу үр дамжуулах хоолойг боох мэс засал хийлгэхээс өмнө эмэгтэй цаашид хүүхэд гаргахгүй гэсэн шийдвэрээ буцалтгүй гаргасан байх ёстой.
5. Байнгын арга тул мэс заслын дараа үрийн хоолойн үр дамжуулах чадварыг сэргээх мэс засал нилээд төвөгтэй.
6. Үр дамжуулах хоолойг боох ажилбарыг гүйцэтгэхээс өмнө үйлчлүүлэгч уг ажилбараас татгалзаж болно.
7. Уг ажилбарын дараа ховор тохиолдолд л жирэмсэлнэ. Жирэмсэн тохиолдолд умайн гаднах жирэмсэлт үүсэх магадлал өндөр байдаг.

**Сонголт хийх эрх үйлчлүүлэгчид байх ёстой.** Эмэгтэй, үр дамжуулах хоолойг боох мэс ажилбарын сул, давуу талыг бүрэн ухамсарласан, мэдээлэл авсны үндсэн дээр уг ажилбарыг хийлгэх зөвшөөрлөө өгч албан баримтад гарын үсгээ зурна. Уг баримтыг эмнэлгийн бичиг баримтанд хавсаргана.

**Жирэмслэхээс хамгаалах зорилгоор үр дамжуулах хоолойг боох мэс засал хийлгэж болох эмэгтэй**

- ✓ Цаашид хүүхэд төрүүлэхгүй гэж шийдсэн
- ✓ Эрүүл мэндийн байдлын улмаас жирэмсэлж, төрөх боломжгүй.

**Үр дамжуулах хоолойг боох мэс заслыг хийлгэхэд тохиромжгүй эмэгтэйчүүд**

Уг ажилбарыг хийлгэхэд эсрэг заалт байхгүй. Гэвч дараах тохиолдолд уг ажилбарыг **хойшлуулах** шаардлага үүсдэг (асуудлыг зохих ёсоор оношлон, эмчлэх хүртэл).

- Жирэмсэн
- Жирэмсэн эсэх нь тодорхой бус байгаа
- БЗДХ, бага аарцгийн эрхтний үрэвсэл, амьсгалын зам, хоол боловсруулах замын өвчинтэй
- Оношлогоо, эмчилгээ хийгдээгүй эмгэг (артерийн даралт ихтэй, зүрхний цусан хангамжийн дутагдал зэрэг)
- Хэсэг газрын халдвар (арьсны халдвар эсвэл мэс засал хийх хэсгийн арьсны үрэвсэл)
- Саяхан хүндрэлтэй төрсөн эсвэл үр хөндүүлсэн

**Ажилбарыг хэзээ гүйцэтгэх вэ?**

Эмэгтэйн байдал	Ажилбар хийх хугацаа
Одоо жирэмсэн биш: - Гэр бүл төлөвлөлтийн арга хэрэглэж байгаа - Биеийн юмны тогтмол мөчлөгтэй	Жирэмслэх эрсдлийг багасгах зорилгоор сүүлийн биений юм ирснээс хойш 10 хоногийн дотор ажилбарыг хийнэ. Эмэгтэй жирэмсэн биш гэдэг нь батлагдсан тохиолдолд хэзээ ч хийж болно
Төрсний дараа	Хэвийн, хүндрэлгүй төрсний дараа 7 хоног дотор, эсвэл төрснөөс хойш 6 долоо хоног өнгөрсний дараа.
Зулбалт болон үр хөндөлтийн дараа	Халдвар, бусад хүндрэл үүсээгүй тохиолдолд шууд, эсвэл 48 цагийн дотор
Жирэмслэхээс хамгаалах өөр арга хэрэглэхээ зогсоож байгаа үед	Тодорхой арга хэрэглэхийг зогсоохоос <b>өмнө</b> үр дамжуулах хоолойг боолгох нь илүү найдвартай.

### Үр дамжуулах хоолойг боох ажилбарыг гүйцэтгэх аргууд:

Үр дамжуулах хоолойг боох мэс ажилбарыг мэс заслын хэд хэдэн аргаар хийдэг. Ямар арга сонгох нь мэс заслын багийн дадлага, ур чадвар, тоног төхөөрөмжийн боломж, төрөөд удаагүй байгаа, эсвэл өөр мэс засалд орж байгаа, мэс заслын явцад хүндрэл гарч болзошгүй тохиолдол г.м зэргээс шалтгаална. Бүх арга өндөр үр дүнд хүргэж, жирэмслэхээс найдвартай хамгаална.

### Лапаротоми:

Мэс заслыг хэвлийн доод хэсгийн зүслэгээр хийдэг. Ихэнх тохиолдолд хэвлий, бага аарцгийн хөндийд бусад мэс засал хийгдэх явцад үр дамжуулах хоолойг боох ажилбарыг гүйцэтгэдэг. Жишээ нь:

- Кесар хагалгаа
- Умайн урагдалт, цооролтыг оёх мэс засал
- Умайн гаднах жирэмсний үед үр дамжуулах хоолойг тайрах үед
- Умайн хоргүй хавдрыг авах мэс засал
- Өндгөвчний мэс засал

### Давуу тал:

- Тусгай мэс ажилбар хийх шаардлагагүй.
- Бага аарцгийн хөндийн мэс заслын үед үр дамжуулах хоолойг боох ажилбарыг гүйцэтгэхэд мэс засал үргэлжлэх нийт хугацаанд нөлөөлөхгүй, халдвар, бусад хүндрэл үүсэх эрсдэл нэмэгдэхгүй.
- Ихэнх тохиолдолд эмнэлгийн заалтаар хийгдэнэ. Жишээ нь: умайн урагдал, умайн гаднах жирэмсэн гэх мэт.

### Сул тал:

- Бага аарцгийн хөндийн бусад мэс заслын үед л хийгдэнэ.
- Мэс заслын дараа үйлчлүүлэгчид тодорхой хугацаанд тавгүй байдал үүснэ.
- Унтуулгын, тайвшруулах эмийн бодис нь хөхний сүүгээр дамждаг тул нярайд нөлөөлж болзошгүй.
- Мэс заслын хүндрэл гарч болно.

- Ерөнхий мэдээ алдуулалттай хийх шаардлагатай үед хүндрэл үүсэх эрсдэл өндөр байдаг.

### **Минилапаротоми**

**Хэсгийн мэдээ алдуулалт дор гүйцэтгэх:** 2-3 см жижиг зүслэг хийж үр дамжуулах хоолойг боох ажилбарыг богино хугацаанд түргэн, амбулаторийн нөхцөлд, хялбар гүйцэтгэж болно. Уг ажилбарыг төрсний дараа хүйсний доод хэсэгт зүслэг хийж, жирэмсэн биш эмэгтэйд умдагны дээд хэсэгт жижиг хэмжээний зүслэлт хийх аргаар гүйцэтгэнэ. Жижиг зүслэлт хийгддэг тул эд эсэд гэмтэл бага учруулахын тулд маш хянуур, нямбай байх, ажилбарын туршид үйлчлүүлэгчтэй ярих, харьцах ур чадварыг эзэмшсэн, дадлага олсон байх ёстой.

Лапаротоми хийх үед хэрэглэдэггүй багаж тоног төхөөрөмжийг хэрэглэх шаардлага үүсдэг. Үүнд:

- Умайн өргөгч
- Шүдгүй жижиг хавчуур
- Үр дамжуулах хоолойн дэгээ
- Хэвлийн ханын жижиг толь

### **Давуу тал:**

- Төрсний дараа болон жирэмсэн биш үед хийхэд тохиромжтой
- Ажилбарыг мэс заслын жижиг өрөөнд гүйцэтгэж, цаг ба нөөцийг хэмнэж болно
- Хэсгийн мэдээ алдуулсан эм нь хөхний сүүгээр дамждаггүй тул нярайд нөлөөлөхгүй.
- Мэдээ алдуулалтаас гаж нөлөө болон хүндрэл үүсэх эрсдэл маш бага.
- Ажилбарын явцад эмэгтэй сэрүүн байснаар хэвийн бус байдал болон хүндрэл үүссэнийг тогтооход хялбар болно.
- Шарх хурдан эдгэрнэ.
- Жижиг зүслэлт хийснээр бага хэмжээний сорвижилт үүснэ.

### **Сул тал:**

- Зарим тусгай багаж төхөөрөмж шаардагдана.
- Мэс заслын багийн бүх гишүүдэд нэмэлт дадлага олох шаардлага үүснэ.
- Үйлчлүүлэгчийг мэс засалд хандах хандлагыг өөрчлөх сургалтанд хамруулах шаардлагатай

### **Лапароскопи:**

Лапароскопийн аргаар үр дамжуулах хоолойг бооход хүйсний доод хэсэгт жижиг зүслэлт хийж, ажилбарыг хийх төхөөрөмжийг хэвлийд оруулж хийнэ. Туршлагатай мэс засалч тоноглол сайтай лапароскопийн тасагт үр дамжуулах хоолойг боох ажилбарыг аюулгүй, шуурхай байдлаар гүйцэтгэх боломжтой. Ажилбарын дараа шарх хурдан эдгэрч, бага хэмжээний сорвижилт үүсдэг тул үйлчлүүлэгчид уг аргыг илүү үнэлдэг. Минилапаротомитой харьцуулахад хүндрэл үүсэх эрсдэл илүү.

### **Давуу тал:**

- Хэсгийн мэдээ алдуулалт хэрэглэнэ.
- Мэдээ алдуулалтаас сөрөг нөлөө болон хүндрэл үүсэх эрсдэл бага



- Үйлчлүүлэгч сэрүүн байснаар үүссэн хэвийн бус байдал, хүндрэлийг илрүүлэхэд тусална.
- Аарцгийн хөндийн бусад эрхтнүүдийг шалгах боломжтой.
- Ажилбарыг мэс заслын жижиг өрөөнд гүйцэтгэснээр цаг хугацаа, нөөцийг хэмнэх боломжтой.
- Жижиг зүсэлт хийснээр бага хэмжээний сорвижилт үүснэ.
- Шарх хурдан эдгэрнэ.

#### **Сул тал:**

- Зөвхөн том эмнэлгүүд лапароскопийн өндөр өртөгтэй, тусгай багаж төхөөрөмжтэй байдаг.
- Төрсний дараа үед хийхэд тохиромжгүй.
- Хүндрэл үүсэх эрсдэл илүү, ялангуяа судасны гэмтэл.
- Ерөнхий мэдээ алдуулалттай хийх нь хүндрэлийг удирдах боломжтой байгууллагад ажилбарыг гүйцэтгэх шаардлагатай болдог.
- Мэс засалчаас илүү өргөн хүрээний дадлага шаардана.

#### **Үр дамжуулах хоолойг боох аргууд:**

Ихэнх тохиолдолд үр дамжуулах хоолойг хэсэгчлэн тайрах арга (сальпингоэктоми)-ыг ашиглана. Энэ нь үр дамжуулах хоолойн дунд хэсэгт гогцоо үүсгэн, өлөн утсаар боож гогцоог тайрахыг хэлнэ. Цус тогтоох зорилгоор хайлдаг утсаар оёдол тавина. Цаашдаа уг утас хайлахад үр дамжуулах хоолойн тайрсан хоёр хэсгийн үлдэцүүд бие биенээсээ холдох болно. Хамгийн хялбар бөгөөд зонхилон хэрэглэдэг.

#### **5-1: Үр дамжуулах хоолойг боох Померойн арга**

Померойн аргын үед ердийн кетгутаар үр дамжуулах хоолойны нарийн хэсэгт хайлдаг утсаар 1-2 см хэмжээний гогцоо үүсгэж зангидаад, гогцооны дээд хэсгийг оёдлын дээгүүр тайрна. Мөн тайралт хийсэн хэсгийн хоолойны хоёр үзүүрийг тус тусад нь боодог арга ч байдаг.

#### **5-2: Үр дамжуулах хоолойг боох Паркландын арга**

Үр дамжуулах хоолойн нарийн хэсгийг судас дайраагүй газарт чацархайнаас нь салгана. Хоолойг хайлдаг утсаар 1-2 см-ийн зайтай хоёр цэгт бооно. Лапароскопи болон зарим лапаротомийн үед үр дамжуулах хоолойг найдвартай бооход нэмэлт хавчуур болон цагираг хэрэглэдэг. Үр дамжуулах хоолойн сувгийг сэргээх ажилбарын явцад эдгээрийг авахад онолын хувьд хялбар боловч илүү өртөгтэй, үр дүн багатай.

#### **5-3: Үр дамжуулах хоолойг хавчих аргаар боох**

Тусгай багаж ашиглан хавчаарыг умайн эвэрнээс 2-3 см-ийн зайд тавина. Хавчаар хоолойг бүрэн тагласан байх ёстой.

#### **Мэс ажилбарын үед эмэгтэйг хянах:**

- Үйлчлүүлэгчтэй ярьж анхаарлыг нь сарниулах, тайвшруулах, түүний саналыг сонсох зэргээр харьцана.

- Артерийн даралт, судасны лугшилт, арьсны өнгө зэргийг 15 минут тутамд шалгана.
- Шаардлагатай бол нэмэлт мэдээ алдуулалт хэрэглэнэ.

### **Ажилбарын дараах асаргаа сувилгаа**

1. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчийн судасны лугшилт, артерийн даралт, амьсгалын тоог биеийн байдал тогтвортой болтол 15 минут тутамд хянана. Эмгэг байдлыг илэрхийлэх дараах шинж тэмдгийг эмнэлгийн мэргэжилтэн таньж чаддаг байх ёстой:
  - Өвчтөн хэт нойрмог болох,
  - Амьсгалын тоо минутанд 10, түүнээс цөөрөх,
  - Уушгинд хэт агааржилт үүсэх,
  - Агшилтын даралт 90 мм МУБӨ-өөс багасах,
  - Судасны лугшилт хурдсах (90-ээс их) эсвэл суларсан,
  - Өвчтөний царай цонхийх эсвэл хөхрөх,
2. Ажилбарын хүрээнээс хамааран мэс заслын дараа доорх арга хэмжээг авна:
  - а) Цусан дахь сахарын түвшинг нэмэгдүүлэхийн тулд шингэн, чихэртэй ус, хар цай өгнө.
  - б) Мэдээ алдуулалтаас гарсныг Ромбергын шинж тэмдгээр шалгаж болно. Эмэгтэй нүдээ аниад тэнцвэртэй зогсоно.
  - в) Үйлчлүүлэгч өөрөө юм идэж, чөлөөтэй ярьж чадаж байгаа тохиолдолд түүнийг эмнэлгээс гаргана.
3. Гэртээ мөрдвөл зохих зааврыг давтан хэлж өгнө

**Үйлчлүүлэгч давтан ирэх:** Үйлчлүүлэгч хагалгаа хийлгэснээс хойш 7 хоногийн дараа, боломжгүй бол 2 долоо хоногийн дотор ирж үзүүлнэ. Үзлэгийн явцад:

1. Мэс заслын шархны эдгэрэлт, халдвар үүссэн эсэхийг магадлана.
2. Оёдлыг авна. Оёдлыг тодорхой дадлагатай эмнэлгийн ажилтан мэс ажилбараас хойш 5-7 дахь хоногт авна.

### **Мэдээ алдуулалтаас үүсч болох хүндрэл:**

Мэдээ алдуулалтын төрлөөс хамааран, эмийн тунг хэтрүүлэн хэрэглэснээс харшил үүсэх, амьсгал дарангуйлагдах, хөхрөх, бөөлжсөн зүйл цагаан мөгөөрсөн хоолойд орох зэрэг хүндрэл үүсч болно.

- 1) **Цус алдалт:** Хэвлийн хөндий болон зүслэг хийсэн хэсэгт үүсдэг. Ажилбарын үед үүссэн хүндрэлийн үед цус алдалтыг зогсоох зорилгоор мэс заслыг дахин хийх шаардлагатай. Цус хурах нь хожуу хүндрэлд тооцогддог ба халдварлагдах боломжтой.
- 2) **Дотор эрхтний гэмтэл:** Умай цоорох, давсаг, гэдэс гэмтэх. Мэс заслын аюулгүй арга барил ялангуяа гялтанг нээж байх үед, шүдгүй хавчуур хэрэглэснээр эдгээр хүндрэлээс сэргийлж болно. Гэдэс болон давсагны гэмтлийг илрүүлсэн бол даруй оёх хэрэгтэй.
- 3) **Ажилбарын шарх, аарцгийн хөндийд халдвар үүсэх:** халдваргүйтгэлийн дүрмийг баримтлах, цусыг сайн тогтоох, шаардлагагүй оёдол тавихаас зайлсхийх замаар арьсны шарх, аарцгийн хөндийд халдвар үүсэх эрсдлийг бууруулна. Эмчилгээ үүссэн халдварын хүрээнээс хамаарна. Идээт буглаа үүссэн бол түүнийг зүсч, нээх хэрэгтэй.

- 4) **Жирэмслэх:** Үр дамжуулах хоолойг боох ажилбарын дараа удалгүй жирэмсэлсэн болох нь тогтоогдвол энэ нь гол төлөв ажилбарын өмнө байсан байх ба мэс засал хийх үед оношлогдоогүй байдаг. Ажилбарыг туршлагагүй мэс засалч гүйцэтгэсэн, эсвэл залуу насны эмэгтэйд жирэмслэх магадлалтай.

**Үр дамжуулах хоолойг боох мэс ажилбарын дараа жирэмслэхэд нөлөөлж болох хүчин зүйлс**

- Эмэгтэй жирэмсэн болсноо мэдээгүй мэс ажилбар хийлгэсэн.
- Өгүүлэмж, бодит үзлэгийн явцад жирэмсэнг оношлоогүй.
- Биеийн юмны мөчлөгийн 2 дахь хагаст мэс заслыг гүйцэтгэсэн
- Ажилбарын явцад үр дамжуулах хоолойг бүрэн боож чадаагүй.
- Боосон үр дамжуулах хоолой цаашид аяндаа нээгдэх
- Үр дамжуулах хоолойг бооход хайлдаггүй утас хэрэглэсэн
- Үр дамжуулах хоолойн хананд цооролт үүссэн
- Үр дамжуулах хоолойд биш, өөр эрхтэнд боолт хийсэн
- Зориулалтын хавчуур, бөгж үр дамжуулах хоолойд амжилтгүй тавигдсан
- Үр дамжуулах хоолойн буруу хэсгийг боосон

Үр дамжуулах хоолойг боох ажилбарын дараа жирэмсэлсэн бол энэ нь гол төлөв умайн гадуур жирэмслэх эрсдэлтэй. Иймээс уг ажилбарыг хийлгэсэн эмэгтэйд жирэмсний шинж тэмдэг илэрмэгц эмнэлэгт яаралтай хандахыг зөвлөнө.

**Шаардагдах багаж төхөөрөмж:**

**Минилапаротомин стандарт бүрдэл:**

<i>Багаж, хэрэгслэл</i>	<i>Тоо хэмжээ</i>
Хавчуур, мэс заслын, (Babcock), 20 см	1
Багаж/боолтын материал тавих бүтээлэгтэй тавиур, 310x195x63 мм	1
Даавууны хавчуур, (Jones), 9 см	4
Боолтын хавчуур, 155 мм	1 (2)
Цус тогтоох шулуун хавчуур (Rochester-Pain), 160 мм	4
Гистерэктомийн шулуун хавчуур, (Pain), 220 мм	4
Цус тогтоох муруй хавчуур (mosquito, Halstead), 125 мм	2
Мэс заслын хавчуур, (spring type), 1x2 шүдтэй, 145 мм	1
Мэс заслын хавчуур, үзүүр хэсэгтээ цонхтой, (Duval), 145 мм	1
Багаж ариутгах сав	1 (2)
Зүү баригч, шулуун, нарийн үзүүртэй, (Mayo), 180 мм	1
Жижиг мэс засал хийхэд зориулагдсан мэс заслын хутганы иш, хэмжээ 3	1
Жижиг мэс засал хийхэд зориулагдсан мэс заслын хутга, хэмжээ 10	
Оёдол тавих зүү, 3/8 бөөрөнхий, дугуй сүвэгчтэй, хэмжээ 12	
Шарх тэлэгч, ерөнхий мэс заслын, (Langenbeck), 60 x 20 мм	

Хэвлийн толь, (Richardson-Eastman), (бүрдэлд 2 ширхэг байна) эсвэл үүнтэй төстэй толь	1
Мэс заслын хайч, шулуун 145 мм	1 бүрдэл
Муруй хайч, 150 мм	1
Үр дамжуулах хоолойн дэгээ	
<b>Умай өргөгч хэрэглэж байгаа тохиолдолд:</b>	
Үтрээний мэс ажилбарт зориулсан багажны тавиур:	1
Үтрээний хоёр хавтаст толь, хэмжээ дунд	1
Үтрээний хоёр хавтаст толь, хэмжээ жижиг	1
Умайн суман хавчуур	1
Умай өргөгч	1
Боолтын хавчуурт зориулсан бортгон сав	

**Яаралтай тусламж ба сэхээн амьдруулахын багаж, тоног төхөөрмж**

- Мэдээ алдуулалтын маск, хүчил төрөгч залгах боломжтой амьсгалын маск
- Хүчилтөрөгчтэй баллон, бууруулагч хавхлага, урсгал хэмжигч, дамжуулагч хоолой
- Соруулагч машин, хоолой, хоёр бэхлэгч
- Хамрын гуурс (агаар дамжуулагч) хоёр хэмжээний
- Амаар агаар дамжуулах гуурс -хоёр хэмжээтэй
- Дуслын шингэн ба эм
- Зүрхний сэхээн амьдруулах эм, хэрэгсэл
- Мэдээгүйжүүлэх эм тарианы эсрэг эмүүд Жишээ нь: налоксон, флюмазенил
- Яаралтай лапаротоми хийхэд шаардагдах багаж төхөөрөмж
- Хураагуур судсыг зүсэхэд шаардагдах багаж
- Шаардлагатай үед ерөнхий мэдээгүйжүүлэг хийхэд шаардагдах багаж, хэрэгслэл
- Лапаротоми хийж байгаа мэс заслын багийн бүрэлдэхүүнд мэдээгүйжүүлэлт болон интубаци хийх, хиймэл амьсгал хийж чаддаг мэдээгүйжүүлэгч эмч байнгын бэлэн байдалд байх шаардлагатай.

**Мэс ажилбар хийх заалт болон үр дүнд нөлөөлөх нөхцөл байдлууд**

<b>Нөхцөл байдал</b>	<b>Авах арга хэмжээ</b>
Жирэмсэн	Эмэгтэйг төрөх, эсвэл жирэмслэлтийг өөр аргаар шийдвэрлэх хүртэл ажилбарыг хойшлуулна.
Төрсний дараах хүндрэлүүд	Дараах нөхцөл байдал үүссэн үед ажилбарыг хойшлуулах шаардлагатай: <ul style="list-style-type: none"> <li>✓ Манас таталтын урьдлын хүнд хэлбэр</li> <li>✓ Ураг орчмын шингэн гараад 24 цагаас дээш хугацаа өнгөрсөн</li> <li>✓ Төрсний дараах үед үжил үүссэн</li> <li>✓ Жирэмсэн, төрсний дараах үед хүнд хэлбэрийн цус алдалт үүссэн (500 мл-ээс илүү)</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>✓ Төрөх замд ноцтой гэмтэл үүссэн: төрлөгийн явцад умайн хүзүү болон үтрээ урагдсан</li> <li>✓ Умай урагдсан, эсвэл цоорсон</li> <li>• Үүссэн хүндрэлийг эмчлэх зорилгоор лапаротоми хийж байгаа үед эмэгтэйг хүсвэл үр дамжуулах хоолойг боох ажилбарыг хийж болно. Мэс заслын үргэлжлэх хугацаа хэт уртсах хандлагатай, эсвэл мэс заслын хүндрэл үүссэн тохиолдолд (ж.нь: өргөн холбоосонд гематом үүссэн) ажилбарыг гүйцэтгэх хориотой.</li> </ul>
Үр хөндөлтийн дараах хүндрэлүүд:	<p>Дараах тохолдолд ажилбарыг түр хойшлуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Үр хөндөлтийн дараа үжил үүссэн, эсвэл эмэгтэй халуурсан</li> <li>✓ Үр хөндөлтийн дараа 500 мл-ээс их хэмжээтэй цус алдсан</li> <li>✓ Төрөх замд хүнд гэмтэл үүссэн: үр хөндөлтийн явцад умайн хүзүү болон үтрээ урагдсан</li> <li>✓ Умай цоорсон</li> <li>✓ Умайн булчинд цус хурсан</li> </ul>
<b>Эмгэг өөрчлөлтүүд</b>	
Артерийн даралт ихсэх хямрал: Хөнгөн, дунд, хүнд хэлбэрийн :	Артерийн даралтыг мэс заслын өмнө хяналтандаа авсан байна. Мэс заслын явцад артерийн даралтыг зохих хэмжээнд барих шаардлагатай.
Амьсгалын замын хурц үрэвсэл (гуурсан хоолой, уушгины хурц хатгалгаа, сүрьеэгийн идэвхитэй хэлбэр)	Халдварыг эмчилж дуусах хүртэл ажилбарыг хойшлуулна. Мэдээгүйжүүлэгтэй холбоотой болон бусад хүндрэлүүд мэс заслын явцад үүсэх өндөр эрсдэл байна.
Бамбай булчирхайн үйл ажиллагааны дутмагшил, эсвэл хэт идэвхжил	Мэдээгүйжүүлэг, мэс заслын явцад хүндрэл үүсэх өндөр эрсдэлтэй. Мэс заслаас өмнө бамбайн өвчнийг эмчилж, хяналтандаа авсан байх шаардлагатай.
Цэсний хүүдийн үрэвсэл	Өвчнийг эмчилж дуустал ажилбарыг хойшлуулна.
Вирүсийн гаралтай элэгний хурц үрэвсэл	Мэдээгүйжүүлэг болон мэс заслын явцад хүндрэл үүсэх эрсдэлтэй.
Элэгний хатуурал	Цус бүлэгнэлтийн тогтолцоонд өөрчлөлт орж болно. Элэгний үйл ажиллагаа алдагдсанаас зарим төрлийн мэдээгүйжүүлэг хийх боломжгүй.
Элэгний хавдар	Элэгний үйл ажиллагаа, цус бүлэгнэлтэд өөрчлөлт орсон байж болохыг анхаарна.
Бөөрний өвчин	Бөөрний үйл ажиллагаа алдагдсан бол мэс заслын явцад хүндрэл үүсэх эрсдэлтэй. Жирэмслэхээс хамгаалах бусад арга хэрэглэхийг зөвлөнө.
хэт тарган	Том зүсэлт хийх, мэдээгүйжүүлгийн эмийн нэмэлт тун хэрэглэх шаардлага үүсч, мэс засал хүндэрч

	болно. Шарх халдварлагдах, оёдол задрах эрсдэлтэй. Ерөнхий мэдээгүйжүүлэг хийх шаардлага үүсэх магадлалтай. Амьсгалын замын үйл ажиллагаа дарангуйлагдаж болно.
Хоол тэжээлийн хүнд хэлбэрийн дутагдал	Шарх халдварлагдах, удаан эдгэрэх эрсдэлтэй.
Төмөр дутагдлын цус багадалт	Үр дамжуулах хоолойг боох ажилбарыг хийхээс өмнө байдлыг үнэлж, эмчилсэн байна. Гемоглобин <10мг/дл байгаа тохиолдолд мэс заслыг хойшлуулна.
<b>Нөхөн үржихүйн замын эмгэг өөрчлөлтүүд</b>	
Шалтгаан нь тодорхой бус үтрээний цус алдалт	Онош тодруулж, эмчилгээ эхэлтэл ажилбарыг хойшлуулна.
БЗДХ	Өвчнийг эмчилж дуустал боломжтой бол ажилбарыг 3 сараар хойшлуулна. БЗДХ-тай эмэгтэйд мэс заслын дараа халдвар үүсгэх өндөр эрсдэлтэй.
Бага аарцгийн эрхтнүүдийн үрэвсэлтэй эсвэл сүүлийн 3 сарын дотор өвчилсөн өгүүлэмжтэй	Өвчтөн эмчлэгдэж, эдгэртэл ажилбарыг хойшлуулна. БАЭҮ-тэй өвчтөнд мэс заслын дараа халдвар ба наалдац үүсгэх эрсдэлтэй. БАЭҮ-ийг эмчилсний дараа үр дамжуулах хоолойг боох ажилбарыг 3 сараас доошгүй хугацаагаар хойшлуулна.
Өмнө нь бага аарцгийн эрхтний үрэвслээр өвчилж байсан.	Үтрээний үзлэгээр халдварын байдал, умай чөлөөтэй хөдөлж байгаа эсэхийг тогтооно. Ажилбарын явцад наалдац тулгарч болохыг мартаж болохгүй.
Умайн булчингийн хоргүй хавдар	Хавдар нь дотор эрхтнүүдийн бүтцийг өөрчилж, үр дамжуулах хоолойг олоход хүндрэл учруулж болно.
Эндомиомиоз	Ажилбарыг шаардлагатай багаж төхөөрөмж болон бусад эмнэлгийн хэрэгслүүдийн тусламжтай зөвхөн туршлагатай мэс засалч гүйцэтгэнэ.
Өмнө нь мэс засал хийгдсэн, эсвэл халдвар үүссэнээс умай хөдөлгөөнгүй болсон	Хүндрэл үүсэх өндөр эрсдэлтэй тул мэс заслыг зөвхөн туршлагатай мэс засалч хийх ёстой.
<b>Өвчний идэвхтэй үе:</b>	
Хэвлий орчмын арьсны халдвар	Эмчилгээ хийж дуустал ажилбарыг хойшлуулна. Мэс заслын дараа халдвар үүсэх эрсдэлтэй.
Эрхтэн тогтолцооны эсвэл ходоод-гэдэсний үрэвсэл	Эмчилгээ хийж дуустал мэс заслыг хойшлуулна.
<b>Мэс заслын нөхцөл байдлууд</b>	
Гэдэсний хана, хүйсний ивэрхий	Ивэрхийг оёх, боломжтой бол мэс заслын явцад үр дамжуулах хоолойг бооно.
Хүнд мэс засал хийгдсэнээс дараа нь өвчтөн удаан хугацаагаар хөдөлгөөнгүй	Төлөвлөсөн зүсэлт, нь үр дамжуулах хоолойнд чөлөөтэй, аюулгүй хүрэх боломжийг бүрдүүлж байгаа ба уг ажилбар нь үндсэн ажилбарт сөрөг

хэвтрийн дэглэм барих шаардлагатай тохиолдолд	нөлөө үзүүлэхгүй тохиолдолд ажилбарыг хийж болно. Бусад тохиолдолд өвчтөн эдгэрч, биеийн хөдөлгөөн бүрэн сэргэтэл ажилбарыг хойшлуулна.
---	---

**Эмэгтэйд зөвлөх нь:** Эмэгтэй мэс заслын дараа 1-2 хоног сайн амарна. 2-3 хоног өнгөрсний дараа хэвийн дэглэмд орж болно. Долоо хоногийн туршид биеийн хүчний хөдөлмөр хийхгүй, хүнд юм өргөж болохгүй. Энэ нь шарх хурдан эдгэрэхэд тустай.

### **Хэсгийн мэдээгүйжүүлгийн дор минилапаротоми хийх мэс ажилбарын удирдамж**

1. Өвчтөнийг мэс заслын өрөөнд оруулахаас өмнө давсгийг суллана.
2. Үтрээний үзлэг хийнэ:
  - Эмэгтэйг литотоми байрлалд (дээшээ харж хэвтсэн, үтрээний үзлэгийн байрлалд) байрлуулна.
  - Умайн байрлал, хөдөлгөөн, хэмжээ, хэлбэр, цуллаг байдлыг тодорхойлно.
3. Умай өргөгчийг умайд тавина:
  - Үтрээнд толь тавьж умайн хүзүүний халдвар, эмгэг өөрчлөлт байгаа эсэхийг шалгана.
  - Антисептик уусмалаар умайн хүзүү болон үтрээг цэвэрлэнэ.
  - Умайн өргөгчийн хамгаалалтын хэсгээс дээш хэсгийг үтрээний хананд хүргэхгүйгээр хамгаалалтын тэмдэг хүртэл нь умайд болгоомжтой оруулна. Ингэхдээ өргөгчийг умайн байрлалын дагуу чиглүүлж оруулна.
  - Умайн өргөгчийг хөшүүрэг болгон, бариулыг нь доошлуулна, ингэснээр умайн ёроолыг хэвлийн хана руу өргөнө. Арагшаа байрлалтай, эсвэл наалдацтай умайд өргөгчийг оруулах боломжгүй байж болно. Умайг өргөхөд хэт их хүч хэрэглэж болохгүй. Ихэвчлэн умайн ёроол умдагнаас дээш 2-3 см-т товойж мэдэгддэг. Мэдрэгдэж буй умайн ёроолоос 1-2 см доор зүслэг хийх газрыг тэмдэглэнэ.
4. Умайн өргөгчийн бариулыг доошлуулж, умайн ёроолыг хэвлийн өмнөт хана руу өргөнө.
5. Гараа умайн өргөгчөөс болгоомжтой авч, өргөгчийг орхино.
6. Үйлчлүүлэгчтэй ярь:
  - Арьсанд мэдээ алдуулалт хийх гэж байгааг бага зэрэг мэдэрч болохыг эмэгтэйд тайлбарлана. Мэс заслын үед бага зэргийн даралт, таталт, базлалт мэдэрч болзошгүйг түүнд анхааруулна.
  - Тавгүй байдал үүсвэл эмэгтэй эмч болон сувилагчид хэлэх, эмч эвгүй мэдрэмжийг багасгах арга хэмжээ авахыг түүнд сануулна.

7. Хэсгийн мэдээ алдуулагчийг арьсанд нэвчүүлэн хийнэ:

- Арьсанд жижиг булдруу үүсгэнэ.
- Адреналин агуулаагүй 6-8 мл 1% лигнокаин (лидокаин)-ийг зүсэлтийн шугамын дагуу арьсанд хоёр чиглэлд нэвчүүлэн хийнэ.

8. Хэвлийг нээх:

- Умдагны үеэс дээш 2-3 см-т арьсан дээр зүсэлт хийнэ. (ихэнхи тохиолдолд умайн ёроолоос 1-2 см-т) Гэхдээ арьсан доорх эдийг хөндөхгүйгээр 2-3 см-ийн урттай хөндлөн зүсэлт хийдэг.
- Цус алдалтаас сэргийлэх зорилгоор арьсан доорх эдийг мохоо аргаар салгана.
- Цоройг нээх: Цоройг зүсэж хөндлөн зай үүсгэнэ. Цоройн үзүүрүүдийг хавчуураар барина. Хэвлийн шулуун булчингийн хальснаас булчинг мохоо аргаар салгана. Арьсны зүсэлтийн доорх цоройн хэсгийг нээхийн тулд зайг томсгоно.
- Шулуун булчинг хэвлийн цагаан шугамын дагуу мохоо аргаар салгана. Шулуун булчинг үргэлжлүүлэн салгах болон гялтангийн гаднах өөхөнд хүрэх зорилгоор тэлэгчийг хийнэ.
- Өвчтөнд өвдөлт мэдэрч байгаа тохиолдолд лигнокаин нэмж хэрэглэж болно.
- Гялтанг өргөнө. Зүсэлт хийхээс өмнө гялтанг гэрэлд харж, дотор эрхтнүүд түүнд наалдсан эсэхийг шалгана. Хайч эсвэл мэс заслын хутгаар жижиг зүсэлт хийнэ. Доор нь байрлаж буй эдүүдийг шалгаж гэдэс дайрагдсан, гэмтсэн эсэхийг шалгана.
- Гялтангийн зүсэлтийг урагш нь чиглүүлж, шаардлагын дагуу томсгоно.
- Шарх тэлэгчийг хэвлийн шарханд байрлуулна.

9. Ажилбарыг түр зогсоож үр дамжуулах хоолой харагдаж байгаа эсэх, хүрэхэд дөхөм байгаа эсэхийг шалгана. Баккокийн эсвэл түүнтэй төстэй хавчуур ашиглан үр дамжуулах хоолой харагдтал ойртуулж авчирна. Умайн болон үр дамжуулах хоолой харагдахгүй байгаа тохиолдолд өвчтөний толгойг доошлуулж, гэдсийг хэвлийн хөндийн дээд хэсэг үрүү чихнэ.

10. Үр дамжуулах хоолойг гаргах:

- Умайн өргөгчийн бариулыг зөөлөн даран, умайн ёроолыг зүсэлт рүү, хэвлийн хананд ойртууна.
- Өргөгчийн бариулыг хөдөлгөж эхний үрийн хоолойг зүсэлт рүү ойртуулна.
- Үр дамжуулах хоолойг дэгээ хэрэглэж зүсэлтийн талбайд авчирна. Үр дамжуулах хоолойг мохоо хавчуураар умайн буланд ойр хэсгээс нь барина. Үр дамжуулах хоолойг гараар барихаас аль болох зайлсхийх хэрэгтэй.
- Шарх тэлэгч хэрэглэж зүсэлтийг нээлттэй байлгах ба 1%-ийн, 3 - 5 мл лигнокаиныг үр дамжуулах хоолой болон умай дээр дусаана.
- Үр дамжуулах хоолойг зөв олсныг баталгаажуулж салбанг нь шалгана.

11. Зүсэлтийг хаах:



- Цус тогтоолтыг бүрэн хийсний дараа шархыг үечлэн хаана. Гялтанг хурдан, богино хугацаанд хаах ба, цоройн ирмэгүүдийг сайн ойртуул. Цоройг үргэлжилсэн эсвэл хэд хэдэн салангид оёдол тавьж хаана.
- Шимэгддэг эсвэл шимэгддэггүй утсаар арьсанд үргэлжилсэн эсвэл салангид зангилаат оёдол тавина.

12. Шарханд боолт хийнэ.

13. Умайн өргөгчийг гаргаж авна. Цус нэмж гарч байгаа эсэхийг шалгана.

14. Үйлчлүүлэгчийг мэс заслын дараах өрөөнд шилжүүлнэ.

### **Минилапаротомигийн явцад үүсч болох хүндрэл, авах арга хэмжээ**

**Үр дамжуулах хоолойг боох ажилбарын явцад мэдээгүйжүүлэгтэй холбоотой үүсч болох хүндрэлүүд:**

- Амьсгал дарангуйлагдах, эсвэл зогсох
- Зүрх судасны эмгэг өөрчлөлтүүд үүсэх. Үүнд: хэм алдагдах, цусны даралт буурах, даралт ихсэх, зүрх зогсох.
- Таталт үүсэх
- Бөөлжсөн зүйлсээ залгих

**Мэдээгүйжүүлэгтэй холбоотой үүсэх хүндрэлийн шинж тэмдэг:**

- Амьсгалын тоо цөөрөх
- Өвчтөн богино, өнгөц, хурдан амьсгалах
- Амьсгаадах, амьсгал боогдох, төвөнхийн хяхтнаа үүсэх
- Хацар орчмоор хөхрөх (амны эргэн тойрон хөхрөх)
- Судасны цохилт хурдсах, жигд бус болох
- Төв мэдрэлийн тогтолцоонд өөрчлөлт орох өвчтөн тайван биш, түгшүүртэй болох, зүг чигээ олохгүй байх
- Өвчтөнд таталт үүсэх, эсвэл ухаан алдах
- Зүрх зогсох, судасны цохилт, зүрхний авиа, амьсгал, рефлексууд, булчингийн тонус алга болох

**Хүндрэл үүсэх шалтгаан болон нөлөөлөх хүчин зүйл**

- Өвдөлт намдаагч эмийн тунг хэтрүүлж хэрэглэх
- Тайвшруулах эмийн тунг хэтрүүлж хэрэглэх
- Эмүүдийн хавсарсан нөлөө үүсэх
- Үр нөлөө хожимдож үүссэн (хяналтыг сулруулсны дараа эмийн үр нөлөө дээд цэгтээ хүрэх)
- Лигнокаиныг судсанд орох
- Лигнокаины тунг хэтрүүлж хэрэглэх. Энэ нь нэвчих аргыг буруу хэрэглэсэн, эсвэл шингэлэлгүй 2% уусмал хэрэглэсний улмаас үүсч болно.

- Зүрхний өвчин
- Их хэмжээний цус алдсаны улмаас судсан дахь цусны эзэлхүүн буурах.

### **Амьсгалын дарангуйлал**

- Налоксоны тусламжтай дараах “АБВ” арга хэмжээг авна.
- А. Амьсгалын замыг байнга чөлөөтэй байлгах
- Б. Өвчтөнд хүчилтөрөгч өгч сэхээн амьдруулах гар төхөөрөмжөөр амьсгалуулна.
- В. Цусны эргэлтийг шалгах. Судасны цохилт, артерийн даралт, амьсгалыг хянана.
  - Өвчтөнд мансууруулах төрлийн өвчин намдаах эм өгсөн тохиолдолд Налоксоноор эмчилнэ.

### **Зүрх-судасны хүндрэлийн үед авах яаралтай арга хэмжээ**

- Зүрх зогссон тохиолдолд зүрхний дефибрилляторыг хугацаа алдалгүй хэрэглэж зүрхэнд хаалттай иллэг хийнэ.
- Амьсгал хаагдсан тохиолдолд амьсгалын аппарат ашиглан өвчтөнд хүчилтөрөгч өгнө .
- Сэхээн амьдруулах, яаралтай эмчилгээний удирдамжийг мөрдөж сэхээн амьдруулах эмүүдийг судсаар тарина.

### **Умайн цооролт үүсэх**

#### **Умайн цооролт үүссэн нь дараах шинж тэмдгээр илэрнэ:**

- Умайн өргөгчийн үзүүр умайг цоолж гарсан гэж санагдах
- Умайг хэвлийн хана руу өргөх оролдлого амжилтгүй болох
- Умай өргөгчийн үзүүр хэвлийн хананы гадна талаас тэмтрэгдэх
- Умай өргөгчийн үзүүр хэвлийн шарханд тулж ирэх
- Цус алдах

#### **Нөлөөлөх хүчин зүйл**

- Умайн өргөгчийг умайд буруу оруулах
- Умайн өргөгчийг болгоомжгүй хэрэглэх

#### **Умайн ёроолын цооролтыг эмчлэх**

- Умайн өргөгчийн байршил эргэлзээтэй байгаа тохиолдолд түүнийг умайгаас гаргаж авна. Цус алдалт үүссэн эсэхийг ажиглана.
- Хүнд хэлбэрийн цус алдалт удаан хугацаагаар үргэлжилж байгаа тохиолдолд хатгаж, зангидах оёдлыг хайлдаг утсаар тавьж цус алдалтыг зогсооно.
- Үйлчлүүлэгчийг 1-2 цагийн туршид хянана.
- Цус алдалт үргэлжилж байгаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өвчтөнийг эмнэлэгт хяналтанд байлгана. Өвчтөний байдал сайжрахгүй тохиолдолд дахин мэс засал хийх шаардлагатай болно.

### **Давсагны гэмтлийн эмчилгээ**

**Мэс заслын явцад илрэх давсагны гэмтлийн шинж тэмдэг:**

- Зүсэлт рүү тунгалаг шингэн олгойдох
- Давсагны дотор хананы нугалаасууд харагдах

**Шээсний дараа илрэх давсагны гэмтлийн шинж тэмдэг:**

- Шээс цустай гарах
- Умдагны дээд хэсгээр өвдөх, шээхэд хүндрэлтэй байх
- Халуурах, халдварын шинж тэмдэг илрэх

**Нөлөөлөх хүчин зүйл:**

- Мэс заслын өмнө давсгийг суллаагүй
- Зүсэлтийг буруу газар хийсэн
- Гялтанг нээхээс өмнө түүнийг гэрэлтүүлж шалгаагүй.

**Давсагны гэмтлийг эмчлэх**

- Давсганд гэмтэл үүссэн сэжигтэй тохиолдолд давсганд катетер тавьж ариун уусмал хийнэ. Үүнд: Метилийн хөх, Генциан ягаан, нэрмэл ус, эсвэл судсаар хийдэг шингэн хэрэглэж болно.
- Гэмтсэн хэсэгт кетгутаар хоёр давхар үргэлжилсэн оёдол гэмтээхгүй зүүгээр тавина. Арьсны зүсэлтийг томсгох шаардлага үүсч болно.
- Давсганд бага хэмжээний гэмтэл үүссэн тохиолдолд үр дамжуулах хоолойг боох ажилбарыг үргэлжлүүлнэ.
- Давсганд катетер тавина.
- Антибиотикоор курс эмчилгээ хийнэ.
- 7 хоногийн дараа катетерийг авч, өвчтөн өөрөө шээж чадаж байгааг хянана.

**Гэдэсний гэмтлийн эмчилгээ**

**Мэс заслын явцад гэдэсний гэмтэл үүссэн шинж тэмдэг**

- Гэдэсний гадна талын гялгар болон булчинт давхарга гэмтсэн харагдах
- Гэдэсний доторх агууламж харагдах хэвлийд гарах

**Мэс заслын дараа илрэх гэдэсний гэмтлийн шинж тэмдэг (ихэвчлэн хожуу илэрдэг)**

- Хэвлийгээр өвдөх
- Бөөлжих
- Хий гарахгүй байх
- Гэдэсний хурц түгжрэл үүсэх
- Халуурах, судасны цохилтын тоо олшрох
- Халуун буух, эсвэл хэвийн болох
- Гэдэс дүүрэх
- Гэдсээр хөндүүрлэх
- Гялтангийн үрэвслийн шинж тэмдэг илрэх
- Үжлийн шинж тэмдэг илрэх

### **Нөлөөлөх хүчин зүйлс:**

- Гэдэс гялтанд наалдсан
- Гялтанг болгоомжгүй нээсэн
- Ажилбарыг төрсний дараах үед гүйцэтгэхдээ хүйс орчмын нимгэрсэн арьс руу огцом, гүн нэвтэрсэн
- Хэвлийн хөндийд шүдтэй багаж хэрэглэсэн

### **Гэдэсний цочмог гэмтлийг эмчлэх**

- Торгон утас ашиглах, бөөрөнхий зүүгээр гэдэсний гэмтсэн хэсэгт олон давхар оёдол тавина.
- Зөвхөн гадна гялгар давхар гэмтсэн үр дамжуулах хоолойг боох ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Мэс заслын дараа өвчтөнийг хянах шаардлагатай.
- Гэдэсний дотор хананд хүрсэн гүн гэмтлийн үед өвчтөнийг эмнэлэгт үлдээж, антибиотик эмчилгээ судсаар хийнэ.
- Өтгөний хэсгүүд хэвлийн хөндийд гарсан тохиолдолд, хэвлийн хөндийг ариутгасан уусмалаар угааж соруулна.
- Үр дамжуулах хоолойг боож эхлээгүй бол ажилбарыг зогсооно.
- Дан шингэн өгөхөөс эхлэн хоолны дэглэмд хүнсний зүйлийг болгоомжтой, алгуур нэмэх хэрэгтэй.

### **Гэдэсний гэмтэл хожуу илрэх:**

- Хэвлийн үзлэг, рентген шинжилгээгээр оношийг батлах
- Судсаар шингэн эрчимтэй хийх, антибиотик өндөр тунгаар хэрэглэх
- Үжлийн шинж тэмдгийг ажиглах
- Оношлогооны зорилгоор лапаротоми хийж гэмтлийг оёх, хэвлийн хөндийг угаах хүнд гэмтлийн үед гэдэс тайрах мэс засал хийнэ.

### Товчилсон үгийн жагсаалт

- ГБТ-Гэр бүл төлөвлөлт
- ЖСАХ-Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл
- ДЭМБ-Дэлхийн Эрүүл Мэндийн Байгуулага
- МСС-Мэдээлэл сургалт сурталчилгаа
- ТҮЧ-Тусламж үйлчилгээний чанар
- ДХЭ-Дааврын хавсарсан уух эм
- ДХБ-Дааврын хавсарсан бэлдмэл
- ДПЭ-Дан прогестерон агуулсан эм
- ДПБ-Дан прогестерон агуулсан бэлдмэл
- ЯЖХЭ-яаралтай ууж жирэмслэхээс хамгаалах эм
- БЗДХ-Бэлгийн замаар дамжих халдвар
- ДОХ-Дархлалын олдмол хомсдол
- БАЭҮ-Бага аарцгийн хөндийн эрхтнүүдийн үрэвсэл

## **НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭМ ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол Улсын Засгийн газрын болон НҮБ-ын Хүн амын сан санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийн Хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцоо (ХУМТ)-ны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2 Монгол улсын “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Монгол Улсын үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, улсын эмийн бүртгэлийн болон бусад холбогдох журам, зааврыг ХУМТ-ын үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

1.3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн ХУМТ-д эх барих, нярайн яаралтай тусламжийн нэн шаардлагатай эм хэрэгсэл, бэлгийн замаар дамжих халдварын оношлуур, эм болон жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийн захиалга, хуваарилалт, хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хамруулна.

1.4 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаанд оролцож буй анхан болон хоёр дахь шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын эмнэлгийн мэргэжилтнүүд энэхүү журмыг мөрдөнө.

### **Хоёр. Хангамжийн удирдлага, мэдээллийн тогтолцоог хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

#### **А. Өрх, сумын түвшинд:**

2.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн сувилагч, эх баригч, багийн бага эмч, эмийн эргэлтийн сангийн эрхлэгч нар хангамж удирдлага мэдээллийн тогтолцоотой холбогдох анхан шатны бүртгэлүүдийг хөтөлнө.

2.2. Үйлчилгээ авахаар ирсэн үйлчлүүлэгчдэд ямар төрлийн эм, хэрэгслийг хичнээн тоо хэмжээгээр олгосныг өдөр тутмын үйл ажиллагааны буюу эм, хэрэгслийн хэрэглээний (жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийг 11А, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хэрэглээг 11Б маягт) бүртгэлд хөтөлнө.

2.3 Анхан шатны бүртгэлийг үндэслэн орон нутгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн жил, улирлын хэрэгцээг тодорхойлон, захиалга хийж, аймгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагчид хүргүүлнэ. Жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийн тоо хэмжээг тооцохдоо “Хосыг хамгаалах жилийн хэрэглээ”-г харьцуулан гаргана.

2.4 Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар хуваарилагдсан эм, хэрэгслийг тухайн бүтээгдэхүүний онцлог байдалд тохирсон нөхцөлд Эмийн санд тавих нийтлэг шаардлага (MNS 5260:2011) стандартын дагуу суманд Эмийн эргэлтийн сан, өрхийн эрүүл мэндийн төвд тусгай зориулалтын шүүгээнд хадгална.

2.5 Сумын эмийн эргэлтийн сангийн эрхлэгч нь агуулахын бүртгэл, эм, хэрэгслийн хөдөлгөөнт карт, тооллогын бүртгэл, эм, хэрэгслийг хүлээн авсан тухай акт, зарлагын баримт зэрэг хадгалалтын болон харилцааны бүртгэлүүдийг хөтөлнө.

2.6 Өдөр тутмын үйл ажиллагааны хэрэглээний бүртгэлээс зарлагын тайлан гаргаж, тооцоолсны үндсэн дээр агуулахын нөөцийн дээд болон доод түвшинг тодорхойлон агуулахад байх ёстой хэмжээг тодорхойлно.

2.7 Агуулахын нөөцийн хэмжээг тогтоосны үндсэн дээр хангамжийн байдалд үнэлгээ өгч, тогтмол болон яаралтай захиалга үйлдэнэ.

2.8 Эм, хэрэгслийг сонгож, захиалга үйлдэхдээ тухайн эм, хэрэгслийг өрх, сум, багийн түвшинд хэрэглэж болох эсэх, эмч нарын эм, хэрэгслийн хэрэглээний талаархи мэдлэг, мэргэжлийн ур чадварын түвшин, эм, хэрэгслийг хэрэглэгчдийн тоо, эм, хэрэгслийн чанарын баталгаа, хэрэглэхэд тохиромжтой байдал, хүчинтэй хугацаа, тээвэрлэлтийн нөхцөл зэрэг үзүүлэлтийг харгалзана.

**Б. Аймаг, нийслэлийн дүүргийн түвшинд**

2.9 Аймаг, дүүргийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн ХУМТ-той холбогдсон бүхий л асуудлыг аймаг, дүүргийн НҮЭМ-ийн зохицуулагч хариуцна.

2.10 НҮЭМ-ийн зохицуулагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.10.1 Анхан шатны нэгжээс ирүүлсэн тайланг нэгтгэн, орон нутгийн эм, хэрэгслийн хэрэгцээг тооцон, **нэгдсэн захиалга** үйлдэж, захиалгын тоог интернетэд суурилсан Channel программд жил бүрийн 1 дүгээр сарын 5, 7 дугаар сарын 5-ны дотор оруулна. (Засгийн газар, НҮЭМ-ийн төсөл гэж ялгахгүй)

2.10.2 Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан хуваарьтай эм, хэрэгслийг хүлээн авч, нийслэл, аймгийн ЭМГ-ын даргын тушаалаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, нөхөн үржихүйн эрүүл мэндийн кабинетуудад хуваарилан хүргүүлж, хяналт тавина.

Өг

2.10.3 Жилд 2-оос доошгүй удаа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тасаг, кабинетаар явж, ХУМТ-ны үйл ажиллагааг шалгаж, үнэлгээ өгч, зааварчилна.

2.10.4 Бодит тооллогыг жилд 2 удаа холбогдох журмын дагуу зохион байгуулж, эм, хэрэгслийн хадгалалтыг хянах бөгөөд тооллогын дүнг цаашдын арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.

2.11 Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүдийн тасгийн эм хариуцсан бага эмч, эмнэлгийн эмийн сангийн эрхлэгч, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч, Монгол эмимпекс концерны агуулахын мэргэжилтэн нар орон нутгийн түвшний хангамж удирдлага мэдээллийн тогтолцооны үйл ажиллагаатай холбогдох анхан шатны бүртгэлийг хөтөлнө.

2.12 Аймаг, дүүргийн эмийн агуулахын мэргэжилтнүүд агуулахын бүртгэл, орлого ба зарлагын бүртгэл, эм, хэрэгслийн хөдөлгөөнт карт, тооллогын бүртгэл, эм, хэрэгслийн хүлээн авсан тухай акт зэрэг хадгалалтын болон харилцааны бүртгэлүүдийг хөтөлнө.

2.13 Аймгийн төвийн агуулахад орлого, зарлагын бүртгэлийг хөтлөхдөө интернетэд суурилсан Channel программыг ашиглана.

## **В. Үндэсний түвшинд**

2.14 Жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор орон нутгаас ирүүлсэн захиалгыг нэгтгэн, дүгнэж, тухайн жилд шаардлагатай НҮЭМ-ийн эм, хэрэгслийн улсын хэмжээний хэрэгцээг тооцон гаргана.

2.15 Улсын хэмжээний эм хэрэгслийн хэрэгцээг үндэслэн захиалга хийж, НҮБ-ын Хүн амын сан болон Засгийн газрын санхүүжилтээр авах асуудлыг шийдвэрлэнэ.

2.16 ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсээс гаргасан тооцоог үндэслэн холбогдох байгуулагуудад захиалгыг албан захидлын хамт хүргүүлж, ханган нийлүүлэх гэрээ байгуулна.

2.17 Захиалгаар нийлүүлэгдэх эм, хэрэгслийн талаархи мэдээллийг гэрээт байгууллагад мэдэгдэж, хяналт тавина.

2.18 Орон нутгийн захиалга, нийлүүлэгдсэн эм, хэрэгслийн тоо хэмжээг үндэслэн эм, хэрэгслийн хуваарийг боловсруулж, ЭМ-ийн сайдын тушаалаар баталгаажуулна.

2.19 Хуваарьт эм хэрэгсэл хэрэглэгчдэд хүрч байгаа үйл ажиллагаанд хяналт тавина.

2.20 НҮЭМ-ийн эм, хэрэгсэл худалдан авах санхүүжилтийг дараа жилийн улсын өсөвт суулгах асуудлыг хариуцна.



**Гурав. Эм, хэрэгслийг хүлээн авагч байгууллагад олгох ба тээвэрлэн хүргэх үйл ажиллагаа**

3.1 НҮБ-ын ХАС болон Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа эм, хэрэгслийг хүлээн авахдаа Эрүүл мэндийн сайдын 2011 оны 105 тоот тушаалаар батлагдсан “Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам”-ыг мөрдөнө.

3.2 Эм, хэрэгслийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилна.

3.3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг хадгалж, түгээх, тээвэрлэх үүргийг Эрүүл мэндийн яамтай стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан байгууллага /цаашид гэрээт байгууллага гэх/ гүйцэтгэнэ.

3.4 Гэрээт байгууллага тусламжийн болон Засгийн газрын санхүүжилтээр худалдан авсан эм, хэрэгслийг хил, гаалиас татан авч, өөрийн агуулахдаа зохих журмын дагуу хадгалж, чанарыг баталгаажуулна.

3.5 Гэрээт байгууллагын төлөөлөл, НҮБ-ын ХАС-ийн хангамж хариуцсан ажилтантай хамт эм, хэрэгслийг хүлээн авч эмийн цувралын дугаар, хугацаа, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээн авсан акт үйлдэнэ.

3.6 Эм, хэрэгслийг хуваарийн дагуу бэлтгэх, хаяглах, орон нутагт ачуулах, бүрэн бүтэн тээвэрлэн хүргэх, хүлээлгэн өгөх хүртэлх бүх асуудлыг гэрээт байгууллага хариуцна. Эм, хэрэгслийг ачих, тээвэрлэх ажилтнууд нь тухайн эм, хэрэгслийн шинж чанар, тээвэрлэх, хадгалах горимын талаар сургалтад хамрагдсан тодорхой мэдлэгтэй байна.

3.7 Хуваарийн дагуу эм, хэрэгслийн зарлагын баримт бичиж, баримтын дагуу тээврийн хэрэгсэлд ачиж, барааг нэг бүрчлэн тоолж, тээврийн хэрэгслийн жолооч буюу тухайн байгууллагын итгэмжлэгдсэн албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

3.8 Эм, хэрэгслийг захиалагч байгууллагад тээвэрлэн хүргэж, хүлээн авах комисс буюу эрх бүхий албан тушаалтанд бичиг баримтын дагуу тулган шалгаж хүлээлгэн өгөөд, хүлээлгэн өгсөн тухай акт бүрдүүлсэн байна.

**Дөрөв. Агуулахын үйл ажиллагаа**

4.1 НҮЭМ-ийн эм, хэрэгслийн хангамж хариуцсан байгууллагууд эм, хэрэгслийг хадгалахдаа Эм ханган нийлүүлэх байгууллагад тавигдах нийтлэг шаардлага MNS 5530: 2010, Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага “MNS 5260: 2011” Монгол улсын стандартыг мөрдөнө.

4.2 Агуулахын мэргэжилтнүүд эм, хэрэгслийг түрүүлж хүчинтэй байх хугацаа нь дуусахаас нь эхэлж гаргах (FEFO) эсвэл эхэлж ирснийг эхэлж гаргах (FIFO) зарчмыг баримтлан ажиллана.

4.3 Агуулахад гал унтраах төхөөрөмж, галын аюулгүй ажиллагааны дүрэм, галын аюулын үед ажиллах схем зааврыг байрлуулна.

4.4 Эм, хэрэгслийг хортон шавьж устгах хор, химийн бодис, хуучин бичиг баримт, бусад бараанаас тусад нь хадгална.

4.5 Гэмтэж муудсан, хагарсан, хүчинтэй хугацаа дууссан эм хэрэгслийг тусад нь хадгалж, зааврын дагуу устгах арга хэмжээг авна.

4.6 Эм, хэрэгслийн хэрэгцээнээс хамаарч агуулахын багтаамжийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч, агуулахын мэргэжилтэнтэй хамтран тооцно.

### **Тав. Хяналт**

5.1 ХУМТ-ны үйл явцад тавих хяналтыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн жигд хүртээмжтэй, тогтвортой хангамжийг бий болгоход чиглүүлнэ.

5.2 Эм, хэрэгсэл шинээр нийлүүлэгдэх бүрт эм бараа хүлээн авах комисс сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн шалгах ба агуулахын мэргэжилтэн эм хэрэгслийг түгээх бүртээ тэдгээрийг шалгаж олгоно.

5.3 Шалгалтын явцад тоо хэмжээ, чанар байдлын талаар илэрсэн зөрчлийг бүртгэж тэмдэглэнэ. Хэрэв шалгалтын явцад чанар байдал нь алдагдсан шинж тэмдэг илэрвэл уг бүтээгдэхүүнийг хэрэглэх буюу тараахыг хориглоно. Шаардлагатай гэж үзвэл дээжийг лабораторийн шинжилгээнд явуулна.

5.4 Гарсан зөрчлийн талаар чанарын мэргэжилтэн ба удирдлагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авна.

5.5 Шалгаж дууссаны дараа нэгж бүтээгдэхүүн бүрийг өөрийн нь хайрцагт буцаан хийж, шалгагдсан хайрцаг дээр он сар өдөр болон шалгасан гэсэн тэмдэглэгээ хийнэ.

5.6 Эм, хэрэгсэл нь хэд хэдэн цувралын дугаартай ирсэн тохиолдолд цуврал бүрээс дээж авах ба олон цувралын дугаартай бүтээгдэхүүнээс нэг цуврал чанарын шаардлага хангаагүй тохиолдолд бусад цувралуудыг шинжилгээнд хамруулна.

**АГУУЛАХЫН БҮРТГЭЛ №**

Эмийн нэр, тун, хэмжээ, хэлбэр: \_\_\_\_\_ Сарын дундаж хэрэглээ: \_\_\_\_\_  
Үйлдвэрлэгч: \_\_\_\_\_ дээд тоо хэмжээ: \_\_\_\_\_  
Цуврал: \_\_\_\_\_ доод тоо хэмжээ: \_\_\_\_\_  
Хэмжих нэгж: \_\_\_\_\_  
Нэгж үнэ: \_\_\_\_\_  
Эд хариуцагчийн код: \_\_\_\_\_

№	Он,сар, өдөр	Орлого / Зарлага		Тоо, хэмжээ				
		Баримт дугаар	Хаанаас/хэнд	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Тэмдэглэл

Бүртгэл хөтөлсөн мэргэжилтэн: \_\_\_\_\_  
Хянасан нягтлан бодогч: \_\_\_\_\_

492

**АГУУЛАХЫН ОРЛОГЫН БАРИМТ**

201 ..... оны ..... сарын ..... өдрөөс ..... – р сарын ..... –ны өдрийн баримт

Агуулахын № \_\_\_\_\_

Агуулахын нэр: \_\_\_\_\_

Эд хариуцагч: \_\_\_\_\_

№	Орлогын баримт	Хүлээн авсан огноо	Бэлтгэн нийлүүлэгчийн нэр	Дагалдах баримт	Бүгд дүн
№ ..... Агуулахын бүгд дүн					

Тайлан гаргасан эд хариуцагч: \_\_\_\_\_

Хянасан нягтлан бодогч: \_\_\_\_\_

**АГУУЛАХЫН ЗАРЛАГЫН БАРИМТ**

201 ..... оны ..... сарын ..... өдрөөс ..... – р сарын ..... –ны өдрийн баримт

Агуулахын № \_\_\_\_\_

Агуулахын нэр: \_\_\_\_\_

Эд хариуцагч: \_\_\_\_\_

№	Ачуулсан огноо	Хүлээн авагчийн нэр	Баримтын дугаар	Дагалдах баримт	Бүгд дүн
№ ..... Агуулахын бүгд дүн					

Тайлан гаргасан эд хариуцагч: \_\_\_\_\_

Хянасан нягтлан бодогч: \_\_\_\_\_

**ЭМ, ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ КАРТ**

Эм, хэрэгслийн нэр: \_\_\_\_\_ Тун хэмжээ, хэлбэр: \_\_\_\_\_

Цувралын №: \_\_\_\_\_ Савлалт: \_\_\_\_\_

Хүчинтэй хугацаа: \_\_\_\_\_

№	Огноо	Байгууллагын нэр	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Тэмдэглэл

Карт хөтөлсөн агуулахын мэргэжилтэн: \_\_\_\_\_

ЭМ ХЭРЭГСЛИЙН ТООЛЛОГЫН БҮРТГЭЛ

Агуулахын нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Агуулахын байршил: \_\_\_\_\_

Хөтөлбөрийн нэр: \_\_\_\_\_

201... он ... сар ... өдөр

№	Эм хэрэгслийн нэр, тун хэмжээ	Цуврал	Дуусах хугацаа	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Бүртгэлээр		Тооллогоор		Илүү		Дутуу		Тэмдэглэл
						Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	

Тооллогын комисс: /Гарын үсэг, албан тушаал/ \_\_\_\_\_

Эд хариуцагч: \_\_\_\_\_

ЭМ ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭН АВСАН АГТ

Бараа нийлүүлэгч: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Хүлээн авагч: \_\_\_\_\_

Барааг дагалдсан падааны дугаар: \_\_\_\_\_

№	Эм, барааны нэр, тун хэмжээ	Цуврал	Хэмжих нэгж	Ирвэл зохиx тоо	Ирсэн тоо	Үүнээс		Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Тэмдэглэл
						дутуу	илүү			

Эм барааг хүлээн авсан комисс:  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



ЭМ ХЭРЭГСЛИЙН ЗАРЛАГЫН БАРИМТ

Бэлтгэн нийлүүлэгчийн тоон тэмдэглэгээ: \_\_\_\_\_ Ачуулсан огноо: \_\_\_\_\_  
Бэлтгэн нийлүүлэгчийн нэр: \_\_\_\_\_ Агуулахын дугаар: \_\_\_\_\_  
Тээврийн хэрэгсэл: \_\_\_\_\_ Баримт үйлдсэн огноо: \_\_\_\_\_  
Эд хариуцагчийн нэр: \_\_\_\_\_ Хүлээн авагч: \_\_\_\_\_

№	Эм хэрэгслийн код	Эм, нэр, тун хэмжээ цуврал	Цуврал	Үйлдвэрлэгч улс	Дуусах хугацаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ	Бүгд үнэ

Хүлээн авсан комисс/гарын үсэг, албан тушаал/

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

**ЗАРЛАГЫН ТАЙЛАН БА ЗАХИАЛГА**

Аймаг, хот /Сум, дүүрэг/ \_\_\_\_\_ 201..... оны жилийн захиалга \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_ 201..... оны I, II жилийн тайлан \_\_\_\_\_

Захиалга өгсөн огноо: \_\_\_\_\_

№	Эм хэрэгслийн нэр, тун, хэмжээ	Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Хорогдол	Эцсийн үлдэгдэл	Захиалах тоо	Жинхэнэ олгосон тоо

№	ЖХХ-ийн нэр	Шинэ үйлчлүүлэгч	Давтан үйлчлүүлэгч	Хорогдлын тайлбар

Тайлан гаргасан хүний овог, нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

Эм барааг дагалдах хаяг

Хайрцагны дугаар: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Хүлээн авагчийн нэр: \_\_\_\_\_

Ханган нийлүүлэгчийн хаяг: \_\_\_\_\_

№	Эм, барааны нэр төрөл	Ачуулсан тоо	Тэмдэглэл

Бэлтгэгчийн нэр: \_\_\_\_\_

**НЭГТГЭЛИЙН МАЯГТ**

Аймаг / хотын нэр: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

201 ... оны ЖХХ-ийн захиалгын нэгтгэл: \_\_\_\_\_ Хянасан: \_\_\_\_\_  
Аймгийн ЭМГ-ын дарга: \_\_\_\_\_  
/Гарын үсэг, тамга/

№	Эм, хэрэгслийн нэр, тун хэмжээ	Хэмжих нэг	Нэгж үнэ	НҮЭМ кабинет	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Сум					Нийт ширхэг тоо	Бүгд үнэ

Захиалга нэгтгэсэн: \_\_\_\_\_  
НҮЭМ-ийн зохицуулагч: \_\_\_\_\_  
ЭХК-ы мэргэжилтэн: \_\_\_\_\_

**ЖИРЭМСЛЭХЭЭС ХАМГААЛАХ ЭМ, ХЭРЭГСЭЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮРТГЭЛ**

Хот/ дүүрэг/ өрх: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Аймаг/ сум/ баг: \_\_\_\_\_

Үйлчилгээ үзүүлэгчийн нэр: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Хянасан: \_\_\_\_\_

№	Овог нэр	Нас	Боловсрол	Хаяг	Регистр №	Хэрэглэгч		Эм	Тариа		Еренд өг	Постинор			Бэлгэвч						ЖХХ-ийн төрлийг сольсон шалтгаан					
						Анх	Давт		Улирал	Улирал		1	2	3	1	2	3	4	5	6						
								Улирал I II III I I V	Улирал I II III I I V																	
							Тоо																			
							Огноо																			
							Гарын үсэг																			
							Тоо																			
							Огноо																			
							Гарын үсэг																			
							Тоо																			
							Огноо																			
							Гарын үсэг																			

НҮБ-ын Хүн амын сангаас үнэ төлбөргүй тараах жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй олгосон тохиолдолд энэ бүртгэлийг хөтөлнө. Хэрэглэгчийн нэрийг нууцлах шаардлагатай гэж үзвэл овог, нэрийн оронд карт, даатгалын дэвтэр, регистрийн дугаар бичиж болно. Сар бүрийн сүүлийн өдөр тухайн сарын бүртгэлийг хааж, сарын хэрэглээг гаргана. Тухайн эмнэлгийн эрхлэгч буюу тасгийн эрхлэгч хяналтыг тавьна.

188

**НҮЭМ-ИЙН НЭН ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БҮРТГЭЛ**

Эмийн нэр, тун, хэмжээ: \_\_\_\_\_  
Үйлдвэрлэгч: \_\_\_\_\_  
Цуврал: \_\_\_\_\_  
Хэмжих нэгж: \_\_\_\_\_  
Нэгж үнэ: \_\_\_\_\_

Үйлчилгээ үзүүлэгчийн нэр: \_\_\_\_\_  
Байгууллагын нэр: \_\_\_\_\_  
Хот/дүүрэг/өрх: \_\_\_\_\_  
Аймаг/сум/баг: \_\_\_\_\_  
Эмийн хүчинтэй хугацаа: \_\_\_\_\_

№	Огноо	Овог нэр	Нас	Боловсрол	Регистр №	Карт, өвчний түүх №	Тоо ширхэг	Хүлээж авсан хүний гарын үсэг

НҮБ-ын Хүн амын сангаас үнэ төлбөргүй тараах жирэмслэхээс хамгаалах эм, хэрэгслийг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй олгосон тохиолдолд энэ бүртгэлийг хөтөлнө. Хэрэглэгчийн нэрийг нууцлах шаардлагатай гэж үзвэл овог, нэрийн оронд карт, даатгалын дэвтэр, регистрийн дугаар бичиж болно

183

**ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮЖИЛТЭЭР НИЙЛҮҮЛЭГДЭЖ  
БАЙГАА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭМ,  
ХЭРЭГСЛИЙГ НИЙГМИЙН ЭМЗЭГ ДАВХАРГЫН  
ИРГЭДЭД ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас санхүүжүүлж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд үнэ төлбөргүй олгох үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд хийж гүйцэтгэнэ.

**Хоёр. Үндэсний түвшинд эм, хэрэгслийг захиалах,  
хүлээн авах, хадгалах, түгээх**

2.1. Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хэрэгцээг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас орлогыг орлуулан тооцох аргаар тогтоосон ядуу болон малчин, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдийн судалгааг үндэслэн гаргана.

2.3. “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийн аюулгүй байдал, тогтвортой хангамж” үндэсний стратегийн хүрээнд Засгийн газраас санхүүжүүлж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Эрүүл мэндийн яамны тухайн жилийн төсөвт тусгаж, батлуулна.

2.4. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг худалдан авах ажиллагааг Эрүүл мэндийн яамнаас хуулийн хүрээнд зохион байгуулж, хуваарийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батална.

2.5. Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг ханган нийлүүлэгчид хүргүүлэхдээ гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвар, эм, хэрэгслийн чанарын баталгаажилт хийлгэх төлбөрийг тооцоолон зардалд тусгасан байна.

185

2.6 Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг, орон нутагт тээвэрлэн хүргэх асуудлыг Эрүүл мэндийн яамтай стратеги түншлэлийн гэрээ байгуулсан эм ханган нийлүүлэх байгууллагаар гүйцэтгүүлнэ.

### **Гурав. Орон нутгийн түвшинд эм, хэрэгслийг захиалах, хүлээн авах, хадгалах, түгээх**

3.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч нь тухайн сум, хорооны ядуу, өрх толгойлсон, олон хүүхэдтэй, нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг эмэгтэйчүүдэд шаардагдах жирэмлэхээс сэргийлэх эм хэрэгслийн хэрэгцээг тооцож, захиалгыг ЭМГ-т 7 дугаар сарын 5, 12 дугаар сарын 15 –ны дотор хүргүүлнэ.

3.2. Аймаг, нийслэлийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагч нар орон нутгийн түвшинд эм, хэрэгслийн нэгдсэн захиалгыг жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор боловсруулж, Channel программд оруулсан байна. (Засгийн газар, НҮЭМ-ийн төсөл гэж ялгахгүй)

3.3. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу орон нутагт нийлүүлэгдсэн эм, хэрэгслийг Эм бараа хүлээн авах комисс хүлээн авна.

3.4. Орон нутагт эм, хэрэгслийг нэгж, салбаруудад хуваарилах, хадгалах, түгээх, мэдээлэх, сурталчлах болон ядуу, малчин, өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүд, нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд хүргэх, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар зохион байгуулна.

3.5. Хүлээн авсан эм, хэрэгслийг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт хуваарилах асуудлыг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

3.6. ЭМГ-ын даргын тушаалаар хуваарилсан эм, хэрэгслийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, эмийн эргэлтийн сангийн эрхлэгч эсвэл эх баригч бага эмч зэрэг итгэмжлэгдсэн төлөөлөгч баримтын дагуу нэгбүрчлэн тоолон хүлээж авна.

3.7. Эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгох ажлыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн кабинетийн эмч, сувилагч нар гардан гүйцэтгэнэ.

3.8. Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд үнэ төлбөргүй олгоно.

3.9. Нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгосон эм, хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, улирал, жилээр дүнг нэгтгэнэ.

3.10. Нийгмийн эмзэг давхаргад хамрагддаг иргэдэд олгосон эм, хэрэгслийн анхан шатны бүртгэл нь НҮБ-ын ХАС-гаар нийлүүлэгдсэн жирэмслэхээс хамгаалах эм



хэрэгслийн бүртгэлтэй ижил байх бөгөөд Засгийн газрын санхүүжилтээр олгож байгааг тодотгосон байна.

3.11. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газраас эм, хэрэгслийн зарцуулалтын тайланг тухайн жилийн 7 дугаар сарын 5, 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж, ЭМЯ-ны Эм эмнэлгийн хэрэгслийн хэлтэст мэдээлж байна.

**Дөрөв. Зарцуулалтад хяналт тавих**

4.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт эм, хэрэгслийг хадгалах, түгээх, бүртгэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар мэргэжлийн удирдлагаар хангана.

4.2 Орон нутагт Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн зарцуулалтад аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар хяналт тавина.

4.3. ЭМЯ-ны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар нь хуваарилагдсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн орон нутгийн хуваарилалт, түгээлт, зарцуулалт, хэрэглээнд хяналт, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлд танилцуулна.

4.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс нь мэдээ, судалгаа, үнэлгээ, тайлангийн дүнд тулгуурлан НҮЭМ-ийн эм хэрэгслийн хангамжийн талаархи бодлогын чанартай асуудлыг боловсруулах, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газрыг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.